ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЯЛТАНД ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ЭРХ ЗҮЙН МӨН ЧАНАР (ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ)



НАВААНЫ ГАНТУЛГА
ШШГС-ийн захирал, доктор, дэд профессор, хурандаа

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн... эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох..."[1] хэмээн тусгагдсан бөгөөд энэ хүрээнд эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг олон хууль, хууль тогтоомжийн бусад актыг шинэчлэх бэлтгэл ажил эрчимтэй явагдаж байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийг шинэчлэх үзэл санааны хүрээнд хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны институт болох ялтанд олгох урамшууллын асуудлыг өнөөдөр мөрдөж буй үндэсний болоод ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн хуулийн хүрээнд харьцуулан судалж судлаачийн дүгнэлт, саналыг илэрхийлэхээр зорилоо.

Хорих ялын зорилтыг хангахад хорих байгууллагын зүгээс ялтны сайн үйлийг сайшаан, тэдний хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлэх, засран хүмүүжих сонирхлыг хөхүүлэн дэмжих явдал онцгой ач холбогдолтой.

Харьцуулалт нь харьцуулагч зүйлүүдийн нийтлэг ба ижил төстэй, ялгаатай ба онцлог талуудыг нээн илрүүлж зүй тогтол, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан дүгнэлт, санал боловсруулах бололцоо олгодог тул энэхүү бичил судалгаанд дээрхи аргыг ашигласан болно.

[1] Монгол Улсын Их хурлын 2012 оны 09-р сарын 18-ны 37-р тогтоолын хавсралт //Төрийн мэдээлэл. УБ 2012. №36/753/ х.2242

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2002 он) хуулиас	ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай (1997 он) хуулиас
126 дугаар зүйл. Ялтныг урамшуулах 126.1. Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна. 126.1.1. хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх; 126.1.2. урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах; 126.1.3. энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.	*113-р зүйл.* Хорих ял эдлэж буй ялтанд олгох урамшууллын арга хэмжээ 1.Сахилгабаттай,хөдөлмөр,сургалтадүнэнчээрханддаг, ялтны сайн дурын байгууллагын ажил болон хүмүүжлийн арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцож буй хорих ял эдэлж буй ялтнуудадурамшууллындараахаргахэмжээгавчболно. а/ талархал б/ бэлгээр шагнах в/ мөнгөн шагнал г/ нэмэлт илгээмж эсвэл гүйвуулга авахыг зөвшөөрөх д/ хүчингүй болсон[1] (2003.12.08-ны өдрийн Холбооны хуулиар №161) е/ түр эсвэл удаан хугацааны уулзалт авах эрх олгох ж/ хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахад нь зориулан 500 хүртэл рублийг нэмж зарцуулахыг зөвшөөрөх з/ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони[2] чанга дэглэмтэй нөхцөлд болон гянданд ял эдлэж буй ялтны гадаалах хугацааг нэг хүртэл сарын хугацаанд өдөрт 2 хүртэл цагаар уртасгах и/ урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах 2. Колони-тосгонд ял эдлэж буй ялтанд урамшууллын арга хэмжээний хувьнар амралтын болон баярын өдрүүдийг колони-тосгоны гадна өнгөрүүлэх явдлыг зөвшөөрч болно. 3. Хүчингүй болсон[3] -(2010.04.05-ны өдрийн Холбооны хуулиар №46 4. Эерэгээр тодорхойлогдож буй ялтны цаашдын засрал хүмүүжлийн зорилгод нь нийцүүлэн ялын хугацааны хуульд заасан хэсгийг бодитойгоор эдэлсэн тохиолдолд хөнгөн ялаар сольж болно. *114-р зүйл.* Хорих ял эдлэж буй ялтанд урамшууллын арга хэмжээ хэрэглэх журам 1. Талархалыг амаар эсвэл бичгийн хэлбэрээр, бусад урамшууллыг зовхон бичгийн хэлбэрээр зарлан олгоно. 2. Урамшууллын журмаар нэг жилийн турш нэмж 4 хүртэл илгээмж эсвэл гүйвуулга авах, 4 хүртэл түр эсвэл удаан хугацааны уулзалт хийхийг зөвшөөрч болно. 3. Энэ хуулийн 115-р зүйлийн 1 дэх хэсгийн "а", "б", 136-р зүйлийн "а", "б"-д заасан шийтгэлийгногдуулснаас хойш 3-аас багагүй сар, 115-р зүйлийн 1 дэх хэсгийн "г", "д", "е" хэсэгт заасан шийтгэлийг эдэлсэн өдрөөс 6-аас доошгүй сар өнгөрснөөс өмнө ногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгахыг зөвшөөрнө. 4. Арилгагдаагүй эсвэл төлж дуусаагүй шийтгэлтэй ялтанд урамшууллыг зөвхөн урьд ногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах хэлбэрээр хэрэглэнэ.

[1] Телефон утсаар ярих хугацааг нь нэмэгдүүлэх

[2] Цаашид "ЗХХК" гэх

[3] Сахилга баттай ялтанд тэрчлэн энэ хуулийн 78-р зүйлийн 78.2, 87-р зүйлд заасан арга хэмжээг авч болно. (энэ нь дэглэм бууруулах явдал юм. Зохиогч)

	119-р зүйл. Хорих ял эдэлж буй ялтанд урамшууллын ба шийтгэлийн арга хэмжээ авах ЗХХ-ийн байгууллагын албан тушаалтнууд 1. ЗХХБ-ын дарга эсвэл тэдгээрийг орлож буй этгээд энэ хуулийн 113, 115-р зүйлд заасан урамшуулал, сахилгын арга хэмжээг хэрэглэх эрхийг бүрэн хэмжээгээр эдлэнэ. 2. Отрядын дарга нар урамшууллын дараах арга хэмжээг авах эрхтэй: а/ Талархал б/ хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахыг зөвшөөрөх в/ Отрядын даргаас урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах. 3. Отрядын дарга нар амаар сануулах арга хэмжээ авах эрхтэй. *134-р зүйл.* Хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй ялтанд олгох урамшууллын арга хэмжээ 1. Сахилга баттай, хөдөлмөр, сургалтад үнэнчээр ханддаг ялтны сайн дурын байгууллагын ажил болон хүмүүжлийн арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцдог насанд хүрээгүй ялтнуудад энэ хуулийн 113-р зүйлд зааснаас гадна дараах урамшууллын арга хэмжээг хэрэглэж болно. а/ тухайн колоний ажилтнуудын хамт хүмүүжлийн колоний гаднах соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээг үзэх эрх олгох б/ эцэг эх тэднийг орлох хүмүүсийн эсвэл бусад ойрын төрөл садангийн хамтаар хүмүүжлийн колониос гадагшаа гаргах эрх олгох в/ хүчингүй болсон[4]. (2005.04.01-ний Холбооны хуулиар №29) г/ ял эдлэх чанга нөхцлөөс ердийн нөхцөл рүү хугацааны өмнө шилжүүлэх 135-р зүйл: Хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй ялтнуудад урамшууллын арга хэмжээ хэрэглэх онцлог 1.Колоний ажилтнуудын хамт хүмүүжлийн колоний гадна гарч соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээ үзэх, эцэг эх, тэднийг орлох хүмүүсийн эсвэл ойрын төрөл садангийн хамтаар хүмүүжлийн колониос гадагшаа гарах эрхийг урамшууллын хэлбэрээр эдлэж буй ялтанд өөрсдийнх нь иргэний хувцсыг олгоно. 2. Шөнийн цагаар явагдах соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээг үзэх явдлыг зөвшөөрөхгүй. 3. Хүмүүжлийн колониос гадагшаа гарах хугацааг тухайн колоний дарга тогтоох ба 8 цагаас хэтэрч болохгүй. 4. Ял эдлэх чанга (хатуу) нөхцлөөс ердийн нөхцөлд урамшууллын журмаар хугацааны өмнө шилжих явдлыг энэ хуулийн 114-р зүйлийн 4 дэх хэсгээр тогтоосон шаардлагуудыг сахиж чанга нөхцөлд 3 сараас доошгүй сар ялаа эдэлсний дараа зөвшөөрнө. *138-р зүйл.* Ялтанд урамшууллын ба шийтгэлийн арга хэмжээ авах хүмүүжлийн колоний албан тушаалтнууд 1. Хүмүүжлийн колоний дарга болон тэдгээрийг орлож буй этгээд урамшуулал, сахилгын арга хэмжээг хэрэглэх эрхийг бүрэн хэмжээгээр эдлэнэ. 2. Отрядын дарга нар урамшууллын дараах арга хэмжээг авах эрхтэй: а/ Талархал б/ Хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахыг зөвшөөрөх в/ Хүчингүй болсон[5]. (2007.12.01-ний Холбооны хуулиар №299) г/ Отрядын даргаас урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах. 3. Тасгийн хүмүүжүүлэгчид урамшууллын дараах арга хэмжээ авах эрхтэй. а/ талархал б/ тасгийн хүмүүжүүлэгчээс урьд ногдуулсан шийтгэлийг хугацааны өмнө арилгах 4. Отрядын дарга нар шийтгэлийн дараах арга хэмжээг авах эрхтэй. а/ сануулах б/ нэг сарын турш уран сайхны кино үзэх эрхийг нь хасах 5. Тасгийн хүмүүжүүлэгчид сануулах арга хэмжээ авах эрхтэй.

[4] Сахилгын тусгаарлах байрнаас хугацаанаас нь өмнө гаргах

[5] Телефон утсаар ярих нэмэлт эрх олгох

Энэхүү харьцуулалтаас үзвэл манай хоёр орны хууль тогтоомжийн хувьд дараах нийтлэг зохицуулалт байна. Үүнд:

1. Хорих ял эдэлж буй ялтанд олгох урамшууллын төрөл, хэмжээг төрөлжсөн хуулийн тодорхой зүйлийн хүрээнд хуульчилжээ.

2. Урьд ногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах явдлыг урамшууллын арга хэмжээний төрөл болгосон.

Ялгаатай зохицуулалтын хувьд:

1. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126-р зүйлээс үзвэл: "Хорих ангийн дэг журмыг чанд сахих, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа нөхцөлд ялтныг урамшуулах"-аар заажээ. Түүнчлэн ХЗДХ сайдын (хуучнаар) 2008 оны 50 дугаар тушаалаар батлагдсан "Хорих ангийн дотоод журам"-д: "Хорих ангиас зохион байгуулж буй ажилд идэвхитэй оролцож, зарласан болзлыг бүрэн хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг чанд сахиж, мэдлэг боловсролоо бие даан дээшлүүлсэн, шинэ санаачлага гаргаж хэрэгжүүлсэн[2]" гэсэн хоёр нөхцлийг нэмж урамшуулах үндэслэл болгон хуулийн зохицуулалтыг өргөжүүлсэн байна.

2. Манай орны хувьд урамшууллын нийтлэг арга хэмжээг 3 төрлөөр заасан бол ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн хуульд нийтлэг 7 төрлөөр, мөн чанга дэглэмтэй нөхцөлд болон гянданд, түүнчлэн колони-тосгон, хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй насанд хүрээгүй ялтанд олгох урамшууллын онцлог хэлбэрийг тусад нь хуульчилж өгчээ.

3. Манай улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтны урамшууллыг хорих ангийн даргын шийдвэрээр тушаал гаргаж олгохоор тусгасан бол ОХУ-ын хувьд урамшууллын бүх хэлбэрийг ЗХХБ-ын дарга олгохын зэрэгцээ отрядын дарга талархал, хүнсний болон нэн шаардлагатай эд зүйлсийг нэмж худалдан авахыг зөвшөөрөх болон отрядын дарга[3], тасгийн хүмүүжүүлэгчийн[4] урьд ногдуулсан шийтгэлийг хугацаанаас өмнө арилгах эрхтэй байхаар хуульчилжээ.

[2] Журмын 21-р хэсэг. Ялтныг урамшуулах тухай

[3] ОХУ-ын 119-р зүйл, 2 дахь хэсэг

[4] 138-р зүйлийн 3 дахь хэсэг

4. ОХУ-ын хувьд хорих ял эдэлж буй ялтанд урамшууллын арга хэмжээг хэрэглэх журмыг[5] Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон бол Монгол улсын хувьд сайдын тушаалаар журамласны зэрэгцээ асуудлыг шаардлагын түвшинд хүртэл нарийвчлан зохицуулаагүй байна.

Харин Монгол улсын хувьд онцолбол зохих нэгэн дэвшилттэй зохицуулалт бол "шагналын хоног" олгох явдал байгаа боловч цаашид уг харилцааны нарийвчилсан журмыг даргын эрх хэмжээнээс[6] хуулийн түвшинд гаргах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Хорих ялын эцсийн зорилго болсон нийгмийг хамгаалах, нийгэмд аюултай гэмт хэргүүдийг арилгах, урьдчилан сэргийлэх явдлыг хангахын тулд ялтан этгээдийг нийгмийн амьдрал, хуульд хүндэтгэлтэй хандан, өөрийн амьдралаа авч явах дадал хэвшилд аажмаар төлөвшүүлэх гэсэн хүн төрөлхтний нийтлэг хүсэл тэмүүлэл, хөгжлийн чиг хандлагыг иш үндэс болгон манай улсын хуулиар тогтоосон ялтны урамшууллын тогтолцоог өөрчлөх цаг болсон гэж үзлээ.

Тодруулбал: Урамшууллын арга хэмжээг ял эдэлж буй нөхцөл дэглэмтэй, ялтны насны онцлогтой нь уялдуулан ялгамжтай байдлаар олгох боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нийгэмшүүлэх, иргэний амьдралтай хөл зэрэгцэн алхах чиглэлд түлхүү хандуулбал зохино. Тухайлбал: Хорих ангийн байрлалаас гадагш явах, түр болон удаан хугацааны уулзалт хийх, үзвэр-үйлчилгээ, соёл, спортын арга хэмжээг үзэх, оролцох боломжийг олгох, нэмэгдүүлэх зэрэг эрх зүйн орчинг бий болгож болох юм. Мөн урамшуулал олгох албан тушаалтнуудын хүрээг өргөтгөх шаардлагатай.

[5] 114-р зүйл

[6] ШШГЕГ-ын даргын 2010 оны А/73 дугаар тушаал "Ялтанд шагналын хоног олгох, тэнсэн суллах, ялыг дэглэмийг өөрчлөхөд мөрдөх журам"

ХОРИХ АНГИД ЯЛТНЫГ ХӨДӨЛМӨРӨӨР ХҮМҮҮЖҮҮЛЭХ НЬ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ГОЛ ХЭЛБЭР



С.БАТСАЙХАН
ШШГЕГ-ын ТТГ-ын сургалт,
хүмүүжлийн хэлтсийн дарга, дэд хурандаа

Өнөөгийн нийгэмд хүн болгон айл өрх бүр тодорхой хөдөлмөр эрхэлж байж эдийн засгийн гол үзүүлэлт болох хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, орлоготой байх боломж бүрдэнэ. Үүний тулд төр засаг аливаа нэг хэлбэрээр ажлын байрыг бие болгохын сацуу улс орны бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд чухал ахиц гарах нь тодорхой.

Хүн өөрөө байгалийн бүтээгдэхүүн мөн боловч хувьсан өөрчлөгдөж буй орчин цагтай хөл нийлүүлэн алхах нь дамжиггүй юм.

Иймд бидний дундаас Эрүүгийн хуулийн тодорхой нийгэмд аюултай, эс аюултай үйлдлийг хийж бусдад ямарваа нэгэн хэлбэрээр эд материалын болон сэтгэл санааны хохирлыг их, бага хэмжээгэр учруулж, үүний улмаас Үндсэн хуульд заасан заяамал эрхээс бусад тодорхой эрхүүдийг хязгаарлаж, төрийн хуулийн дор суугаа этгээдийн талаарх анхаарах зарим асуудлуудыг авч үзэх нь зүйтэй болов уу. Тухайлбал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчийн хувьд шийтгэх тогтоол гарсан бол "ялтан" гэж нэрлэж байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь хэсэгт зааснаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн" болохыг заасан. Энэхүү хоёр харилцааг зохицуулж байгаа гол агуулга нь төрийн үндсэн зорилтод чиг үүргийг хэрэгжүүлж гэмт этгээдийг дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийтээс буюу олон нийтээс тодорхой хугацаагаар хязгаарлах явдал юм.

Тухайн ялтныг хорьж цагдсанаар гэмт үйлдлийг ойлгуулах, нийгмийн хор уршиг аюулыг бүрэн гүйцэт таниулах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэх баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байна. Өнөөгийн нийгэм дэх бодит байдал дээр энгийн буюу эрх чөлөөт иргэдээс авахуулаад нийгмийн тодорхой хэсэг, бүлэг хүмүүст ажлын байр олдохгүй, олдсон ч тухайн ажлын байранд ажлын дадлага туршлага, нас, мэргэжил, боловсрол зэрэг наад захын шалгуур үзүүлэлтийг тавьж, үүнийг хангах шаардлага гарч байна. Энэ нь зах зээлийн бичигдээгүй хуулийн дагуу тавьж буй тодорхой хэрэгцээнд тулгуурласан ойлголт билээ.

Бид "Социалист" нийгмээс салж одоогийн энэхүү "Ардчилсан" нийгэм рүү шилжээд даруй 20 гаруй жилийг үзэж иргэн бүр чөлөөтэй хэлж ярих, хэвлэн нийтлэх, дэлхийн бусад аль ч орон руу зорчих, бусдын үгийг үл тоох, уламжлалт зан үйлээсээ татгалзах зэргээр өөрсдийгөө хэт өндөр "ёс суртахуунт хүмүүн" болсон мэтээр ойлгож, бүгдийг чөлөөт нийгмийн энгийн үзэгдэл зэргээр хандаж байгаа нь илэрхий болсон байна. Тэгэхдээ зарим "сөрөг" тогтолцоог бие болгохдоо бид нийгмийн чухал хэсгийг бүрдүүлэгч "хүн"-ээ мартаж бодит бус, хийсвэр орчин нөхцлийг тэргүүн эгнээнд тавьснаар нийгмийг хөдөлгөгч "ард иргэдээ" сул орхисон тохиолдол бий. Ардчилсан нийгмийн гол лоозон бол иргэн бүр эрх чөлөөтэй, эд хөрөнгөтэй байхыг тунхагладаг.

Гэхдээ нийгмийг зангидагч төр, засаг иргэдээ ажилтай, орлоготой, ажлын байрыг бие болгох зорилт тавин жилд дунджаар тогтмол болон түр ажлын байраар .....иргэдийг хангасан тоон үзүүлэлт харагдаж байна. Төрийн нуруунаас тодорхой ачааны хүндийг үүрч байгаа хувийн хэвшлийн байгууллагад цалин хөлсний хэмжээ, олсон орлогоос төлөх татвар, ажиллах хүч ажиллууласны нийгмийн даатгалын шимтгэл, төрийн захиргааны байгууллагын элдэв хяналт шалгалт зохих зөвшөөрөл зэрэг хууль болон хууль бус дарамт шахалтнаас хамаарч ажлын байр хангалттай бие болох нөхцөл хомс байгаа нь илүү ихээр анзаарагдаж байна.

Мөн хувь хүний өөрийн мөн чанар, ажилд хандах хандлага, өөртөө тавьсан зорилго, хэтийн төлөвлөлт, гэр бүлийн орчин, найз нөхдийн хамаарал, ажил олгогчоос олгож буй цалин хөлс зэрэг нь хангалтгүй сөрөг нөлөөлөл үзүүлж байна гэж үзэж болох юм. Энэ бүхэн гэмт хэрэг үйлдэх шалтгаан

нөхцөл болж нэг хэсгийг нь хохироох, нөгөө хэсгийг нь ялтан хэмээх нэрийн дор ял эдлүүлж байна. Үүнээс гадна нийгмийн олон хүчин зүйлс нөлөөлж байгаа төдийгүй энэ бүгдийг тодорхой аргаар үр дүнтэй бодитой шийдэх цаг нь болсон. Төрийн онцгой чиг үүрэг бүхий хорих байгууллагад хоригдож байгаа ялтны тоо жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай боловч тэнд хоригдож буй ялтан мэргэжил, боловсролын түвшингээрээ доогуур үзүүлэлт байна .

Үүний тод жишээ нь сүүлийн 3 жилийн байдлаар 2010 онд 5899 ялтан, 2011 онд 6530 ялтан, 2012 оны 9 дүгээр сарын байдлаар 6767 ялтан хоригдож зохих ялаа эдлэж байна

Мөн насжилтаар нь харуулбал дийлэнх нь буюу 18-34 насныхан 50, 2 хувийг өсвөр насны залуучууд эзэлж байна.



	18-24	25-34	35-44	45-54	55-64
■2009	914	2163	1383	542	52
■2012	1560	2351	1524	652	83

Мөн боловсролын түвшингээр нь харуулбал дийлэнх нь буюу бүрэн бус дунд боловсролтой 36 хувийг эзэлж байна. Түүнчлэн бүрэн боловсролтой 1765 буюу 27.4 хувь эзэлж байгаа нь ерөнхий боловсрол, түүнээс доош түвшний боловсролтой нь нийт хоригдогсдын 91,2 хувийг эзэлж байна.



Эрүүл мэндийн байдлаас авч үзвэл:

Нийт хоригдогсдын 77,9 хувь нь эрүүл буюу ямар нэгэн өвчингүй байгаа бол 21,6 хувь ямар нэгэн байдлаар эмнэлэгийн тусламж үйлчилгээ авдаг, эмчийн хяналтанд байгаа нь харагдаж байна.



Дээрх тоон үзүүлэлтийг харж буй та Монгол улс шоронжсон бөгөөд ял эдлэгсэд нь насны хувьд залуужсан, боловсролын түвшин доогуур байгаа нь харагдана. Үүний цаана эдийн засгийн гол үзүүлэлт болох цалин хөлс, хоол хүнс, хувцас хэрэглэл, байр савны багтаамж, түүний ахуйн хэрэглээ, дагалдах зардал, харж хамгаалах хүн хүчний тооцоо гэх мэт олон цифртэй

тоогоор гарах мөнгөн дүн шаардлагатай болно. Гэхдээ төрийн ажлыг хүнд, хөнгөн амар хялбар гэлтгүй өдөр шөнийн аль ч цагт үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид хэзээ ч нуруу нь бөхийлгүй, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж биелүүлсээр ирсэнг дурьдах нь зүйтэй.

Ер нь бол хөдөлмөрөөр хүнийг төлөвшүүлнэ гэдэгтэй санал нэг байна. Иймд хорих ангид ял эдлэж буй ялтан этгээдийг зүгээр суулгаж тэжээх нь гол биш өнөөгийн нийгмийн тавьж байгаа зорилтод нийцүүлэн хөдөлмөрлүүлэх нь оновчтой, нөгөө талдаа төрийн албадлагын нэг хэлбэр хэрэгжиж байх ёстой.

Зүгээр суухаар зүлгэж суу гэдэгтэй адил өдөр хоногийг хий дэмий өнгөрүүлж хорвоогийн тоосыг хөдөлгөх нь тийм таатай явдал биш. Иймд тодорхой төрлийн ялаар хоригдож байгаа ялтныг хорих анги болон удирдах дээд байгууллага, хяналт тавих эрх бүхий прокурор, орон нутгийн засаг захиргааны төв байгууллага, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог эрс нэмэгдүүлж "нийгмийн хариуцлагын" асуудлыг тодорхой түвшинд гаргах нь зүй зохистой.

Ялтан этгээдийг ажлын байраар хангаснаар цалин хөлстэй болох, нийгэм ард иргэдэд учруулсан хохирол төлбөрийг барагдуулах ,өөрсдийн ахуй хэрэгцээнд ашиглах, ар гэртээ мөнгөн тусламж үзүүлэх, цаашилбал суллагдаад гарах үед тодорхой мөнгөн хуримтлал үүсгэх чухал ач холбогдолтой байгаа нь харагдаж байна. Хуучин социализмын үед ч гэсэн төвлөрсөн хорих ангид ял эдлээд гарсан ялтан орох оронтой, унах унаатай гарч байсан түүх олон бий.

Ялтанг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус хэлбэрээр ажлын байраар хангаж ажилтай болгосноор хөдөлмөрт суралцах, мэргэжил эзэмших, бусадтай харьцах хандлагыг үүсгэх, сэтгэл зүйн болон нийгмийн орчинд дасан зохицох, өөрсдийн ур чадварыг дээшлүүлэх, бусаддаа зааж сургах, тэдний харилцаа төлөвшихөд ихээхэн нөлөөлөл үзүүлэх гол хэлбэр гэдгийг онцлон тэмдэглэе.

Үүний тулд тухайн ялтанг хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч нар цогц судалгаа явуулж, мэргэжил, боловсрол, ажил хийх чадвар, сэтгэл зүйн онцлог, бусдын дунд бие авч яваа байдал, өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэргийг нарийн тооцож хөдөлмөрт хуваарилах, ажлын байрыг бие

болгох, түүнд дасан зохицох хугацаа зэргийг харгалзаж байх нь үр дүнтэй болно .

Хуулийн дагуу хичнээн албадлагын арга хэмжээг хэрэглэж байгаа боловч эрсдлийг өөрсдөө хүлээн авч сөрөг уур амьсгал бие болгох нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Жишээ нь : Хорих ангиудад гардаг нийтлэг зөрчил бол хүнээ зөв судлаагүйгээс болж ажлын байран дээрх хөдөлмөр хамгаалал зөрчигдөх, оргох, бусдыг үл ойшоон харьцаж зөрчил гаргах, ажлын бүтээмж муудах зэргээр илэрдэг.

Түүнчлэн хорих ангиуд “Нээлттэй, хаалттай хорих ангийн төрөл, дэглэм“-д шилжиж байгаатай уялдуулан эртнээс ялтны ялын байдлыг харгалзан мэргэжил боловсролтой болгох, ажлын дадлага чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулах, шинээр ажлын байр үйлдвэрлэлийг эхлүүлэх бололцоот тохиолдолд гаднаас хөрөнгө оруулагч нарыг дэмжих, тодорхой хугацааны дараа тухайн тоног төхөөрөмж үйлдвэрийг өөрийн болгох, улс орны томоохон бүтээн байгуулалтын ажилд идэвхилэн оролцох /барилга, зам, хөдөө аж ахуй, газар тариалан, түүхий эдийн боловсруулалт, техник тоног төхөөрөмжийн жижиг эд ангийн угсралт гэх мэт/ зэргээр бэлтгэл ажлыг хангах хэрэгцээ зайлшгүй урган гарч байна.

Энэ бүхэн нийгэм эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд бие хүн болох ялтны эрх ашигт эерэгээр нөлөөлж нийгэмшүүлэхэд үр дүнгээ өгөх нь зайлшгүй .

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЯЛЫН ТОГТОЛЦОО ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ



П.ГАНТӨМӨР
ХСИС-ийн ШШГС-ийн ШШГЭЗ-н
тэнхимийн эрхлэгч, хошууч

Дэлхийн улс орнуудын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт нь өөрийн үүсэл хөгжлийн түүхэн үе шатыг нэгэнт өнгөрөөж, одоо улам боловсронгуй болох чиг хандлага руугаа явж байна.

Дэлхий нийтийн жишиг хандлагыг харсан ч Монгол улсынхаа түүхэн уламжлалыг харахад ч төрийн бодлого, тухайн нийгмийн хөгжил, эрэлт шаардлагаасаа хамааран ялын төрлүүдийг сонгон хэрэглэж байсан бөгөөд түүнийг улам боловсронгуй болгох чигийг эрхэм болгож ирсэн байдаг. Тухайлбал: Нэгдсэн Монгол улсын үед үйлчилж байсан "Их засаг" хуулийн ялын үндсэн төрлүүд нь андгайлах, золиослох, дөнгөлөх, торгох, зодож занчих, гянданд хорих, цөллөгт явуулах, цаазаар аваачих зэрэг байжээ. Их засаг хуулийн дараа үйлчилж байсан "Их Юан гүрний нэвтэрхий хууль"-д туйвандах /богино банзаар 57 удаа занчих/, цавчрагдах / урт банзаар 67-107 удаа занчих/, хөл дөнгөлөх, хол цөлөх, үйлдэхүй хүнд ажил хийлгэх, цавчиж алах, огтчиж алах эдгээр 7 төрлийн ял байсан байна.

"Их засаг" хуулийн ихэнх зүйл ангиудад /51 зүйлийн 41-т нь буюу 80.3 хувьд нь/ цаазаар авах ял эзэлж байсан бөгөөд тус хуульд цаазын ялтай байсан хүн малыг талж авах, эд малыг талж авах, эд малыг хагасалж авах, хэрэв ялт хүн торгуулиа төлж эс чадваас биеэ тушаах зэргээр зохицуулагдаж байсан бөгөөд зарим зүйл заалтыг 1640 оны "Монгол ойрадын хууль"-д зөөлрүүлж эд малаар торгох ялаар сольж байсан байдаг.

Ер нь энэ үеэс дэлхий нийтээрээ цаазаар авах ялаас татгалзаж,

хорих ялыг түлхүү хэрэглэж эхэлсэн бөгөөд хорих ялыг боловсронгуй болгох талаар олон алхмуудыг хийж байжээ. Тухайлбал, АНУ 1786 онд Пенсильван мужийн Филадельф хотод хорих ял эдлэгсдэд зориулан нэгэн шинэ шорон нээсэн нь "пенитенциар "-ын хэмээн нэршсэн байна. Энэхүү пенитенциарыг анх байгуулсан явдал нь шашин шүтлэгийн үзэл санаанд тулгуурласан байна. Пенитенциарыг үүсгэн байгуулагчид нь протестант шашны нэгэн урсгалынхан байсан бөгөөд тэдний үзлээр бол гэмт хэрэгтэн хорих ял эдлэх явцдаа өөрсдийн үйлдсэн нүгэлийг наминчлан гэмшиж, засарч хүмүүжих ёстой ажээ. Ингэж хүмүүжихэд онцгой нөхцөл, тухайлбал, хатуу чанга тусгаарлалт, чимээгүй байх явдал шаардлагатай гэж үзэж байв. Энэ байдлаас болоод шоронд чимээгүй нам гүм байх тусгайлсан орчин бүрдүүлж ингэснээр ялтан, ял эдлүүлэх байгууллагын ажилтнууд бүгд хоорондоо шивнэн ярилцдаг болсон байна. Мөн ял эдлэгсдийг ганцаарчилсан тасалгаанд хорихоос гадна тэдэнд хамтын хөдөлмөрийг хориглох, нарлуулах ажиллагаанд ганц ганцаар нь гаргах, гаднах орчинтой харьцах явдлыг бүр мөсөн хориглох зэрэг хатуу журам үйлчилж байв. Энэ бүхнийг өчүүхэн төдий зөрчихөд л хатуу чангаар цээрлүүлдэг байжээ. Энэ байдал нь ял эдлэгсдийн сэтгэл зүйд маш их дарамттайгаар тусч, ингэснээр хоригдлууд сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчлөх, тэр ч байтугай амь насаа алдах явдал цөөнгүй гардаг болсон байна.

Пенсильваны хэмээн нэрлэгдсэн хорих ял эдлүүлэх нөхцөл нь шашны төлөөлөгчдийн хүсэн хүлээсэн үр дүнд хүрээгүй ажээ.

1816 онд Нью-Йорк мужийн Оборн хотод нэгэн пенитенциарын байгууллага шинээр байгуулагдав. Энэ байгууллага нь нэг талаар дээр дурдсан ганцаарчлан хорих, чимээгүй байдалд буюу заналхийлэлтийн дор ял эдлүүлэх нөхцлийг хэвээр хадгалах, нөгөө талаар хоригдлыг хамтын хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх, эдийн засгийн хувьд ашигтай байх шинэ үзэл санаагаар ажиллах болов. Дээрх хоёр аргыг хослуулан хэрэглэснээр хоригдлууд өдрийн цагаар хямд ажиллах хүчний үүрэг гүйцэтгэж, шөнө нь ганцаарчилсан тасалгаанд хоригдож үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшин буруугаа ухаарах байдалд шилждэг байв. Ийм байдлаар ял эдлүүлэх ажиллагаа нь "Оборны хэлбэр" хэмээн нэрлэгджээ. Хоригдлын хөдөлмөр хүмүүжил, эдийн засгийн хосолсон энэ шинэ хэлбэр шоронгийн

хөгжилд зохих үр нөлөө үзүүлсэн гэж үздэг. Оборн хэлбэрээр ял эдлүүлэх явдал зөвхөн АНУ-д төдийгүй Европт ч ихээхэн тархан дэлгэрчээ.

XIX зууны хоёрдугаар хагас бол дэлхийн улсуудын ял эдлүүлэх ажиллагааг дэвшилттэй хэлбэрээр зохион байгуулах эрэл хайгуул идэвхтэй хийгдсэн үе байлаа.

XX зуунд АНУ хорих ял эдлүүлэх төрөл бүрийн хувилбарыг шинээр боловсруулахад нилээд анхаарч, ялангуяа ял эдлэгсдийн нийгэм, сэтгэл зүйн онцлогийг ихээхэн харгалзан үзэх болов. Үүний үр дүнд улс орон даяар нэг загварын бус өөр өөр төрлийн ял эдлүүлэх байгууллагууд үүсэн хөгжиж эхлэв.

Манай оронд нүүдэлчин соёл уламжлалаас шалтгаалж удаан хугацаагаар хорих ял нь харьцангуй сүүлд үүссэн байдаг. 1930-1940 оны үеэс Европ загварын шорон бүрэлдэн бий болж, Монголын түүхэн дэх гашуун сургамжит их хэлмэгдүүлэлт болсныг бид мартах аргагүй.

Өнөөгийн байдлаар авч үзэхэд Хорих байгууллагуудад жилдээ 2500 орчим ялтан шинээр ирж, мөн 2900 орчим ялтан суллагдаж байдаг бөгөөд өршөөл уучлалаар суллагдсан бусад ялтныг оролцуулан тооцоход урьдчилан хорих төв болон шорон гяндангаар эргэлддэг гуч орчим мянган хүн байдаг гэсэн судалгаа гарчээ. Гэтэл эдгээр хүмүүсийн оролцсон гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 72 тэрбум орчим байдаг боловч нөхөн барагдуулалт төдийлөн хангалтгүй байна.

Дээрх судалгааны үзүүлэлтээс дүгнэлт хийхэд “ **тэднийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монгол төрийн ялын бодлого хэрэгжиж байна уу?”** гэдэг асуулт байнга давтагддаг. Иймээс өнөөгийн нийгмийн хөгжлийн үе шат, хүний хөгжил, төрийн ялын бодлого, нийгмийн эрэлт шаардлагыг хангах тийм ялын тогтолцоо үгүйлэгдсээр л байна.

Дэлхий нийтийг хамарсан даяарчлалын үйл явц аливаа улс орны ял эдлүүлэх үйл ажиллагаанд ихээхэн хамааралтай болж байна.

Иргэдийг гэмт хэргийн учир шалтгаанаар хорьж цагдах, ял эдлүүлэх ажиллагаанд шинэ шаардлага тавигдаж, түүнийг зөв шийдвэрлэх явдал зөвхөн тухайлсан нэг орны асуудал биш гэдэг нь тодорхой болсоор байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд хандахад орон бүрийн онцлог байх ёстой

ч НҮБ-аас гаргасан Тунхаг бичгүүдэд тогтоосон нэгдсэн жишиг байдаг. Өнөөдөр олон улсуудад ял эдлүүлэх ажиллагаанд тохиолдож буй бэрхшээлтэй асуудлуудыг дараах нөхцөл байдлуудаар нэрлэж байна. Үүнд:

-Олон орны шоронд хоригдогчдын, ялангуяа урьдчилан мөрдөн байцаалтын явцад тэдний дийлэнх олонх нь эрх зүйн хэвийн тусалцаа авах боломжгүй буюу тун бага боломжоор хангагддаг.

- Дэлхийн шоронгууд нь нийгмээс тусгаарлагдан мартагддаг байгууллага болсон.

- Амьдрал дээр шоронгийн нөхцөл байдал хүмүүнлэг бус, НҮБ-аас болон бүс нутгийн тогтоосон хамгийн доод хэм хэмжээнээс доогуур байна.

-Хүний эрх зөрчигдөх явдал, тухайлбал шоронг хэт дүүргэх, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байх, хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээгүй байдал, эмнэлгийн чанаргүй үйлчилгээ, халдварт өвчлөл болон хорих ял эдэлж байхдаа нас барах явдал өндөр түвшинд хүрч, хүчирхийлэл, авилгал өргөн дэлгэрсэн.

-Олон оронд мэргэшсэн боловсон хүчин хүрэлцээгүй, хөрөнгө мөнгө дутагдалтай, шүүх эрх мэдлийн болон эрүүгийн ял шийтгэлийг эдлүүлэх системийн хамтын үйл ажиллагааны зохицуулалт муу байгаагаас хоригдлын гомдлыг шүүх эрх мэдлийн байгууллагад хүргэх болон хянаж үзэх ажиллагаа хэт удаашралтай.

-Олонх шоронд янз бүрийн арьс өнго ба үндэстний цөөнхид хамаарах хүмүүс байхаас гадна, тэнд байгаа ядуу хүмүүсийн эзлэх хувь хэтэрхий өндөр байна.

-Нийгэм дэх мансууруулах бодис хэрэглэгчдийн асуудлыг шийдвэрлэх оролдлого хийх үед тэдэнд хорих ялыг хэрэглэсэн явдал шоронд хоригдогчдын тоо өсөхөд олон талаар нөлөөллөө. Зарим оронд нийт хоригдогчдын 50 хүртэлх хувь нь хүчирхийлсэн бус, зөвхөн мансууруулах бодистой холбоотойгоор шоронд орсон байна. Эмгэнэлт хувь заяаны эрхээр шоронд байгаа хоригдлуудын мөн төдий хувь нь мансууруулах бодисыг далд нууцаар хэрэглэж байна.

-Эмэгтэйчүүд, хүүхэд, сэтгэл мэдрэлийн ба үхлүүт өвчтэй хоригдлууд, тахир дутуу хүмүүс, өндөр настан, үндэсний ба шашны цөөнхийн төлөөлөгчид, гадаад улсын иргэн, улс төрийн хоригдлууд өөрсдөд нь

зайлшгүй хэрэгцээтэй байгаа халамж анхаарлыг хүлээн авч чадахгүй байна.

-Хорих ялыг зайлшгүй тохиолдолд бус харин ялимгүй гэмт хэрэгт үндсэн ял болгон хэрэглэж байна.

-Зарим оронд цаазаар авах ялыг хэрэглэсээр, хүмүүс шүүхийн шийдвэр биелэгдэхийг хүлээсээр, тэд ихэвчлэн хүмүүнлэг бус нөхцөлд, байвал зохих эрх зүйн хамгаалалтын эрхгүй гэх зэргээр авч үзсэн байна.

Эцсийн дүндээ " **Шорон нийгэмд тун бага ашиг огч хоригдогчдын гэр бүлийг бусниулж тэдний давхар яллаж байна, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нохон барагдуулах чиглэлээр бодит арга хэмжээ авч чаддаггүй, тэдний ходолморлүүлэхгүйгээр хорьж байгаа нь харин ч эсэ үйл ажиллагаанд саад болж байна, ялтныг хүмүүжүүлэх үндсэн үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон улмаар хохирогчдын ашиг сонирхлыг хангаж чадахгүй байна**" гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Дээрх сөрөг үзэгдэл нь Монгол орны нөхцөлд ямар байгааг харьцуулан үзэж дүгнэлт гаргах, шийдвэрлэх арга замыг зөв тодорхойлох явдал олон талын ач холбогдолтой. Монгол улсын өнөөгийн нийгмийн эрэлт шаардлагаас харахад хорих ялын үр нөлөөг дээшлүүлж зөвхөн хүнд төрлийн гэмт хэргүүдэд нийтийг хамруулахгүй байх зарчмыг баримтлах шаардлагатай бөгөөд хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэгт хорих ялыг орлуулан гүйцэтгэх ял шийтгэлийн ямар төрөл байж болохыг эрэлхийлэх шаардлага зүй ёсоор бий болж байна.

Хорих ялыг өөр төрлийн ялаар орлуулах ямар арга зам байна вэ?, Одоо хэрэгжиж буй ялын тогтолцоо, түүний хэрэгжилтийг сайжруулах уу, эсвэл шинэ ялын тогтолцоог эрэлхийлэх үү?

Эдгээр асуултуудад хариулахын тулд өнөөдөр Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд заасан ялын тогтолцоо, тэр дундаас хорихоос өөр төрлийн ялын агуулга онцлог, дэлхий нийтэд хэрэглэж буй ялын тогтолцооны онцлогийг авч үзье.

Торгох ял гэдэг нь : Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг Эрүүгийн хуульд заасны дагуу гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.

Шигтгээ: МУ-д өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 140400 төгрөг байна. Иймээс торгуулийн ялын хэмжээ 7 саяас 70 саяд хэлбэлзэж байгаа бөгөөд ихэвчлэн авто ослын хэрэгт ногдуулж байгаа юм. Энэ хэмжээг хөдөө орон нутаг, нийгмийн эмзэг бүлэг болон дунд түвшнийхэнд хүндээр тусдаг өндөр хэмжээ, нөгөө талаас орлого сайтай хэсэг бүлэгт бол өчүүхэн төдий мөнгө бөгөөд ялын шинж чанарыг хангаж чаддаггүй гэсэн шүүмжлэлийг байнга дагуулж байдаг.

Албадан ажил хийлгэх ял: Эрүүгийн хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ. Албадан ажил хийлгэх ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай байна. Албадан ажил нь нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ.

Албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хоног баривчлах ялаар тооцож сольдог, харин хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулдаггүй.

Шигтгээ: 2002 онд анх хуулинд томъёолохдоо: 1. Ялтныг биеэр нь ажил хийлгэх; 2.Ялтны цалин хөлсийг улсад тушааж эдийн засгийн хөшүүрэг үзүүлэх зорилтыг агуулж байсан боловч ажлын байрны хомсдол, эдийн засгийн нөөц боломжоос үүдэн хожмоо цалингүй ажиллуулахаар болгож хуульчилсан нь ялын нийгмийн ач холбогдол, нөлөөг багасгасан гэх шүүмжлэлийг дагуулдаг.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял: Монгол улсын Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд

нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхдээ тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг баривчлах, хорих ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол үндсэн ялыг эдэлж дууссан өдрөөс эхлэн, харин уг ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан түүнчлэн албадан ажил хийлгэх, торгох ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан бол шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор уг шийдвэрийн хувийг шүүх тухайн этгээдийг ажил, албан тушаалд томилсон, сонгосон, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон төрийн захиргааны болон бусад байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд энэ тухай бичгээр мэдэгдэнэ. Практик хэрэглээ нь 25 %-тай байдаг.

Эд хөрөнгө хураах ял: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ. Мөн гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана гэж хуульчилжээ.

Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Баривчлах ял: Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ. Баривчлах ялыг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулна. Баривчлах ялыг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 16 насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны хүүхэдтэй ганц бие эх, эцэгт оногдуулахгүй. Баривчлах байранд ялтныг ганцаарчлан байлгаж баривчлах ялыг эдлүүлнэ.

Шигтгээ: Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ганцаарчлан хорих зорилготой боловч байрны хүрэлцээ

хангамж муугаас өнөөдрийг хүртэл ганцаарчлан хорьж чадаагүй бөгөөд өрөөний зохион байгуулалтын журмаар хорьж байгаа нь жирийн дэглэмтэй хорих ялаас ялгагдахаа больсон, ялын зорилгыг хангаж чадахгүй байна гэсэн шүүмжлэлийг дагуулдаг.

Цаазаар авах ял: Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно. Цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино.

Шигтгээ: Монгол улс цаазаар авах ялаас татгалзаж байна.

Гадаадын зарим орон дахь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог

Хорихоос өөр төрлийн ял эдлэгсдэд хамаарах олон улсын эрх зүйн баримт бичигт "Токиогийн дүрэм" хэмээн нэрлэгдсэн 1990 оны наад захын жишиг дүрэм хамаарагдана.

Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд дараах зарчмуудыг мөрдлөг болгох нь зүйтэйг НҮБ-ын гишүүн орнуудад хандан тунхаглажээ.

1. Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх явцад олон нийтийг аль болох өргөн оролцуулах боломжийг хангах

2. Олон нийтийн аюулгүй байдал, гэмт хэрэгтнүүдийн эрхийн байдлын хоорондын бодит харьцааг хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх

3. НҮБ-аас тогтоосон жишгийг өөрийн орны шүүх эрх мэдэл, үндэсний онцлогт тохируулан хэрэглэх

4. Нийгмийн сонирхол, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн зэрэгт уян хатан хандаж шийдвэр гаргаж байх

5. Хорихоос бусад арга хэмжээг хэрэглэхэд саад болох төрөл бүрийн нөлөөллийг аль болох багасгах.[7]

Хорихоос бусад төрлийн ял оногдуулах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц тухайн этгээдэд аль болох хөнгөлөлттэй хандах нь

[7] А.Лхагваа. "Монгол улсын ШШГЭЗүй".2008 он., 309-314-р тал

түүнийг нийгмийн хэвийн амьдралд эргэн очиход тус болдог хэмээн үздэг байна.

Токиогийн дүрмээр сайшаасан нэг зүйл бол хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх явцад олон нийт, хэвлэл мэдээллийн оролцоог өргөтгөх явдал юм.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээ буюу ял оногдуулахад холбогдох наад захын жишиг дүрэм НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 45/110 дугаар тогтоолоор батлагдсан байна.

Уг дүрмийн агуулга зөвхөн хорихоос өөр төрлийн арга хэмжээ төдийгүй энэ төрлийн ял эдлэгсдэд нэгэн адил хамаарагдах ёстойг заан тодорхойлжээ.

Хятад улс дахь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог.

БНХАУ-ын эрүүгийн хууль дах үндсэн ялыг хөнгөнөөс нь хүнд зүйлд жагсаавал захиран хамаарах, хорьж хөдөлмөрлүүлэх, хугацаатай хорих, хугацаагүй хорих, цаазаар авах таван ял бий.

Захиран хамаарах ялын онцлог нь: Ялтан этгээдийг хорихгүй, зөвхөн зохих эрх чөлөөг нь хязгаарлан захирагдан хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд хуульд тогтоосон хязгаарлалтыг журамлан сахих явдал юм.

Захиран хамаарах ял бол ард олонд түшиглэж гэмт эргэдийг өөрчлөх хүчин төгөлдөр бүхий ял шийтгэлийн арга болохыг туршлага нотолсон байна. Захиран хамаарах ял бол хамгийн хөнгөн үндсэн ял болох тул тус ялын ялт ажиллагаа нь нэлээд хөнгөн, хорихгүйгээр улсын ямар түвшинд хор хөнөөл учруулсан гэмт этгээд ба бусад гэмт хэргийн ялт этгээдэд тохируулан хэрэглэнэ. Жишээлбэл, ард иргэдийн биеийн эрх, ардчилалын эрхэнд халдсан гэмт хэрэг, эд хөрөнгөнд халдсан гэмт хэрэг, нийгмийн хамааралтын эмх дэглэмийг самуурууулсан гэмт хэргийг хийсэн хөнгөн ялт этгээдэд тохируулан хэрэглэнэ.

Захиран хамаарах хугацааг 3 сараас дээш 2 жилээс доош байлгана. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд "...зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтоох ёстой, ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хувааж тушаана, хориглогдошгүй гай гамшиг болсон байвал ялыг багасгах буюу хэлтрүүлж болно" гэжээ. Ихэнх гэмт хэргүүдэд **хорих**

болон **хорьж хөдөлморлүүлэх ялыг** үндсэн ялын чанартайгаар, **торгох** ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр заажээ.

Герман улс дахь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог

Торгууль бол Герман улсын эрүүгийн ял оногдуулалтад хамгийн өргөн хэрэглэгддэг байна. Торгуулийн ял нь 5-360 өдөр байх ба торгуульд хамруулах цалингийн хэмжээг шүүх тогтоодог байна. ХБНГУ-д торгох ял нь үндсэн ялд хамаардаг бөгөөд түүнийг өдрийн орлогоор хэмжиж оногдуулдаг. Мөнгөн торгуулийн өдрийн орлогын доод хэмжээ нь 5 өдрийн бүтэн орлого, дээд хэмжээ нь 360 өдрийн бүтэн орлого байна.

Өдрийн орлого 10-10.000 еврогийн хооронд хэлбэлзэх ба торгууль төлөхгүй бол хорих ялаар солино. Нэг өдрийн орлого хорих ялын нэг өдөртэй тэнцэх бөгөөд торгох ялыг сольсон тохиолдолд нэг өдрөөс 2 жил хүртэл хугацаатай хорино.

1992 оноос Германд "эд хөрөнгийн торгууль" гэсэн нэмэгдэл ялыг хэрэглэж эхэлсэн бөгөөд мансууруулах бодис худалдах болон зохион байгуулалттай бүлгийн орлогыг хураан авах боломжийг бүрэн нээх, уг гэмт явдалд орох хөрөнгө оруулалтыг зогсооход чиглэгдсэн энэ ялыг өдрийн орлогод тооцохгүй, шүүхээс улсад төлүүлэхээр тогтоосон мөнгөн дүнгээр тодорхойлогддог.

Америкийн нэгдсэн улс дахь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог.

АНУ-ын холбооны болон муж улсуудын шүүхийн дэргэд шүүхийн шийдвэр, тогтоолыг албадан гүйцэтгэх ажиллагааг явуулж байдаг ажилтан байх ба холбооны шүүхэд түүнийг маршал, мужийн шүүхэд шериф гэж нэрлэдэг боловч хэрэгжүүлж байдаг чиг үүргийн хувьд зарчмын ялгаа байхгүй учраас нийтэд нь шериф гэдэг нэр томъёог хэрэглэдэг байна.

Шериф нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэхээс гадна шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хариуцагчид нэхэмжлэлийг гардуулах, гэрчийг дуудах зэрэг шүүхийн ажлыг гүйцэтгэдэг байна. Зарим хэд хэдэн муж улсад цагдаагийн үүрэгт ажлыг ч давхар хийдэг байна.

АНУ-ын шүүхээс оногдуулдаг ялын төрөл нь голдуу **барьцаалах,**

торгууль хүлээлгэх, хорих ял эдлүүлэх юм. Барьцаалах гэдэг нь ялыг тэнсэж, шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулах ойлголт бөгөөд хорихоос бусад төрлийн ялд багтана. Барьцаалах ялыг хэрхэн оногдуулахыг АНУ-ын хууль тогтоомжинд нарийвчлан тусгасны дээр дундаж хугацаа нь 1-5 жил байхаар заажээ. Барьцаалах ялын үндсэн нөхцөл нь энэ төрлийн ял эдлэх хугацаандаа шинээр гэмт хэрэг үйлдэхгүй байх явдал юм. Хэрэв барьцаалах, торгууль хүлээлгэх ялыг нэгэн зэрэг оногдуулсан бол торгуулийн төлбөрөө төлж барагдуулах явдал нь ял эдлэлтийн биелэлтийг харуулах нэг чухал нөхцөл болдог байна.

АНУ-д торгох ялыг ямарч ангилалын гэмт хэрэгт оногдуулах боломжтой, үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар түгээмэл хэрэглэгддэг ялын төрөл бөгөөд хүнийг санаатай алсан зэрэг онц хүнд хэрэгт цаазаар авах, хорих ялыг үндсэн ялын чанартайгаар, торгох ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг.

Шүүхийн шийдвэрт торгуулийн мөнгийг нэн яаралтай төлөх эсвэл зохих хувиартайгаар төлөхийг заадаг. Торгуулийн мөнгө 30-90 хоногийн дотор төлөгдөөгүй бол энэ ял биелэгдээгүйд тооцдог байна.

Холбооны хэмжээнд торгуулийн хэмжээ нь 500,000 хүртэл доллар, муж бүрд харилцан өөр боловч дунджаар 10.000-250.000 хүртэл доллар, Огайо мужид 25.000 хүртэл, Нью-Йорк, Кентукки зэрэг мужид 10.000-20.000 хүртэл байдаг бол мансууруулах бодис худалдсан хэрэгт 8-20 сая доллар хүртэл торгууль оногдуулах боломжтой байдаг байна. Торгууль төлөхөөс зайлсхийвэл 6 сар хүртэл баривчлах ялаар солино.

Япон улс дахь хорихоос оор төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог.

Японы улсын эрүүгийн ялын тогтолцоо нь:

1. Бага хэмжээний торгууль
2. Торгууль
3. Эрүүгийн баривчилгаа
4. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих
5. Цаазаар авах гэсэн төрлүүдтэй байдаг.

Тус улсын Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд "..мөнгөн торгуулийн хэмжээ 10.000 иенээс дээш байна, хөнгөрүүлэх нөхцөл байдал байгаа бол

10 иенээс бага байж болно", 17 дугаар зүйлд "...бага хэмжээний торгууль нь 1.000-10.000 хүртэл иен байна" гэжээ. Торгох ял нь үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэгддэг бөгөөд торгуулийн хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүн болон хуулийн этгээдэд өөр өөр байдаг бөгөөд нийт шийтгүүлэгчдийн 90 хувь нь торгуулийн ялд хамаарагддаг байна. Энэ нь нэгд, авто замын осол зөрчилтэй холбогдсон гэмт хэрэг их гардаг. Хоёрт, богино хугацааны хорих ялыг аль болох цөөн оногдуулах эрмэлзэлтэй байдаг зэргээр тайлбарлагдана.

Эрүүгийн баривчилгааг хор хохирлоор бага гэмт хэрэг үйлдэгчдэд 1-30 хоногийн хугацаагаар оногдуулна.

Албадан буюу албадан хөдөлмөрлүүлэхгүй хорих ялыг 1 сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорихоор оногдуулдаг. Бүх насаар нь хорихоор ял оногдуулдаг гэх боловч тэр нь харьцангуй ойлголт юм. Хэрэв бүх насаараа хорих ялаар шийтгүүлэгчид 10 жил хорих ял эдлэх ба хүмүүжиж чадсанаа харуулсан тохиолдолд тэднийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болдог байна. Японд хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд Монгол улсын эрүүгийн ялын тогтолцооны цаашдын чиг хандлагыг тодорхойлох, түүний үр дүнг дээшлүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хүн төрөлхтөн XXI дүгээр зуунд нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн жам ёсыг дагаж цаазаар авах ялаас татгалзаж, хорих ялын хамрах хүрээг багасгах чиг хандлагыг эрхэмлэх болсон нь ажиглагдаж байна. Иймээс Хорихоос өөр төрлийн ялын төрөл хэлбэрийг шинэчлэн баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдаж эхэлж байна. Энэ чиглэлээр НҮБ-аас батлсан жишиг дүрмээр хэрэгтэнд дараах арга хэмжээг авч болохыг зөвлөмж болгодог. Тухайлбал: Урьдчилан анхааруулах, хариуцлагаас тэнсэж чөлөөлөх, иргэний эрхэнд нь халдах, торгууль зэрэг эдийн засгийн чанартай арга хэмжээг авах, өмч хөрөнгө эзэмших эрхийг хасах буюу хөрөнгийг нь хураах, оногдуулсан ялыг тэнсэх буюу хойшлуулах, ял эдлүүлэх байгууллагад өдөр бүр очиж байхаар шийдвэрлэх, гэрийн хорионд байлгах зэрэг арга хамжээг хамруулсан байна.

Олон улсын барьж буй эдгээр зарчмаас гадна манай орны нөхцөл

байдал, иргэдийн санаа бодолд нийцсэн, нийгмийн эрэлт хэрэгцээг хангахуйц ялын төрөл хэлбэрийг эрэлхийлэх шаардлагатай бөгөөд өмнөх хуулиудыг санаачлан хэрэгжүүлэхдээ ч мөн энэ зарчмыг баримталж ялын төрөл хэлбэрүүдийг шинэчилж иржээ.

2. Хорихоос өөр төрлийн ялын тогтолцоо түүний хэрэгжилтийг боловсронгуй болгох. Тухайлбал: торгох ялын хэмжээг нийгмийн шударга ёсны зарчим, ялын чанар хүн болгонд ижил үйлчлэх зарчмын үүднээс харгалзан үзэж Герман болон бусад орны жишгээр торгуулийн хэмжээг өдрийн орлогоор тооцох, Японы жишгээр бага торгууль, торгуулийн гэсэн систем буюу ялгаатай ангиллын систем зэргийг өнөөгийн хувилбартай хослуулах хэлбэрээр зохицуулалт хийх боломж харагдаж байна. Торгох ял нь хэрэгжүүлэхэд хамгийн түгээмэл ял бөгөөд цаашид ч энэ чанар хадгалагдах тул нийгмийн шаардлагыг хангаж чадах уян хатан хэлбэрийг сонгож хэрэглэх нь зүйтэй байна.

2002 онд Эрүүгийн хуульд шинээр оруулсан Баривчлах болон албадан ажил хийлгэх ялын тогтоцоо нийгмийн ач холбогдол, хүмүүжлийн нөлөөг нь нарийвчлан тогтоож судлах шаардлагатай байна. Хорих ангийг нээлттэй хаалттай системд шилжүүлсэн тохиолдолд баривчлах ялын хэрхэн уялдахыг тогтоох.

Олон улсад хэрэгжиж байгаа эрүүгийн баривчилгаа, гэрийн хорио, хорьж хөдөлмөр хийлгэх, хамт олон, ах дүүсийн баталгаанд өгөх, мөнгөн барьцааны хугацаа гэх мэт шинэ хэлбэр төрлүүдийг судалж үзэж болох юм.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ



Я.БАТГЭРЭЛ

Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2007 оны 2-р сарын 23-ны өдрийн А/31 тоот тушаалаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэд <<Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын хэсэг>> байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Зарим хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигч иргэдэд учирсан хохирлын тодорхой хэсгийг Монгол улсын төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулахаар Монгол Улсын их хурлаас 2007 оны 8-р сарын 3-ны өдөр <<Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах тухай>> хууль батлагдаж, энэ хуулийн 6-р зүйлд заасны дагуу хохирол барагдуулах журмыг Засгийн газрын 2007 оны 9-р сарын 27-ны өдрийн 242 дугаар тогтоолоор батлан гаргасан.

Харин Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12-р сарын 24-ний өдрийн 64-р тогтоолоор банкны өр барагдуулах газрын чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэнтэй холбогдуулан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2009 оны 03-р сарын 17-ны өдрийн б/31 тоот тушаалаар <<Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба >> болж өргөтгөн зохион байгуулагдсан байна.[8]

[8] А.Лхагваа., Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал., 2011 он УБ хот., 84 дэх тал

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 26 хадгаламж зээлийн хоршоодод холбогдох 8301 хохирогчтой 72,4 тэрбум төгрөгийн төлбөртэй гүйцэтгэх баримт бичиг, татан буугдсан, дампуурсан банкны болон өрхийн амьжиргааг дээшлүүлэх төслийн зээлийн бүгд 28,1 тэрбум төгрөгийн 6787 зээлийн материалд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хууль, "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай" хууль болон бусад хууль эрх зүйн актуудын хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажиллагаа нь төлбөр төлөгч хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгуулагч, иргэний хариуцагч зээлдэгч нараас төлбөр гаргуулах, шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, хувьцааг Цагдаагийн байгууллагаас хүлээн авах, худалдан борлуулах, төлбөр авагч иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх ашгийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах, "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль"-ийн дагуу хохирогчдод бодит хохирлын 50 хувийг улсын төсвөөс олгох, хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зэрэг ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд цөөхөн төлбөр төлөгч, олон /1900 хүртэлх/ төлбөр авагч оролцдог, Төрийн зарим байгууллага хамтран ажиллах шаардлагатай болдгоороо онцлогтой юм.

Тус алба Шүүхийн шийтгэх тогтоол түүний хавсралтанд заасан, мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд битүүмжлэгдсэн 30,824,455.2 төгрөгийн үнэлгээтэй 94,344 ширхэг эд хөрөнгө Цагдаагийн байгууллагаас хүлээн авахаас нийт 29,259,825.0 төгрөгийн үнэлгээтэй 69,380 ширхэг эд хөрөнгө буюу нийт хохирлын дүнгийн 40 хувьтай тэнцэх хөрөнгө хүлээн авсан[9].

[9] БХЗХТБАА-ны 2012 оны 3 р улиралын мэдээ., 2012.09.25., УБ хот.,



Хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын шатанд 29,2 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн эд хөрөнгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах явцад

- Хувьцаат компаний 7,3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 71 үл хөдлөх эд хөрөнгө
- Шүүхээс чөлөөлсөн 1,8 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 29 үл хөдлөх эд хөрөнгө
- Бусдад барьцаатай 194,6 сая төгрөгийн үнэлгээтэй 6 үл хөдлөх эд хөрөнгө
- Эрхийн маргаантай 123,2 сая төгрөгийн үнэлгээтэй 6 үл хөдлөх эд хөрөнгө

байгаа нь тус тус тогтоогдож нийт 9,4 тэрбум төгрөгийн хөрөнгө буюу хүлээн авсан хөрөнгийн үнийн дүнгийн 32,1 хувьтай тэнцэх үнэ бүхий хөрөнгийг худалдан борлуулах боломжгүй болсон.



Худалдан борлуулах боломжтой гэж үзсэн 19.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөс 16,0 тэрбум төгрөгийн үнэлгээтэй хөрөнгөөр төлбөр барагдуулсан. Үүнд:

- 12,3 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулсан
- 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгийг төрийн өмчид шилжүүлсэн
- 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгийг төлбөрөө бүрэн барагдуулсан тул чөлөөлсөн /зээлдэгчийн/

Худалдан борлогдоогүй байгаа үлдэгдэл 3,7 тэрбум төгрөгийн үнэлгээтэй хөрөнгө байна.



"Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль"-ийн дагуу улсын төсвөөс:

- 2007 оны 12 дугаар сард 33,000,000.00 төгрөг
- 2010 оны 06 дугаар сард 2,068,766.8 төгрөг
- 2011 оны 12 дугаар сард 1,081,977.7 төгрөг

нийт 36,150,744.5 төгрөгийг хүлээн авч, 26 хадгаламж зээлийн хоршооны 7731 хохирогчтой зохих гэрээг байгуулан 35,870,647.0 төгрөгийг олгож эргэн төлөгдөх нөхцөлөөр хохирлын мөнгө олгох шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа 99,2 хувьтай байна. Уг хуулийн дагуу 15,422,084.4 төгрөгийг төрд буцаан төвлөрүүлж, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг төсөвт төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт 42,7 хувьтай төрд эргэн төвлөрүүлэх мөнгөний үлдэгдэл **20.728.660.1** төгрөг байна.

Иргэний хариуцагч, төлбөр төлөгч нарт холбогдох 545 гүйцэтгэх бичиг баримтанд холбогдох 6,996,764.7 төгрөгийн материалд шийдвэр

гүйцэтгэлийн ажиллагааг явуулж 631.705.7 төгрөгийн үнийн дүнтэй 21 гүйцэтгэх баримт бичгийг шүүхээс хэрэгсэхгүй болгож, 100,081.6 төгрөгийн үнийн дүнтэй 13 гүйцэтгэх баримт бичгийг төлбөр төлөгч нас барсан үндэслэлээр хасаж, 160,590.7 төгрөгийн үнийн дүнтэй 14 гүйцэтгэх баримт бичгийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд төлсөн баримтаар дуусгавар болгож, 88,247.5 төгрөгийн үнийн дүнтэй 1 гүйцэтгэх баримт бичгийг шүүхээс түдгэлзүүлж 2,382.738.2 төгрөгийн үнийн дүнтэй 336 гүйцэтгэх баримт бичгийг бүрэн биелүүлж 69 гүйцэтгэх баримт бичгийн 542.979.7 төгрөгийг хэсэгчлэн биелүүлж **2,925.718.0** төгрөгийг зээлдэгч нараас төвлөрүүлсэн, зээлдэгчийн үлдэгдэл 2.959.013.3 төгрөг байна.

Тус алба нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж төлбөр төлөгч, зээлдэгч нараас **2,230.062.0** төгрөгийг бодитой биелүүлж, хоршооны эд хөрөнгө худалдан борлуулах ажиллагаагаар 14.540.353.4 төгрөг, эд хөрөнгөөр 2,473,579.6 төгрөг, хоршооны үүсгэн байгуулагчдаас 109.4 сая төгрөг, Цагдаагийн байгууллагын болон банкны данснаас 711,116.6 төгрөгийг татан авч нийт 20.064.535.9 төгрөгийг барагдуулсан. Үүнээс:

Төрд мөнгөөр 12,200,000.0 төгрөг, эд хөрөнгөөр 2,473,579.6 төгрөг, албаны дансанд 655,239.0 төгрөг нийт 15,422,084.4 төгрөгийг төрд төвлөрүүлж, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг төсөвт төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт 42,7 хувьтай, төрд эргэн төвлөрүүлэх мөнгөний үлдэгдэл 20,7 тэрбум төгрөг байна.

Үлдэх 4,642.451.511 төгрөг нь төрөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр авсан мөнгөө буцаан төвлөрүүлж дууссан 8 хадгаламж зээлийн хоршоодын хохирогч нарын үлдэх хохиролд олгох мөнгө байгаа бөгөөд үүнээс 1169 хохирогчдын **3,164,980.7** төгрөгийг олгоод байна. Өнөөдрийн байдлаар "Си Эм Си", "Гэр хорооллын барилгажилт", "Үйлс үржихүй", "Нэмэгдэх ундрага", "Ти Эс Би", "Цэн Алт", "Европын хөгжил" "Севэн бойз" гэсэн 8 хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдод төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг төрд буцаан төвлөрүүлж дуусаад байна. Үүнээс:

"Ти Эс Би", "Нэмэгдэх ундрага" гэсэн 2 хадгаламж зээлийн хоршооны хохирогч нарын үлдэгдэл төлбөрийг 100 хувь барагдуулсан.

1. "Гэр хорооллын барилгажилт" хадгаламж зээлийн хоршоо 3,888,476.0 төгрөг

2. "Си Эм Си" хадгаламж зээлийн хоршоо 314,164.8 төгрөг

3. "Үйлс үржихүй"хадгаламж зээлийн хоршоо 11.999.8 төгрөг

4. "Нэмэгдэх ундрага" хадгаламж зээлийн хоршоо 133,327.7 төгрөг

5. Ти Эс Би" хадгаламж зээлийн хоршоо 63,986.5 төгрөг /улсын орлого/

6. "Цэн Алт" хадгаламж зээлийн хоршоо 43,295.5 төгрөг

7. "Европын хөгжил" хадгаламж зээлийн хоршоо 599.3 төгрөгийг тус тус олгохоор шийдвэрлэж үүнээс 1169 хохирогчдын **3,164,980.7** төгрөгийг олгосон.

Хэдийгээр "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай" хуулиар газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг худалдан борлуулахаар хуульчилж, Засгийн газрын тогтоолоор шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж хамтарч ажиллахыг төрийн байгууллагуудад үүрэг болгосон боловч төрийн байгуулгуудын хамтын ажиллагааны нэгдсэн зохицуулалт байхгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэрийн утга санаа ойлгомжгүй, тодорхойгүй байгаагаас шалтгаалж нэлээдгүй хүндрэл бэрхшээл тулгарч байдаг. Тухайлбал:

• "Баян өндөр сан","Гэр хорооллын барилгажилт", "Бүтээн байгуулалт хөгжлийн сан" гэсэн нэр бүхий 3-н хадгаламж зээлийн хоршоодын төлбөрт ашиглалтын 2, хайгуулын 3, нийт 5 ширхэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг худалдан борлуулж хохирогч нарын хохиролд олгохоор шүүхээс шийдвэрлэсэн боловч лицензийг Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын, Геологи, уул уурхайн кадастрын газрын даргын 2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 2221 дугаар шийдвэрээр "тусгай зөвшөөрлийн эзэлжит жилийн төлбөрөө төлөөгүй" гэсэн үндэслэлээр тус тус цуцалсан байна. Мөн Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газраас "Ашигт малтмалын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан "төрийн өмч"-өөс хариуцлагагүй иргэн, хуулийн этгээдийн учируулсан хохирол, төлбөрийг төлөх ойлголт байхгүй тухай мэдэгдсэн.

• Шүүхээс "Баян өндөр сан", "Гэр хорооллын барилгажилт" хадгаламж

зээлийн хоршоодын төлбөрт "Борнуур" ХК, "Даваан булаг" ХК, "Баялаг налайх" хувьцаат компаниудын нийт 7,4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг битүүмжлэн худалдан борлуулж хохирогчдод олгохоор шийдвэрлэсэн нь компаний тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж шууд худалдан борлуулах боломжгүй болсон. Хувьцаат компаний бусад хувьцаа эзэмшигч нарын эрх ашиг нь хөндөгддөг.

• "Гэр хорооллын барилгажилт" хадгаламж зээлийн хоршоодын төлбөрт бусдын эд хөрөнгө түрээсийн гэрээгээр ашиглах явцад тохижуулсан засварын ажлыг 24,000,000 төгрөгөөр, бусдын эзэмшлийн газар дээрх павилоныг 18,000,000 төгрөгөөр тус тус худалдан борлуулахаар шийдвэрлэсэн. Дээрх эд хөрөнгө, засварын ажил, засвар хийсэн барилгын материалыг дахин ашиглах боломжгүй зэрэг нь худалдан борлуулахад хүндрэлтэй байна. Эд хөрөнгийг буулган авахад засвар хийсэн барилгын материалыг дахин ашиглах боломжгүй худалдан борлуулахад 18,000,000 төгрөгийн үнэлгээндээ хүрэхгүй байх хүндрэлтэй нөхцөл үүсээд байна.

• Эд хөрөнгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зах зээлийн ханшнаас хэт өндөр үнэлсэн, тухайн эд хөрөнгийн хэв загвар нь хуучирсан, өнөөгийн зах зээлийн ханшаар борлогдохгүй нөхцөл байдал үүсч байна. Бодит бус үнэлгээтэй холбогдох асуудлаар жишээ дурдвал: "Баян өндөр сан" хадгаламж зээлийн хоршооны төлбөрт хураагдаж ирсэн Дархан уул аймагт байх Тахианы байр 40,0 сая төгрөгөөр үнэлэгдсэн хөрөнгө худалдан борлогдоогүй тул хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгоход 1 сая 20 мянгаар үнэлэгдсэн "Бизнес кредит" хадгаламж зээлийн хоршооны төлбөрт хураагдаж ирсэн Өмнө говь аймгийн Сэврэй сумын нутагт байх "Дуут Манхан" жуулчны бааз 329 сая төгрөгөөр үнэлэгдсэн хөрөнгө худалдан борлогдоогүй тул хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгоход 36,1 сая төгрөгөөр үнэлгээ тогтоогдож байна. Мөн "Бүтээн байгуулалт хөгжлийн сан" хадгаламж зээлийн хоршооны төлбөрт хураагдаж ирсэн 2001 оны Land –cruiser 100 маркийн суудлын хуучин авто машин /мөрдөн байцаалтын шатны үнэ/ 80,0 сая төгрөгөөр, Pentium -1 компьютер нь 585.0 төгрөгөөр гэх мэт илт өндөр үнэлсэн байдаг.

Иймд дээрх нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд:

1. Боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, давтан сургах,

мэргэшүүлэх,

2. Төрийн болон хуулийн байгууллагын хамтын ажиллагааны эрх зүй зохицуулалт, хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсронгуй болгох,

3. Шүүхийн шийдвэр заавал биелэглэгдэх зарчимыг хангах үүднээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төрийн албадлагыг хэрэглэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх,

4. Төрийн бусад байгууллагын ажиллагсадын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай байна.

ТӨЛБӨР АВАГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ



С.БУЯНЗАЯА
ХСИС-ийн ШШГС-ийн багш, хууль зүйн ухааны докторант

Төлбөр авагч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

Төлбөр авагчийн эрхийг хангах нь зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хуулийн байгууллагуудад ноогдсон үүрэгт ажлаа хийснээр дуусахгүй бөгөөд олон улсын болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар хийгдэх, эрх зүй, эдийн засаг, ниймийн цогц асуудал юм. Хохирогчийн талаарх онол, тодорхойлолтыг гаргах, түүнд үндэслэн судалгаа шинжилгээ хийх, цаашид хохирлыг арилгах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал зэрэгт дэлхий нийтээрээ анхаарал хандуулан ажиллаж байна. Гадаадын зарим улс орнуудад хохирогч судлах асуудлыг шинжлэх ухааны хэмжээнд хүртэл өргөжүүлэн судлаж байна.

Хэдийгээр хохирогчдод учруулсан мөнгөн болон биет эд хөрөнгийн хохирлыг нөхөн барагдуулж байгаа боловч тэдний бие махбодь, сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах асуудал нь хязгаарлагдмал ойлголт юм. Учир нь эдгээр хохирол нь тодорхой үнэлэмж байхгүй, үнэлгээг гаргах боломжгүй байдагтай холбоотой юм.

Төлбөр авагч буюу хохирогчийн эрхийг хангах, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байдаг. Эрх, эрх чөлөө нь

зөрчигдсөн этгээдийн хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар Нэгдсэн Үндэсний Байгууллагаас тусгайлсан тунхаглал, зарчим, удирдамж гаргасан нь эдүгээ олон улсад мөрдөгддөг үндсэн стандарт, хэм хэмжээ болж байна.

Төлбөр авагч нь ямар ч байдлаар хохирсон байж болох бөгөөд тухайлбал гэмт хэрэг, захиргааны хууль бус ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд, хүчирхийллийн улмаас хохирсон зэрэг олон шалтгаан нөхцлүүдийг дурдаж болно. Нөлөөлөл нь хоорондоо харилцан адилгүй боловч учруулж буй хор уршиг, хохирол заавал байдаг. Төлбөр авагч нь стресст орох, цочирдох, айдаст автах, өөртөө итгэх итгэлээ алдах, өөрөөсөө ичих, өөрийгөө буруутгах, гэр бүлийн гишүүдийнхээ өмнө буруутан болох, нэр хүнд нь гутаагдах, орчиндоо аж төрөх боломжгүй болох цаашлаад амиа хорлох явдалд хүрч байна.

Манай улсад төлбөр авагч, хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тэдэнд дэмжлэг үзүүлэх, төлбөр авагчийн эрхийг хамгаалах, тэдний нуущыг хадгалах зэрэгт хандсан үйл ажиллагаа байдаггүй нь учир дутагдалтай юм.

Хохирогчийн эрхийг олон улсын гэрээ, конвенц, тунхаглал, зарчмуудаар баталгаажуулсан гол асуудал бол хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм. Хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь төлбөр авагч бүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тэгш, үр дүнтэй боломж эдлэх, хохирлоо хурдан шуурхай, бүрэн, зохистой барагдуулах бололцоогоор хангагдана гэсэн ойлголт юм. Төлбөр авагчдад хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх асуудал нь төлбөр авагчийн эрх хангагдахад гол хүчин зүйл болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгосон "... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрх"-ийг баталгаатай эдлүүлэх, төлбөр авагчийн эрхийн хэрэгжилтийг хангаж буй эрх зүйн зохицуулалтыг авч үзье. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 22 дугаар зүйлд: Төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах үед байлцах, холбогдох тэмдэглэл, бусад баримт бичигтэй танилцах, тэдгээрийн хуулбарыг авах, нэмэлт баримт бичиг гарган өгөх, амаар болон бичгээр тайлбар гаргах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гүйцэтгэгчийг татгалзан гаргах эрхтэй

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй

3. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 106 дугаар зүйлд: Байцаан шийтгэх ажиллагааны оролцогч, түүнчлэн уг ажиллагааны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол иргэн, хуулийн этгээд нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу гомдол гаргах эрхтэй гэжээ.

Төлбөр авагч нь өөрийн эрхийг эдэлж хуульд заасны дагуу төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхтэй байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 52 дугаар зүйлд тусгайлан хуульчилсан байна.

- Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар уг үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлэхээр шийдвэрлэж болно

- Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлсэнээр тухайн эд хөрөнгөөс олох орлого нь түүнийг эзэмших, ашиглахтай холбогдсон зардлаас их байх тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлэх шийдвэрийг гаргана

- Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлэх шийдвэрийг гаргахын өмнө үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлсэнээр эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болох этгээдүүд болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн бүх этгээдэд мэдэгдэж саналыг нь авна

- Төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлсэн барилга буюу түүний тодорхой хэсэгт төлбөр төлөгч өөрөө оршин суудаг бол орон сууц ашигласны хөлсийг тухайн үеийн ханшаар төлбөр авагчид төлөх үүрэгтэй

- Төлбөр авагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшиж, ашигласнаас бий болох үр шимийг авч, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдон гарах бүх зардлыг төлнө

- Шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн шаардлагыг бүрэн хангасан, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад албадан шилжүүлсэнээр төлбөрийн шаардлагыг хангах боломжгүй болох нь илт болсон бол төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх тухай шийдвэрээ хүчингүй болгоно гэж заасан юм.

Төлбөр авагчийн эрхийг хангах, хохирлыг барагдуулахад шууд хамааралтай хүчин зүйл бол:

1. Төлбөр авагчийн эрх ашгийг хамгаалахад туслах өмгөөлөгч, түүнийг хөлслөх санхүүгийн нөхцөл боломж

2. Төлбөр төлөгч этгээдийн төлбөрийн чадвар, хохирлоо бүрэн барагдуулах хүсэл эрмэлзэл

3. Тухайн хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй хуулийн ажилтны хандлага нар болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болох үндэслэлүүдийг тусгасан байдаг ба үүний дотор "Төлбөр төлөгч иргэн, эсхүл төлбөр авагч иргэн нас барсан гэж зарлагдсан буюу төлбөр төлөгч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан үед тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй", "Төлбөр төлөгч хуулийн этгээд дампуурлын хэрэг үүсгэж явуулсан татан буулгах ажиллагаа дуусгавар болоход эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байгаа нь шүүхээр тогтоогдсон" гэсэн заалт байдаг. Энэ заалтын хүрээнд эдгээр дурдсан тохиолдол бий болсон бол төлбөр авагчийн шаардлага хангагдахгүй гэсэн үг юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Төлбөр авагчийн шаардлага нь аливаа шалтгаанаас болж хангагдахгүй тохиолдолд төлбөр авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хэрхэх талаар хуульчилсан заалт байхгүй байгаа нь учир дутагдалтай байна. Манай орны хувьд хуульчлагдсан байдал нь зөвхөн түүнд хохирол учирсан нь тогтоогдож шүүхээс хүчин төгөлдөр шийдвэр гарсанаар төлбөр авагчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал яригддаг. Бусад эзэн холбогдогч нь тогтоогдоогүй эсвэл хууль эрх зүйн мэдлэг дутуугаас болж тухайн

хэргийг гэрчлэх баримт нотолгоо байдаггүйн улмаас хохирогч буюу төлбөр авагчаар тогтоогдоогүй олон иргэд, аж ахуйн нэгж хохирч эрх, эрх чөлөөгөө сэргээлгэж чадахгүй үлдэж байна.

Хохирлоо нөхөн төлүүлэх эрх хангагдах нэг чухал нөхцөл бол хохирлоо хурдан бөгөөд шуурхай, бүрэн барагдуулах бололцоотой байх явдал билээ. Хохирогчийн хохирлыг ямар хугацаанд барагдуулах эсэхийг хуулиар тодорхойлсон зүйл заалт байхгүй. Манай улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас харахад шүүхээр хэрэг хянан шийдвэрлэхэд хэргийн шинж байдал, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хянуулах эсэхээс хамаарч, шүүхийн эцсийн шийдвэр гарах хугацаа нь 2 сар 7 хоногоос 35 сар хүртэлх хугацаа шаардлагатай байна. Хохирлоо нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гараад төлбөр авагчаар тогтоогдсон хэдий боловч энэ шийдвэр нь бодитой, бүрэн биелэгдэх хүртэл хичнээн хугацаа өнгөрөх нь тодорхойгүй асуудал юм.

Төлбөр авагчийн эрхийг хангах, хохирлыг нөхөн барагдуулах асуудлыг эдийн засаг, эрх зүйн орчин, хууль тогтоомжийн сурталчилгаа зэрэг нийгмийн бүхий л чиглэлээр төрийн цогц бодлогыг олон улсын туршлагыг судлан өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төлбөрийн чадваргүй төлбөр төлөгчийн учруулсан хохирлыг төлбөр авагчид нөхөн олгох, хохирол барагдуулалтын хариуцлагыг төр хариуцдаг байх, үүний тулд төлбөр төлөгчдийг ажлын байраар хангаж цалин, хөдөлмөрийн хөлсийг хохиролд нь тооцон олгодог байх зэрэг хариуцлагын тогтолцоонд шилжих нь зүйтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэх тухай хууль зөрчсөн төлбөр төлөгч нарт хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, чангатгах шаардлагатай. Учир нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас санаатайгаар зайлсхийх, хууль зөрчих, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цаг хугацааны хувьд алдагдуулж төлбөр төлөгдөхгүй байх үндэслэл болж төлбөр авагчийн эрх хангагдаж чадахгүй байдалд хүрч байна.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ АЖИЛЛАГААНД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ



З.БАТДОРЖ

ШШГЕГ-ын харъяа Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч, Шихихутуг ХЗДС-ийн магистрант

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр болон шүүхээс баталгаажуулсан бусад байгууллагын хуульд заасан шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шийтгэх тогтоол тэдгээрийг үндэслэн төрөөс хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас хууль журамд заасны дагуу гүйцэтгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгуулагч нарын буруутай үйл ажиллагааны улмаас хэдэн мянган иргэнд олон тэрбум төгрөгийн хохирол учирсан билээ. Дээрх гэмт үйлдлийн улмаас бусдад учирсан хохирол төлбөрийг барагдуулах ажиллагаа нь бусад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас нилээд онцлог бөгөөд уг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд учирч байгаа хүндрэл бэрхшээл түүнийг даван туулах арга замыг эрэлхийлэх зүй ёсны шаардлага гарч ирсэн. Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт тэрхүү ажиллагааг явуулж буй журам нь амьдрал практикт хэрэгжиж байгаа чиг хандлагыг тусгайлан онолын болон практикын хүрээнд судалж дүгнэлт хийхийг зорьсон юм.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2007 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/31 тоот тушаалаар Нийслэлийн Шийдвэр Гүйцэтгэх Албаны дэргэдэх Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчоор тогтоогдсон хадгаламж эзэмшигч иргэдэд учирсан хохирлын тодорхой хэсгийг Төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах эрх зүйн орчиныг бүрдүүлж, *Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах" тухай Монгол Улсын хууль батлагдаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хохирол барагдуулах журмыг уг хуульд нийцүүлэн Засгийн газрын 2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 242 дугаар тогтоолоор батлсан.*

Үүнтэй уялдан ШШГЕГ-ын даргын 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Б/787 тоот тушаал гарч ШШГЕГ-ын харъяа Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба болон зохион байгуулагдсан.[10]

Тус алба нь 26 хадгаламж зээлийн хоршоонд холбогдох 8301 хохирогчтой 72,4 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичиг, материалыг хүлээн авч, холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрх нь зөрчигдсөн аж ахуй нэгж, хуулийн этгээдийн болон иргэдийн хохирлыг барагдуулах үйл ажиллагааг явуулж "Монгол Улсын Үндсэн хууль", "Иргэний хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль", "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах" тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа удирдлага болгон 51 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

Хадгаламж зээлийн 26 хоршоодод холбогдох 8301 хохирогчтой 72,4 тэрбум төгрөгийн төлбөртэй гүйцэтгэх баримт бичгийг шүүхээс хүлээн авч, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах тухай хуулийн дагуу улсын төсвөөс нийт 36,1 тэрбум төгрөгийг хүлээн авч 26 хадгаламж зээлийн хоршооны 7,586 хохирогчтой гэрээ байгуулан 35,6 тэрбум төгрөгийг олгож эргэн төлөгдөх нөхцөлөөр хохирлын мөнгө олгох ажил 98,5 хувьтай байна.[11]

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан явуулж нийт **16,4 тэрбум** төгрөгийг барагдуулсанаар хохирогчдод эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг төсөвт төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт **40 хувьтай** байна.

[10] БХЗХТБАА-ны үйл ажиллагааны танилцуулга 2011.12 сар 1 дэх тал

[11] БХЗХТБАА-ны 1 дүгээр улиралын тайлан, 2012.03.15, 2 дахь тал

2011 он гарсанаас хойш шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар нийт 2,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

Өнөөдрийн байдлаар "Си Эм Си", "Гэр хороллын барилгажилт", "Үйлс үржихүй", "Нэмэгдэх ундрага", "Ти Эс Би", "Цэн Алт" гэсэн 6 хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдод төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон мөнгийг төрд буцаан төвлөрүүлж дуусаад байна.

Үүнээс "Ти Эс Би", "Нэмэгдэх ундрага" гэсэн хоёр хадгаламж зээлийн хоршооны хохирогч нарын үлдэгдэл төлбөрийг бүрэн олгож хохирлыг 100 хувь барагдуулж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгож хаасан.[12]

Хохирол барагдуулах боломжийг харуулсан судалгаа

2012.09.15

Д/д	Хадгаламж зээлийн хоршооны нэр	Өнөөдрийг хүртэлх төлбөр барагдуулалтын хувь	Бодитой биелүүлэх боломжтой төлбөрийн дүнг нийт хохиролын дүнтэй харьцуулсан хувь
1	Ажилчины бөх	2.6	10.3
2	Оюу-Алт	1.5	10.2
3	Жигүүр инвест	5.2	5.3
4	Монгол торго	26.3	36.7
5	Европын хөгжил	43.6	56.6
6	Си-Эм-Си	52.4	96.3
7	Бизнес кридет	1.8	100.0
8	Гэр хороолол	53.8	74.3
9	Улаан загалмай	11.0	73.5
10	ХОХСан	15.3	93.0
11	ББХСан	2.9	6.7
12	Төгс-Эрдэнэ	8.8	9.5

[12] БХЗХТБАА-ны 5 дугаар сарын ажлын тайлан, 2012.05.15, 4 дэхь тал

13	Үйлс үржихүй	70.2	100.0
14	Глоб кридет	16.7	21.3
15	Нью болор оргил	3.0	19.4
16	Баян-Өндөр	19.7	21.6
17	Нэмэгдэх ундарга	100.0	100.0
18	Ти-Эс-Би	100.0	100.0
19	Хаан түшиг	3.0	43.5
20	Цэн-Алт	63.4	69.5
21	Эрхэс инвест	41.9	74.2
22	ЗИБ	5.2	29.6
23	Севен бойз	36.4	43.5
24	Бөөн цагаан нуур	1.4	11.4
25	Бод боломж	2.4	38.5
26	Мэдээлэл сан ХЗХ	9.9	100.0
27		25.0	32.9

Дээрх судалгаанаас харахад хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдах боломж бололцоо хангалтгүй төлбөр төлөгдөх хөрөнгөгүй болох нь харагдаж байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн үр дүнд муугаар нөлөөлж төлбөр авагч нарын зүгээс үл ойлгох, гомдол санал гаргах улмаар тэдний эрх ашигийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн сэргээн эдлүүлэх боломжгүй болж байна.[13]

Тус шийдвэр гүйцэтгэх алба нь "Монгол Улсын Үндсэн хууль", "Иргэний хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ууд болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллахаас гадна өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэглэдэг гол хууль бол "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах" тухай Монгол улсын хууль болон түүнд нийцүүлэн гаргасан "Хохирлыг эргэн төлөгдөх

[13] Н.Бямбадорж, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог, өнөөгийн байдал, тулгарч буй зарим хүндрэлтэй -асуудлууд сэдэвт илтгэл, 2011 он 8 дахь тал

нөхцлөөр барагдуулах" тухай журам юм. Энэ нь нэг талаараа тус албаны шийдвэр гүйцэтгэгч нарт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа хоёр төрлийн хуулийг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах боломжтойг харуулж байна. Үүнээс шалтгаалан доорх онцлогууд урган гарч ирсэн.

1. "*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана*"[14] гэж заасны дагуу тус алба нь бүтэц зохион байгуулалтын хувьд тойргийн бус ***ажил үүргийн зарчмаар байгуулагдсан*** ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааг харъяалал харгалзахгүй Нийслэл болон орон нутагт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдагаараа онцлогтой.

2. "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах" тухай хуулийн дагуу нийт **26** хадгаламж зээлийн хоршоонд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдагаараа онцлог */Энэ хууль нь хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхийн шийтгэх тогтоолоор хохирлынх нь бодит хэмжээг тогтоосон хадгаламж зээлийн хоршоод хамаарна.*[15] /

3. Төлбөр авагчийн /хэдэн мянган иргэнд олон тэрбум төгрөгийн хохирол учирсан / тоо олон байдгаараа онцлог

Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажиллагаа нь "Монгол Улсын Үндсэн хууль", "Иргэний хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль", "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах" тухай Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. Эдгээр хууль эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах явцад зарим тулгамдсан асуудлууд урган гарч ирдэг ба хуулийн зарим зүйл заалтуудыг хэрэглэх боломжгүй болдог.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад Мөрдөн байцаалтын шатанд үнэлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийг "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах журам"-д <<Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны анхны үнэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллгааны явцад

[14] ШШГтухай хууль, 2002.01.10, 5 дугаар зүйл 5.2 дахь заалт

[15] Хохиолыг эргэн төлөгдөх нөхцөлөө барагдуулах тухай хууль, 2007.08.03 УБ хот, 3 дугаар зүйл 3.2 дахь заалт

тогтоосон үнэ байна. Үнийг нь тогтоолгоогүй тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр үнийг тогтоолгоно>>[16] гэж заасны дагуу албадан дуудлага худалдаанд оруулах болдог. Гэтэл "Иргэний хууль" –ийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх заалтад <<Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн анхны үнийг үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч нар харилцан тохиролцож тогтоох бөгөөд хэрэв тохиролцохгүй бол хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ тогтоолгоно>> гэж, ШШГтухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтын дагуу шинжээчээр үнэлүүлэх, 39 дүгээр зүйлийн 39.8 дахь заалтын дагуу, 48 дугаар зүйлийн 48.8 дахь заалтын дагуу үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид санал болгох, гүйцтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана гэх зэрэг зүйл заалтыг хэрэглэх боломжгүй болдог.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах журам"-ыг баримтлан үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаа зохион байгуулахад төлбөр төлөгч нар Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд гомдол гаргаж улмаар тухайн хөрөнгийн талаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч хариуцагчаар оролцон анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр хэрхэн гарах зэргийг хүлээх шаардлага гардаг. Үүнээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч хохирогч нар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргадаг.

Тус албаны бүтэц зохион байгуулалт нь тойргийн бус ажил үүргийн зарчмаар байгуулагдсан ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааг харъяалал харгалзахгүй Нийслэл болон орон нутагт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдгаараа онцлог бөгөөд төлбөр авагч нар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албатай андуурах явдал гардаг.

Мөн хадгаламж зээлийн хоршоодын үүсгэн байгуулагчидтай (Төлбөр төлөгчид) нийслэл болон орон нутаг дахь хорих ял эдлэж буй ангид очин шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тайлбар тэмдэглэл авах гэхэд та нар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхгүй тиймээс тайлбар өгөхгүй ШШГүйцэтгэх тухай хуульд заасан хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгчдээ тайлбар өгнө гэх зэрэг хүндрэл учирдаг.

[16] Хохиролыг эргэн төлөгдөх нөхцөлөөх барагдуулах журам, Засгийн газрын 2007 оны 242 дугаар тогтоолын хавсралт, 6 дугаар зүйл, 6.2 дахь заалт

Одоогийн байдлаар Хадгаламж зээлийн хоршоодоос хураагдан ирсэн хөрөнгийг "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах журам"-ын 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу төлбөр авагч нарт хувь тэнцүүлэн тараах ажиллагааг явуулахад ихээхэн хүндрэлтэй байна. Тухайлбал хураагдан ирсэн хөдлөх хөрөнгийг тараахад хэтэрхий олон төлбөр авагч байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл учирч байна. Жишээ нь: 1 ширхэг Чонын зурагтай уран зургийг 20 төлбөр авагчид тарааж өгөхөд хэрхэн хуваах вэ? гэсэн хүндрэлтэй тохиолдлыг авч үзье.

Чонын зургийг хуваан өгөхдөө эхэлж төлбөрийн үнийн дүнд дүйцэх хувьд оногдох хэсгийг нэг бүрчилэн үнийн дүнгээр гаргана. Хувь тэнцүүлэн гаргасан хувь болон үнийн дүнд дүйцэхүйц хөрөнгийг танилцуулна. Үүний дараа хохирогч нарт хөрөнгийг санал болгох ажил явагдана. Төлбөр авагч нараас нэг өндөр үнийн дүнтэй Э гэх төлбөр авагч уран зургийг авна гэхэд нөгөө 19 төлбөр авагчдад зөрүү мөнгийг төлөх шаардлага гарна. */Хохирлын мөнгөний оронд хөрөнгө авах гэж байгаа Э гэх төлбөр авагч бусад төлбөр авагч нарт Чонын зурагны үнийн дүнгийн зөрүүг төлөх шаардлага урган гарч ирнэ. Иймд хохирлын мөнгөний оронд хөрөнгө авах гэсэн Э мөнгө төлж хөрөнгө авна гэсэн нөхцөл байхгүй.* Эсвэл үлдсэн 19 төлбөр авагч нараас "Уран зураг" цуглуулдаг хүн авна гэх бол мөн адил маргалдана.

Энэ байдлаар нийт 26 хадгаламж зээлийн хоршооны **17,591 ширхэг 2,202,006,080 төгрөгийн** хөдлөх хөрөнгийг тараахад хүндрэл учираад байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар монгол улс дахь хууль эрх зүйн актуудын шинэтгэлийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, тогтолцоог дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах журмыг нарийвчлан тодорхой болгож, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад гардаг эрсдэл, алдаа дутагдлыг багасгах, шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг ахиулахын тулд тодорхой судалгаа төлөвлөгөөт ажил хийж гүйцэтгэж байна.

Энэхүү судалгааны ажлыг хийх гүйцэтгэх хугацаанд хэрэглэгдсэн судалгаа, практик үйл ажиллагааны үндсэн дээр доорхи дүгнэлтийг хийж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажиллагаанд "ШШГТ" хууль болон "ХЭТНБТ" хуулийг хослуулан хэрэглэдэг болохыг дээр дурьдсан. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мөрдөн байцаалтын шатанд үнэлэгдэн тус албанд шилжин ирсэн үл хөдлөх хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулахад төлбөр төлөгч нар үнэлгээ зах зээлийн ханшнаас доогуур байна гэсэн үндэслэлээр шүүхэд ханддаг.

Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулж, анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэж байна. Иймд:

1. ШШГТ хуулийн 37 дугаар зүйлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хураагдсан эд хөрөнгийг үнэлэх талаар хуульчилсан байх ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулахгүйн тулд тус хуулийн 37 дугаар зүйлд ***"Эрүүгийн хэргийн талаар гарсан шийтгэх тогтоолын дагуу явагдаж буй шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тодорхой дурьдах шаардлагатай байна.*** / Жишээ нь: Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн анхны үнэ "ХЭТНБТ" хуулийн дагуу ЭБША-нд тогтоосон үнэлгээ байна гэх эсвэл тухайн үеийн зах зээлийн ханшаар худалдан борлуулна гэж нэмэлтээр оруулж өгөх шаардлагатай байна./

2. Хураагдан ирсэн хөрөнгийг хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдод "ХЭТНБТ" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу хувь тэнцүүлэн тараах ажиллагаа бэлтгэлийн шатандаа байна. Улсын төсвөөс авсан хохирлын 50 хувийг буцаан төвлөрүүлээгүй байгаа хадгаламж зээлийн хоршооны ***хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн хороонд шилжүүлэн өгөх*** нь зүйтэй байна.

3. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд "ШШГТ" тухай хууль шинэчлэгдэн батлах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа гэх ба шинээр батлагдах "ШШГТ" хуульд ***Цөөхөн төлбөр төлөгчтөй олон төлбөр авагчтай шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулах талаар хуульчилж эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн бодит үр дүн дээшлэх боломжтой*** гэж судлаач миний зүгээс үзэж байна.

ТОДОРХОЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХИЙГ ХАСАХ ЯЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Ш.СҮХБАТ
УЕПГ-ын ял эдлүүлэх ажиллагаанд
хяналт тавих хэлтсийн прокурор

Монгол улсын Эрүүгийн хуульд зааснаар Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа болон төрийн зүгээс тавьж буй хяналтыг сайжруулахын тулд дараах алхамуудыг нэн тэргүүний хийх шаардлагатай байна.

1. Хяналт тавьж буй байгуулага болон гүйцэтгэх байгууллагуудын хооронд нягт уялдаа холбоотой ажиллагаа болон орчин үеийн техник технологи, менежмент, эрх зүйн шинэчлэлийн хүрээн дэх шинэ хууль тогтоомжуудыг бий болгон хамтарч ажиллах

2. Хамтын үйл ажиллагаатай байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг зэрэгт нь тулгуурлан өөрийн үйл ажиллгааг тохируулж ажиллах

3. Цаашид байгууллагууд хооронд үйл ажиллагааг сайжруулах талаар тус тусдаа бодлого боловсруулж ажиллах бус хамтран бодлого боловсруулж урьдчилан сэргийлэх, хянах, таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг цаг алдалгүй ажиллах шаардлагатай.

4. Хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх талаар нэг мөр нэгдсэн

ойлголтуудыг бий болгож бусад байгууллагуудын харилцааг маш сайн тодруулах нь түүний үр дүн бөгөөд цаг алдалгүй ажиллахад нэн тустай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд прокурорын байгууллагаас тавьж буй хяналт түүний үр дүнд ял эдлүүлэх ажиллагааны эцсийн үр дүнг сайжруулах чиглэлээр доорхи саналуудыг дараах судалгааны дүнд үндэслэн хүргэж байна.

"Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялын биелэлтийг улсын хэмжээнд 2009, 2010, 2011 оныг хамруулан судласан дүнгээс харахад дээрх 3 оны байдлаар уг ялаар 962 ялтан шийтгэгдсэнээс 57 буюу 6 хувь нь эмэгтэй, 905 буюу 94 хувь нь эрэгтэй, 23 буюу 2.3 хувь нь тодорхой албан тушаал эрхлэх ялыг, 939 буюу 97.3 хувь нь үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг тус тус оногдуулсан байна.

Үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялаар 939 хүн шийтгэгдсэнээс 916 буюу 97.5 хувь нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах ял, 12 буюу 1.2 хувь нь эмчлэх, эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, 6 буюу 0.6 хувь нь хөдөлмөр хамгаллын журам зөрчсөн, 5 буюу 0.5 хувь нь нягтлан бодох болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял шийтгэлийг оногдуулсан байна. Уг ялаар шийтгүүлэгчдээс 22 буюу 2.2 хувь нь төрийн тусгай албан хаагч, 25 буюу 2.5 хувь нь терийн захиргааны албан хаагч, 42 буюу 4.3 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид эрх хасах ялтай 56 зүйл анги байгаагаас шүүхийн практикт сүүлийн 3 жилд 14 зүйл ангийг буюу зөвхөн 25 хувийг нь хэрэглэсэн байна.

Шүүхээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг болон ашиглалтын журам зөрчиж эрх хасах ялаар 915 ялтан шийтгэгдсэнээс 25 буюу 2.7 хувь нь Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт зааснаар, 25 буюу 2.7 хувь нь мөн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2 дахь хэсэгт зааснаар, 480 буюу 52.4 хувь нь мөн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт зааснаар, 334 буюу 36.5 хувь нь Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.4 дэх хэсэгт зааснаар, 24 буюу 2.6 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлийн 216.1 дэх хэсэгт зааснаар, 38 буюу 4.1 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 216 дугаар зүйлийн 216.2 дахь хэсэгт заасан "Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх,

зугтаах" гэмт хэрэгт, Эрүүгийн хуулийн 220 дугаар зүйлд заасан "Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах гэмт хэрэгт 4 хүн, Эрүүгийн хуулийн 222 дугаар зүйлд заасан "Жолоогоо бусдад шилжүүлэх гэмт хэрэгт 16 хүн шийтгэгдсэн байна.

Албан тушаалын гэмт хэрэгт 16 хүн шийтгэгдсэнээс Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан "Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах" 3 хүн Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйл хэсэгт заасан "Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх", 10 хүн Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйл хэсэгт заасан "Хээл хахууль авах" гэмт хэрэгт тус тус шийтгэгдсэн байна.

Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйл хэсэгт заасан "Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх зүйл ангиар 6 хүн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 138 дугаар зүйлд заасан "Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих" зүйл хэсгээр 4 хүн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 106 дугаар зүйл хэсэгт заасан "Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх" зүйл ангиар 13 хүн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 251 дүгээр зүйлд заасан "Эрүү шүүлт тулгах" зүйл ангиар 1 хүн тус тус шийтгэгдсэн байна.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан тохиолдол байхгүй бөгөөд харин торгуулийн ялыг үндсэн ялын чанартай 77 хүнд оногдуулж, хорих болон баривчлах ялыг 857 хүнд үндсэн ялын чанартай оногдуулж, дээр нь эрх хасах ялыг нэмэгдэл ялаар оногдуулжээ.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг аймаг, дүүргийн шүүхэд харилцан адилгүй оногдуулсан байна. Тухайлбал: Орхон аймагт 56, Сэлэнгэ аймагт 57, Төв аймагт 99, Чингэлтэй дүүрэгт 66, Налайх дүүрэгт 48 байгаа нь хамгийн их оногдуулсан байхад Дархан-Уул аймагт 5, Говьсүмбэр 7, Дундговь аймагт 8, Баянгол дүүрэгт 6 ялтанд буюу эрх хасах ялыг хамгийн бага оногдуулсан байна.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялын биелэлтэнд хяналт тавихад гарч байгаа хүндрэл бэрхшээл, уг ялд цаашид хяналт тавих, харилцан мэдээлэх ажлыг боловсронгуй болгох талаар шийдвэр гүйцэтгэгч, хяналт тавьж буй прокурор нараас гаргасан саналыг

нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

Шийдвэр гүйцэтгэгч нар ялтныг мэдэгдэх хуудсаар дуудаж уулздаг гэх боловч бодит амьдрал дээр ялын хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь ялтан гадуур тээврийн хэрэгсэл жолоодон явж байгааг албан өрөөндөө сууж байсан шийдвэр гүйцэтгэгч мэдэх боломжгүй ба хэрэв ялын биелэлтэнд тавих хяналтыг бодит хэрэгжүүлэх шаардлагатай гэвэл замын зохицуулагч нартай хамт шийдвэр гүйцэтгэгч нар замын хяналтанд гарч ажиллах нь зүйтэй юм.

Эрх хасах ялыг хорих, баривчлах ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан тохиолдолд гүйцэтгэх хуудсыг шүүгч хэзээ бичиж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хэзээ хүргүүлж байх талаар нарийвчилсан зохицуулалт байдаггүйгээс хорих болон баривчлах ялыг биечлэн эдлэх хугацаанд гүйцэтгэх хуудас шүүх дээр хадгалагдаж, улмаар тухайн ялтан хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан эсэхийг ялтны оршин суухаар явсан газрын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд сулласан хорих ангиас мэдэгддэггүйгээс ялтныг хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдмагц нэмэгдэл ялыг эдлүүлэхээр хяналтанд авахгүй байх явдал гарч байна. Иймд хорих болон баривчлах ял эдлээд суллагдах /хорихоос хугацааны өмнө тэнсэн болон хугацаа дуусаж/ бүрт нэн даруй тухайн хорих анги холбогдох бичиг баримтын хамт ялтны оршин суухаар явсан газрын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж хэвших, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ялтныг хяналтанд авсан талаар прокурорт мэдэгдэж байх, эсхүл энэ төрлийн ял шийтгүүлсэн ялтныг оршин суугаа харъяаллын дагуу хяналтанд авахуулахаар прокурорын газраар дамжуулан шилжүүлдэг байх.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялаар шийтгүүлсэн ялтан сумын төвд амьдардаг тохиолдолд тухайн сумын хэсгийн төлөөлөгч эрх хасах ял дээр шийдвэр гүйцэтгэгчтэй хамтран хяналт тавьж байгаа боловч хэдий хугацаанд, ямар хэлбэрээр хяналт тавьж буй ажлынхаа талаар мэдээлэл солилцох, шийдвэр гүйцэтгэгч, сумын хэсгийн төлөөлөгч нар нь хоорондоо хэрхэн хамтарч ажиллах талаар тодорхой зохицуулалтыг бий болгох /Сумын төв болон сумын төвөөс алслагдсан газарт оршин суудаг эрх хасах ялаар шийтгүүлсэн ялтан өөрөө сар бүр аймгийн төвд ирж шийдвэр гүйцэтгэгчтэй

уулзах болон шийдвэр гүйцэтгэгч нь сар бүр тухайн суманд хүрч ажиллах нь практикт хүндрэлтэй байдаг/

Ялтан өөр суманд байгаа нь тухайн ялтантай шийдвэр гүйцэтгэгч байнга уулзахад хүндрэлтэй, учир нь машины бензин тосны зардал төсөвлөгдөөгүй байдаг, түүнчлэн тухайн орон нутгийн цагдаагийн байгууллагаар дамжуулан уг ялын биелэлтэнд хяналт тавих ажиллахад тогтсон журам байхгүй байна.

Иймд "Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялаар шийтгүүлсэн ялтныг бүртгэх, харилцан мэдээлэх, хяналт тавих журам"-ыг боловсруулах Хууль зүй, Дотоод хэргийн сайдын "Тодорхой төрлийн албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам"-д цагдаагийн байгууллагатай хамтарч хяналт тавина гэж заасан байна.

Цагдаагийн байгууллагаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан талаар тэр бүр тодорхой хариуг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлдэггүй нь нэмэгдэл ялд хяналт тавихад хүндрэлтэй байдаг бөгөөд энэ төрлийн ялын биелэлтийг нэг байгууллагад харъяалуулах нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд, хяналт тавихад хялбар байх болно. Ялтан этгээд нууцаар машин унаж яваад баригдсан, саатуулагдсан эсэх талаар нэгдсэн бүртгэл, цагдаагийн байгууллагатай энэ талаар мэдээлэл солилцохоор топгоосон дүрэм журам, уялдаа холбоо байдаггүй. Үүнээс гадна хасуулсан эрхээ эдэлсэн, автомашин барьсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хууль журамд зааж өгөөгүй тул шүүхийн шийдвэрийг зөрчсөн ялтанд хариуцлага хүлээлгэх боломжгүй.

Судалгааны дүнгээс үзэхэд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийг судалж, уг ялын талаар "Харилцан мэдээлэх, хяналт тавих" тусгай журам" гаргах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газраас санал авч, журмыг батлан гаргах үүрэг чиглэл өгч, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ШИЙТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН ХЭРЭГЖИЛТ, ПРАКТИК



Л.ЭРДЭНЭЦАГААН
НШГА-ны мэргэжилтэн, ахмад

Аливаа улс орны хүмүүний ухамсар, сэтгэхүйн төлөвшил, нийгэм эдийн засгийнхаа хөгжилтэй салшгүй холбоотой бөгөөд хөгжиж буй Монгол улсын хувьд эрх зүйн систем, тогтолцоогоо олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж шинэчлэж, боловсронгуй болгон хөгжүүлж байгаа билээ.

Өнөөдөр Монгол Улс Олон улсын гэрээ болон Хүний эрхийн тунхаглалд заасан хүний эрх, эрх чөлөө, жам ёсны эрхийн үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, улмаар хүний эрхийг хангах, халдашгүй байдлыг баталгаажуулах үүргийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоороо хүлээж, эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх ашгийг төрийн зүгээс хамгаалах, тэдний эрхээ эдлэх нөхцөл боломжийг олгох асуудалд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ихээхэн анхаарал хандуулж байна.

Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөнд шүүхийн шийдвэрийг хуулийн хүрээнд биелүүлдэг нөхцлийг бүрдүүлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, зах зээлийн нөхцөлд нийцсэн оновчтой хувилбар бий болгох, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд прокурорын байгууллага хяналт тавихаар холбогдох хуулиудад тусгах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагын ажилтныг шаардлагтай техник хэрэгсэл, эдийн засгийн баталгаагаар хангах нөхцлийг тогтоох, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгуулдаг тогтолцоо бий болгох асуудлыг судалж шийдвэрлэхээр тусган, дээрх заалтуудыг хэрэгжүүлэхээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Үүний илрэл нь 2002 оны "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндсийг тодорхойлон тогтоосон Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулиудыг шинэчлэн баталсан билээ.

Эдгээр хуулиудыг нийгмийн хөгжилтэйгээ уялдуулан тухай бүрт нь нэмэлт өөрчлөлтийг хийж ирсэн бөгөөд зарим нэг заалт, хуулийн нэр томъёог гадаад орнуудын хуулиас шууд авч хэрэглэсэн, өөрийн орны ахуй, амьдралын хэвшилд тохируулан хийгээгүйгээс хуулийн алдаатай, хоорондын уялдаа холбоогүй байх нь ажиглагддаг.

Нийгмийн төдийгүй хувь хүний эрэлт хэрэгцээг бүрэн хангасан байдлаар хууль тогтоомжийг гаргахад алдаа байхыг үгүйсгэх аргагүй юм. Хуулийг хүн л зохиож, зохиосон хуулиа өөрсдөө дагаж мөрддөг шүүдээ.

Шүүхийн шийдвэр гүйцтгэх ажиллагааг явуулж байгаа практик, хуулийг хэрэглэж буй байдлаас ажиглахад дараах тулгамдсан асуудлууд байсаар байна. Тухайлбал: Эрүүгийн ялын төрөл, ялангуяа хорихоос өөр төрлийн ял шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны талаархи иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгааг дурьдах нь зүйтэй.

Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллгааны нилээн онцлог бүхий нэгэн томхон бүрдэл хэсэг бол хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолийг гүйцэтгэх ажиллагаа юм.

Энэ төрлийн ялыг хэргэжүүлснээр нэг талаас нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, ял шийтгүүлэгчийн ёс зүйн төлөвшил, гэм буруугаа хүлээх ухамсар, хохирол арилгахад давуу байдал олгож болох боловч нөгөө талаас гэмт хэргийн зүйлчилэл, ялын хэрэгжилтэнд тавих хяналт, үр нөлөөг сулруулах, оногдуулсан ялын хэмжээнээс хамаарч зарим тохиолдолд ял шийтгүүлэгч засарч хүмүүжихгүй байх зэрэг хандлагын улмаас эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх, заавал биелэгдэх зарчим алдагдаж, дахин гэмт хэрэгт холбогдох сөрөг үр дагавар гарч болзошгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Иймээс хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, тухайн ялын

хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалт, түүний онцлог шинж чанар, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад баримтлах хууль, журмыг онолын болон практикийн хүрээнд тусгайлан судалж дүгнэх, улам бүр хөгжүүлэх шаардлага урган гарч байна.

Иргэдийн олонх шүүхээс зөвхөн хорих ял оноодог гэдэг өрөөсгөл ойлголттой явдаг. Тиймдээ ч хорихоос өөр төрлийн ял болох торгох, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, албадан ажил хийлгэхийг ял гэж үздэггүй байна. Энэ төрлийн ял авсан бол юман чинээ тоодоггүй сэтгэхүй давамгайлдаг бөгөөд шүүгчид, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаныхан нь ч ийм шийдвэрт хайнга ханддаг нь ажиглагдаж байна.

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалт, шүүхийн шийтгэх тогтоолоор тухайн гэм бурyутай этгээдэд оногдуулсан ялыг эдлүүлэх, мөнгөн дүнгээр биелүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, энэ төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй зарим бэрхшээлтэй асуудал, түүнийг үр дүнтэй шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд энэхүү нийтлэлийн зорилго оршиж байгаа юм.

Тиймдээ ч хорихоос өөр төрлийн ял, шийтгэл практик дээр хэрхэн хэрэгжиж буйг тодорхой бодит тоо баримт, судалгаа, ялын хэрэгжилтийг хангуулж буй байгууллагуудын мэдээ, тайланг үндэслэн энэхүү нийтлэлд уг ялын талаар авч үзэж ялын төрлөөр нь нэг бүрчилэн авч үзье.

1. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн эрхзүйн байдал, хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээл.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр болон шүүхээс баталгаажуулж өгсөн бусад байгууллагын хуульд заасан шийдвэр, хорих ял оногдуулахаар заасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан, шүүхийн шийтгэх тогтоолийг үндэслэн хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас хууль журамд заасны дагуу гүйцэтгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Торгох ял гэдэг нь: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ.

Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно.

Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг Эрүүгийн хуульд заасны дагуу гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно.

Харин торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх нь торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг ШШГТХуулийн 10-14, 18-20 дугаар зүйлд тус тус заасны дагуу гүйцэтгэх бөгөөд Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш ялтан 7 хоногийн дотор шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй.

Ялтан ШШГТХуулийн 91.2-д заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлэх ба Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 12.1-т заасны дагуу тогтоосон тойргийн шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн шийдвэрийг хуваарилна.

Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулна.

Ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

Хэрэв ялтан торгуулийн мөнгийг ШШГТХуулийн 91.2-т заасан хугацаанд төлөх боломжгүй байвал түүний өргөдлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч торгууль төлөх хугацааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулах болон мөн хугацааны дотор хэсэгчлэн төлүүлэх тухай санал прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Ялтан нь шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөөс албадан гаргуулна.

Тухайн ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг баривчлах, хорих ялаар солих тухай саналыг прокурорт гарган прокурор дүгнэлт гарган шүүхэд хүргүүлэх ба шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд заасны дагуу торгох ялыг баривчлах, хорих ялаар сольж болдог.

Дээрхээс үзэхэд торгуулийн ял шийтгэлийг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг талаас тодорхой хуульчилсан ч уг хуулийн бодит хэрэгжилт хөрсөн дээр төдийлөн бүрэн цэцэглэхгүй байсаар байна. Үүний нэг жишээ бол торгох ял хэт өндөр, торгуулийн ялаар шийтгэгдсэн этгээд төлбөрийн чадваргүй байх явдал байсаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулинд /91-р зүйлд/ торгох ялыг гүйцэтгэх ажиллагаа нь энэ хуулийн II хэсэгт зааснаар буюу иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны дагуу явуулахаар заасан байна.

Гэтэл торгох ялаар шийтгэгдсэн этгээд маань төлбөрийн чадваргүй байх, торгуулийн ял хэт өндөр байх гэсэн 2 үндэслэлээр торгох ялыг биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Жишээлбэл: Хан-Уул дүүргийн шүүхийн 2009 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 263 дугаар шийтгэх тогтоолоор иргэн Э овогтой Х-г 16.308.000 төгрөгөөр торгож шийтгэжээ.

Хэргийн байдлаас үзэхэд ялтан Х нь 2009 оны 7 дугаар сарын 10-ны орой найз Б-гын гуйлтаар суудлын автомашиныг жолоодож явахад хажууд сууж явсан Д согтуу байсан бөгөөд Х-ийн жолоодож явсан автомашины өрүүлийг хажуунаас эргүүлж автомашин онхолдож Д нас барсан байна.

Гэтэл шүүхээс түүнд 16.308.000 төгрөгөөр торгож шийтгэсэн нь биелэгдэх боломжийн хувьд туйлын хангалтгүй юм.

Учир нь ялтан Х нь ам бүл-2, эрхэлсэн тодорхой ажилгүй, хараагүй эхийгээ асран хардаг нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад тогтоогдсон байна.

Дээрх жишээнээс үзэхэд торгуулийн ялын бодлогыг зөв баримтлах нь шүүхийн асуудал боловч цаашид гарах үр дагаврыг анхаарах нь чухал

байна.

Хорихоос өөр төрлийн ял нь хөнгөн ял гэдэг үндэслэлээр оногддог боловч хэт өндөр торгуулийн ял нь биелэгдэх боломж нөхцлөөр муу байх, биелэгдсэн ч муу үр дагавар ихтэй байх практикт ихээхэн харагдаж байна. Жишээ нь: торгох ялаар шийтгэгдсэн этгээдийн ар гэр, үр хүүхэд, амьдрал ахуй нь давхар хохирох явдал амьдралд ихээхэн тохиолдож байна.

"Эрүүгийн ял шийтгэл гарцаагүй биелэдэг байх" зарчим, эрүүгийн бодлого алдагдаж байгаа бас нэгэн жишээ бол Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд өнгөрсөн 2011 онд торгох ялын 247160.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 28 гүйцэтгэх хуудас баримт бичгийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д зааснаар торгох ялын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр ялыг хэрэгсэхгүй буюу хүчингүй болгох саналыг прокурорын байгууллагад хүргүүлэн шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

Яагаад дээрх 247160.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 28 гүйцэтгэх хуудас 2009 оноос хойш 3 жилийн хугацаанд биелэгдэхгүй байсаар хэрэгсэхгүй болж байна вэ. Энэ нь нэг талаас төлбөрийн чадваргүй, торгох ялыг биелүүлэх боломжгүй этгээдэд шүүх торгох ял оноосон, нөгөө талаас хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар тухайн ялтан төлбөрийн чадваргүй, эд хөрөнгөгүй болох нь тогтоогдож байгаа явдал юм.

Түүнчлэн торгох ялын эрхзүйн хэрэгжилтийг бодит байдал дээр хуульчид өөрсдөө дордуулах явдал цөөнгүй байсаар байна. Тухайлбал: Шүүхээс хорихоос өөр төрлийн ял болох торгох ял оногдуулсан тухайн ялтны зүгээс өөрт оноосон ялыг биелүүлэх талаар хуулиар хүлээсэн үүрэг, иргэний эрхзүйн ухамсарт нь өмгөөлөгч нар нөлөөлөх явдал цөөнгүй байна.

Жишээлбэл: Баянзүрх дүүргийн шүүхийн 2009 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 100 дугаар шийтгэх тогтоолоор иргэн А овогтой "Б"-г 21.300.000 төгрөгөөр торгож шийтгэжээ.

Өмгөөлөгч хуульзүйн зөвлөгөөг тухайн ялтан "Б"-д өгөхдөө: - Торгох ялын мөнгөн дүнг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад 3 жилийн хугацаанд сар, сараар бага хэмжээгээр хэсэгчилэн төлсөөр дуусгаж болдог гэсэн ойлголтыг төрүүлсэн байна.

Шүүхээс торгох ял авсан "Б" Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр ирээд шийдвэр гүйцэтгэгчээс торгох ялыг биелүүлэх талаар холбогдох хууль тогтоомж, ... шүүхийн шийдвэр гарснаас хойш торгуулийн мөнгийг 7 хоногийн дотор төлж барагдуулах үүрэгтэй, мөн ... шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулах ... хуулийн заалтыг тайлбарлахад торгох ял авсан этгээд гайхах, манай өмгөөлөгч хэлэхдээ бага багаар төлсөөр 3 жил өнгөрөхөд ял чинь хэрэгсэхгүй болдог гэж хэлсэн ш дээ гэж хэлсэн байна. Энэ бол нэг хүний жишээ биш нийтлэг явдал юм.

Түүнчлэн шүүхийн өмнөх шат хэрэг бүртгэлт бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгө хурааж битүүмжлэх, хөрөнгө хамгаалах ажиллагаа хангалтгүй байдаг.

Энэ нь шүүхийн шийдвэр биелүүлэх, торгох ялтны эд хөрөнгөнөөс ялыг албадан биелүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгөө хууль бусаар бусдад шилжүүлэх, шүүхээс өөрт оногдуулах ялыг урьдчилан таамаглаж энэ талаар арга тактик боловсруулж эртнээс төлөвлөж өв хөрөнгө, хадгаламж, данс, мөнгөн хуримтлалаа өөр хүний нэр дээр шилжүүлж байгаагаар илэрч байгаа явдал юм.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны торгох ялын бодит биелэлтийн сүүлийн 3 жилийн байдлаар гүйцэтгэх хуудас, мөнгөн дүнг харьцуулсан судалгаа:

Торгох ялын гүйцэтгэх хуудсаар

Хүснэгт 1.1

Он	2009	2010	2011
шүүхээс хүлээн авсан гүйцэтгэх хуудас	163	126	181
бодиттой биелүүлсэн гүйцэтгэх хуудас	59	59	126

үлдэгдэл гүйцэтгэх хуудас	104	67	55

Торгох ялын мөнгөн дүнгээр Хүснэгт 1.2

Он	2009	2010	2011
шүүхээс хүлээн авсан мөнгөн дүн	941,252.9	686,561.0	1131711.8
бодитой биелүүлсэн мөнгөн дүн	163,486.8	272441.7	709460,9
үлдэгдэл мөнгөн дүн	777,766.1	674,276.0	422250.9

Прокурорын байгууллагаас нийслэлийн хэмжээнд торгох ялын бодит биелэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар 2009-2011 онд иж бүрэн шалгасан дүн шинжилгээнд: Торгох ялыг шүүхээс төлбөрийн төлбөрийн чадваргүй, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өөрийн гэсэн өмч хөрөнгөгүй, оршин суух хаяггүй хүнд ногдуулж буй талаар дурьджээ.

2. Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал, хэрэгжилт, бөдит бэрхшээл.

Эрүүгийн хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэж ойлгодог.

Албадан ажил хийх ялыг Монгол улсын Шүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-ээс 98 дугаар зүйлийн 98.3 дахь заалт, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан 2002 оны 256 тоот тушаал "Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журам"-аар зохицуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-д ... Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга албадан ажил хийлгэх ажил олох, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй, ... үүргээ хэрэгжүүлэхдээ албадан ажил хийх тухай нийтэд мэдээлэх, орон нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах хэлбэрээр

ажиллах .. талаар хуульчилсан билээ.

Хууль хэрэгжүүлэх хүрээнд албадан ажил хийлгэх ялыг нийгэмд ашигтай ажил хийлгэх замаар эдлүүлж, нэг өдөрт 3-12 цагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хариуцсан шийдвэр гүйцэтгэгч тогтмол хяналт тавьдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхээс албадан ажил хийх ял оногдуулсан ялтнуудыг аймаг, нийслэл, орон нутгийн Тохижолт үйлчилгээний компаниудад нийгэмд тустай ажил хийлгүүлэх замаар ялыг эдлүүлж байна.

Сүүлийн 5 жил буюу 2006-2011 онд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд дүүргүүдийн Тохижолт үйлчилгээний компаниудад нийт албадан ажил хийх ялтай 150.524.0 /Нэг зуун тавин мянга таван зуун хорин дөрвөн / цагтай 656 ялтны ялыг биечилэн эдлүүлсэн байна.

Бодит байдал дээр албадан ажил хийлгэх ялтай этгээдийг ажлын байраар хангах асуудал аймаг, нийслэл, орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи сул, тэдний цаг ашиглалтанд тавих хяналт тогтмол бус бөгөөд ажлын ачааллаас шалтгаалан шийдвэр гүйцэтгэгчээс түүнд өдөр тутмын хяналт тэр болгон тавьж ажиллаж чаддаггүй байна. Жишээлбэл: Шийдвэр гүйцэтгэгч албадан ажил хийх 350 цагийн ялтай ялтан "А"-г Хандгайтын, Шарга морьт, Салхитийн зуслангийн айл өрхүүдийн хог хаягдал цэвэрлэж байгааг газар дээр нь тэр болгон шалгаад явах боломжгүй юм.

Шүүхээс албадан ажил хийлгэх ялыг оноодог ч хаана, ямар төрлийн ажил хийлгэх нь тодорхой бус, хэрэгжүүлэх боломж, нөхцөл тааруу, ийм ялтай хүмүүс нь дийлэнхдээ хот тохижуулах, гудамж талбайн хог цэвэрлэх, мод услах, байгууллагын цонх хаалга угаах зэрэг саархан ажил хийлгэхээс хэтэрдэггүй байгаагаас энэ төрлийн ял төдийлөн нэг мөр хэрэгжихгүй байгаа нь шалгалтаар нотлогдож хүлээн зөвшөөрөгдсөн бодит байдал болоод байна.

4. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа өнөөгийн байдал, хэрэгжилт

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд

хөрөнгө хураах ял гэнэ.

Эд хөрөнгө хураах эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцтгэх тухай хуулийн 94 дугаар зүйлийн 94.1-ээс 95 дугаар зүйлийн 95.2 дах заалт хүртэлх зүйл хэсгүүдээр зохицуулсан байдаг.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлнэ.

Тухайн хураах эд хөрөнгө нь дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгөнөөс тодорхой эд хөрөнгийг хураахаар шүүхийн шийтгэх тогтоолд нэрлэн заасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу хураана.

Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, улсын орлогод оруулснаар эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хааж, тогтоол гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

Шүүхийн шийтгэх тогтоолд хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Шүүхийн шийтгэх тогтоолд хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгийг хураах боломжгүй болсон бол түүний үнийг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлдэг.

Эд хөрөнгө хураах ялын бодит биелэлтэнд нөлөөлж буй бэрхшээл бол шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заалгүй мөнгөн хэлбэрээр оноож буй шийдвэрүүд юм.

Үүний нэг тод жишээ бол Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны эд хөрөнгө хураах ялын 2011 оны жилийн эцсийн тус ялын судалгаа юм.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны эд хөрөнгө хураах ялын хэрэгжилтийг өнгөрсөн 2011 оны байдлаар авч үзэхэд : - Шүүхээс

биелүүлбэл зохих 144 гүйцэтгэх хуудасны 47862.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгээс 12186.7 мянган төгрөгийн үнийн дүнтэй 51 гүйцэтгэх хуудсыг бодитой биелүүлж 35675.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй 93 гүйцэтгэх хуудасны үлдэгдэлтэй байна.

Эд хөрөнгө хураах ялын бодит биелэлтэнд нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл нь эд хөрөнгө хураах нэмэгдэл ялтай ялтнуудын дийлэнх хэсэг нь хорих ангиудад ял эдэлж байгаа бөгөөд ялын төрөл дэглэмээс хамаарч тухайн ялтныг хөдөлмөрийн бүтээмжтэй ажлын байраар хангаж цалин хөлснөөс нь суутгал хийх замаар эд хөрөнгө хураах ялыг биелүүлэх боломж төдий л хангалттай биш байгаа юм.

4.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа, бодит бэрхшээл.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд заагдсан ялыг биелүүлэх ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 99.1-д заасан заалтын шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор уг шийдвэрийн хувийг Шүүх тухайн этгээдийг ажил албан тушаалд томилсон, сонгосон эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд бичгээр мэдэгдэнэ гэсэн заалтыг зөрчиж, шүүх гүйцэтгэх хуудсыг бичиж, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шууд ирүүлж байна.

Мөн дээрх ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулахдаа гүйцэтгэх хуудсыг бичихгүй орхигдуулах явдал гарч байна.

Түүнчлэн уг ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулахдаа гүйцэтгэх хуудсыг бичихгүй орхигдуулах явдал нь тодорхой албан тушаал үйл ажиллага явуулах эрхийг хасах ялын талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөгдөхөд хүндрэл учруулж байгаа юм. Жишээлбэл: Шүүхээр жолооны эрх хасах ял дээр гүйцэтгэх хуудсыг харилцан адилгүй бичиж байна.

Тухайлбал: - Замын цагдаагийн газрын Мэргэжил хяналтын хэлтэс дээр 2011 онд нэмэгдэл ялаар жолооны эрх хассан шүүхийн шийтгэх тогтоол 305 ирсэн байхад Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шүүхээр

нэмэгдэл ял эрх хасах ялын гүйцэтгэх 55 ирсэн байх жишээтэй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухай ялтныг ажилд авсан, томилсон, сонгосон аж ахуйн нэгж, байгууллага ажлаас чөлөөлөх, эрх олгосон шийдвэрээ өөрчлөхгүй байх зэрэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Хууль зүй дотоод хэргийн сайдын 252 дугаар тушаалаар батлагдсан журмын заалтууд зөрчигдөх явдал нэлээд гарч байна.

Тухайлбал: Жолооны эрх хасах ялаар шийтгэгдсэн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавихад цагдаагийн байгууллагад албан бичиг тоот явуулахаас өөр эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Шийдвэр гүйцэтгэгч тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг хуульд зааснаар хэрэгжүүлж, хяналт тавих боломж муутай.

Жишээлбэл: Жолооны эрх хасах ял дээр тухайн эрх хасагдсан жолоочийг шийдвэр гүйцэтгэгч дуудан ирүүлж тайлбар авч, тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар холбогдох хууль, журмыг тайлбарлан сануулж, энэ талаар баталгаа гаргуулах боловч тухайн иргэнийг хөдөө, орон нутагт тээврийн хэрэгсэл жолоодон явж байгаа эсэхийг хянах боломж байхгүй, тэр ч байтугай хулгайн аргаар тээврийн хэрэгсэл жолоодон ямар нэгэн осол, зөрчил гарган цагдаагийн байгууллагад шалгагдаж байгааг ч хянах боломжгүй юм.

Гэтэл жолооны эрхийг Цагдаагийн байгууллага олгодог боловч эргээд эрх нь хасагдсан тохиолдолд олгосон эрхээ түдгэлзүүлэх, сэргээх, хойшлуулах ямар нэгэн зохицуулалт байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл гарч байна.

Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын замын цагдаагийн газар, тасагт хяналт тавьж, хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлэн ажилладаг ба хэрхэн яаж хяналт тавьсан талаар хариу ирдэггүй байна.

Цаашид хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар доорхи арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

1.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлүүлэх ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог өөрчилөх, ялын төрөл, хэмжээ, оногдуулж буй байдлыг өөрчлөн шинэчлэх, тухайлбал эд хөрөнгө хураах ялын хэмжээ, биелүүлэх хугацааг тодорхой болгох

2.Хорихоос өөр төрлийн ялын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүний дотор өнөөгийн мөрдөгдөж буй хууль, журмыг шинэчлэх, торгох ял шүүхийн практикийг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах.

3. Албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхэд ялтныг харъяа аймаг нийслэл, сум дүүргийн засаг дарга ажлын байраар хангах, жагсаалт гаргах, нийтэд мэдээлэх зэрэг асуудалыг шийдвэрлэхээр байгаа нь нийгэмд тустай ажил хөдөлмөр хийлгэх ялын үндсэн шинж чанар хэрхэн нийцэж байгаа эсэхийг эргэн харах цаг болсон байна.

Ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд Гадаад улсын хорихоос өөр төрлийн хэрэгжилт, туршилгыг судалж нэвтрүүлэх.

Эцэст нь хэлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоолыг биелүүлэх, түүний дотор зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг арилгах, баривчлах, хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг гүйцэтгэх үндсэн чиг үүргийг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд нэр төртэй гүйцэтгэж байна.

СЭТГЭЦИЙН ӨВЧТЭЙ БУЮУ СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ, ЭТГЭЭДЭД ЭМНЭЛЭГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ШИЙТГЭХ ТОГТООЛЫГ ГҮЙЦЭТГЭХ



Д.ЖАМЪЯАНДАГВА
ХСИС-ийн ЭШХ-ийн "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал" төвийн эрдэм шинжилгээний ажилтан

Сэтгэцийн өвчтэй буюу согтуурах, мансуурах донтой этгээдэд эмнэлэгийн чанартай арга хэмжээг хоёр төрлийн аргаар оногдуулж байна.

Энэ нь: нэгдүгээрт **Эрүүгийн,** хоёрдугаарт **Захиргааны** журмаар гэж ангилагдана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, түүний харьяа аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албадуудын хуулиар хүлээсэн чухал чиг үүргийн нэгэнд зүй ёсоор тооцогдох үүрэг нь албадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж, түүнд хяналт тавьж ажиллах явдал юм.

Архаг архичин ба мансуурах донтой этгээд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүхээс тэдэнд хорих, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэхээс гадна эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болдог байна.

Шүүхээс эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ, өөрийнхөө хийж буй үйлдлийг жолоодож, хариуцаж чадахааргүй сэтгэцийн өвчтэй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсөн,мөн согтуурах, мансуурах донтой этгээдүүдэд хэрэглэнэ.

Уг арга хэмжээг хэрэглэх тухай шүүхийн тогтоолд тухайн этгээдийг сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгийн алинд байлгаж

эмчлүүлэх тухай тодорхой заана.

Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийтгэх тогтоол гармагц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг цагдаагийн байгууллага, хэрэв уг этгээд баривчилах, хорих ял эдэлж байгаа бол ял эдлүүлж байсан баривчилах байр, хорих анги нь тус тус хүлээдэг байна. Ингэхдээ шүүхийн шийтгэх тогтоол, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад бичиг баримтыг хамтад нь хүргүүлнэ.

Хорих ялаар шийтгүүлсэн архаг архичин буюу мансуурах донтой этгээдийг хорих шардлагатай гэж үзвэл ял эдэлж байх хугацаанд нь албадан эмчилж болно.

Албадан эмчлүүлж байгаа этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эмнэлэгийн болон цагдаагийн байгууллага хамтран авч хэрэгжүүлэх үүрэгтэйг хуулиар хуульчилж өгсөн байна.

Албадан эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг этгээдийг цаашид үргэлжлэлүүлэн эмчлэх шаардлага байгаа эсэхийг сэтгэцийн эмгэг судлалын болон мэргэжлийн эмч нарын зөвөлгөөнөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах, уг арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа шүүхэд нэн даруй мэдэгдэх үүргийг шүүхийн холбогдох тогоол хэрэгжүүлэх байгууллага хүлээнэ.

Согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэс нь “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль ” –д заасан хэм хэмжээгээр зохицуулагдана.

Өвчтэй нь эмнэлэгийн дүгнэлтээр тогтоогдсон бөгөөд нийгмийн хэв журмыг зөрчсөн, сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн буюу эмчлүүлсэний дараа согтууруулах ундаа, мансууруулах бодис дахин хэрэглэсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт явуулж албадан эмчилнэ.

Албадан эмчилгээ хийлгэх этгээдээр эмчилгээ, үйлчилгээний зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлэх зорилгоор шүүхийн шийдвэрээр албадан

хөдөлмөр хийлгэж болохыг хууль тогтоомжид заажээ.

Албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяанд байх ба түүний мэргэжлийн удирдлагыг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ханган хэрэгжүүлнэ.

Албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газрын зардлыг улсын төсвөөс гаргаж байгаа бөгөөд үүнд төр засгаас маш их анхаарч байна.

Албадан эмчилгээнд согтуурах, мансуурах донтой этгээдийг ч хамруулж болохоор хууль тогтоомжид тусгасан ба албадан эмчилгээнд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрүүл мэндэд харшгүй эм бэлдмэлийг ашиглах, эмчлүүлэгчийн нууцыг хадгалах зэрэг нийтлэг зарчмыг баримтлан ажиллах нь зүйтэй.

Монгол Улсын Дээд Шүүхийн тайлбарт албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх талаар хуулийг маш нарийвчилан авч үзэж тайлбарласан. Үүнд:

1. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар согтуурах, мансуурах донтой этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт албадан эмчлүүлэхэд.

а/ тухайн этгээд согтуурах, мансуурах донтой өвчтэй болох нь мэргэжлийн эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон байх.

б/ тухайн этгээд нийгмийн хэв журам зөрчсөн байх,

в/ тухайн этгээд сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн эсхүл эмчлүүлсний дараа согтууруулах, мансууруулах бодис дахин хэрэглэсэн байх үндэслэл нэг дор бүрдсэн нөхцөлд тухайн этгээдийг энэ хуульд заасан журмын дагуу албадан эмчилгээнд хамруулна.

"Эмнэлэгийн дүгнэлт" гэдэгт ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн эмгэг, наркологийн гурваас доошгүй эмч нарын бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтийг ойлгоно.

"Нийгмийн хэв журам зөрчсөн" гэдэгт нийгмийн хэв журмыг зөрчиж, захиргааны арга хэмжээ авагдсан, эсвэл авагдаагүй боловч эрх зүйн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулна.

"Эмчлүүлсний дараа" гэдэгт согтуурах, мансуурах дон өвчнөөс ангижруулах зорилготой сайн дурын эсхүл албадан эмчилгээнд урьд өмнө

хамрагдаж байсныг хэлнэ.

2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан **"нийгмийн хэв журам зөрчсөн"** үйлдэлд нь захиргааны хариуцлага ногдуулах эсэх асуудлыг тухайн этгэдийг албадан эмчилгээнд хамруулах асуудлаас тусдаа Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэнэ.

3. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан **"шүүх шаардлагатай гэж үзвэл дээр дурдсанаас бусад материалыг шаардан авч болно"** гэдгийг энэ зүйлийн 6.1-д заасан хүсэлт, тодорхойлохт, дүгнэлтээс гадна тухайн этгээд урьд өмнө эмчилгээнд хамрагдсан эсэх болон захиргааны арга хэмжээ авагдаж байсан бол энэ тухай баримт, холбогдох гэрчийн мэдүүлэг зэрэг уг этгээдийг албадан эмчилгээнд явуулах зайлшгүй шаардлагатай болохыг нотлох аливаа баримтыг шүүх шаардах эрхтэй гэж ойлгоно.

4. Мөн зүйлийн 6.3-т заасан **"шүүх хуралдааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж, шүүхийн шийдвэр гаргана "** гэсний дагуу шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван гуравдуггар бүлэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар хүсэлтийг шийдвэрлэж, мөн хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.14 дэх хэсгийг шийдвэр гаргахдаа удирдлага болгоно.

Шүүх тухайн этгээдийн тайлбарыг сонсож, шийдвэрт тусгах боловч түүнийг хариуцагч гэж үзэхгүйгээс гадна согтуурах, мансуурах дон өвчтэйн улмаас албадан эмчилгээнд хамрагдах шаардлагатай болсон үйл баримтыг тогтоож байгаа тул тухайн хэрэгт эрх зүйн маргаан байхгүй учир мэтгэлцээн явагдахгүй.

5. Мөн зүйлийн 6.4-т заасан **"шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс нь хойш тухайн овчтэй этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааны дотор давж заалдах эрхтэй"** гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1-д "онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ" гэж заасантай нийцүүлж, эмчилгээнд хамрагдах этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь энэ зүйлд заасны дагуу шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргана гэж

ойлгоно.

Харин хүсэлт гаргасан этгээд хэргийн оролцогчын хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасны дагуу шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно.

6. Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д **"энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан овчтэйн улмаас албадан эмчлүүлж байгаа этгээдээр эмчилгээ, үйлчилгээнд нь гарсан зардлыг албадан хөдөлмөр хийлгэж, өөрөөр нь нөхөн төлүүлж болно"** гэж заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамрагдаж буй этгээд албадан эмчлэх журам, эмчилгээний горим зөрчсөнөөс эмчилгээний нэмэгдэл зардал гарсан, эмнэлэгийн дүрэм зөрчиж албадан эмчлэх байгууллагад хохирол учруулсан зэрэг тохиолдолд энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан зарчим, үндэслэлийн дагуу албадан хөдөлмөр хийлгэх, эмчилгээ, үйлчилгээнд гарсан зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

Албадан хөдөлмөрлүүлэх тухай хүсэлтийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар тухайн орон нутгийн анхан шатны шүүхэд гаргана.

7. Мөн зүйлийн 10.2-т заасан "албадан эмчилгээний хугацаанд гарсан зардлыг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын тодорхойлолтыг үндэслэн шүүхийн шийдвэр биелүүлэх журмаар гаргуулна" гэдгийг шүүх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан хугацаа болон албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газраас тодорхойлсон баримтыг үндэслэн албадан эмчилгээний зардлын хэмжээг шийдвэрт тус тус зааж, уг шийдвэрийг шүүхийн шийдвэр биелүүлэх журмаар гүйцэтгэнэ гэж ойлгоно.

8. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 –д **"албадан эмчлэх, албадан хөдолмөр хийлгэх газар нь эмчлүүлэгч этгээдийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан эмчилгээг хугацаанаас өмнө зогсоох тухай хүсэлтээ шүүхэд гаргаж болно"** гэж заасны дагуу албадан эмчилгээ, албадан хөдөлмөр хийлгэх газар нутаг дэвсгэрийн харъяаллын анхан шатны шүүхэд хүсэлт гаргана.

Энэ зүйл, хэсэгт "эмчлүүлэгч этгээдийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан" мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "тухайн этгээдийн

эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн" гэж тус тус заасныг мэргэжлийн эмч нарын дүгнэлтээр эмчилгээ бүрэн хийгдсэн, эсхүл хугацаанаас өмнө эмчилгээг зогсоох шаардлагатай альч тохиолдолд албадан эмчилгээний хугацааг шүүхийн шийдвэрээр дуусгавар болгоно гэж ойлгоно.

9. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1"д заасан албадан эмчилгээний хугацааг өвчний онцлог эмчилгээний үр дүнгээс шалтгаалан эмнэлэгийн байгууллага тогтооно. Шүүх шийдвэртээ албадан эмчилгээний хугацааг тогтоохгүй.

10. Мөн зүйлийн 12.2-т заасан **"мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлт"** гэдэгт ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн эмгэг, наркологын гурваас доошгүй эмч нарын бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтийг ойлгоно. Уг дүгнэлтээр өвчтөнд архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчилгээ оншилгооны стандартын дагуу эмчилгээ бүрэн хийгдсэн, эсхүл албадан эмчилгээ хийж болохгүй сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй болохыг тогтоосон байвал зохино.

11. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан **гомдлыг** эмчлүүлэгч этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгөч, албадан эмчлэх, албадан ходөлмөр хийлгэх газар нь нутаг дэвсгэрийн харъяаллын анхан шатны шүүхэд гаргана. Шүүх тухайн гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арвандөрөв дүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

12. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан баривчлах шийтгэлийг шүүх Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэврээр ногдуулна.

Баривчлах шийтгэлийн хугацааг албадан эмчилгээний хугацаанд оруулж тооцохгүй гэж тайлбарлсан байна.

1. А.Лхагва МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй УБ 2012 он 216-218 дахь тал

2. Төрийн мэдээлэл УБ 2007 он №13 334-336 дахь тал

3. А.Лхагва МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал УБ 2011 он

МОНГОЛ УЛСЫН ХОРИХ БАЙГУУЛАГЫН НИЙГМИЙН АЖЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Б.БАЯРСАЙХАН
ХСИС-ийн ШШГС-ийн багш, ахмад

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулага дахь нийгмийн ажлын хөгжилд санаа тавьдаг, нийгмийн ажил үйлчилгээг гар биеэр явуулдаг, дэмждэг та бүхний энэ өдрийн амгаланг ирье.

Энэ илтгэлийн зорилго нь Монголын хорих байгуулага дахь нийгмийн ажлын түүхэн уламжлалыг өнөөгийн нийтлэг гишүүдийн нийгмийн ажил саяханаас хөгжиж эхэлсэн гэх төсөөлөлийг бодит жишээ эх сурвалжинд тулгуурлан нийгмийн ажил Монгол улсад эртний түүхэн улбаатай бөгөөд нийгмийн хөгжлийн өөрчлөлтөнд зохих байр суурь эзлэж байсныг гарган ирж хорих байгуулага дахь нийгмийн ажил нь түүхэн улбаанаас хамаарч уламжлагдан шинчлэгдэж өнөөгийн шаардлага, практик онцлогт тулгуурлан хөгжиж буй хандлагыг тодорхойлохыг хичээлээ...

Монгол улсын төр оршин тогтнох түүхэн явцад гяндан, шорон байсаар ирсэн бөгөөд түүнд орших нийгмийн гишүүд /ард иргэд/-ийн тулгамдсан асуудлыг тухайн үеийн нийгмийн онцлогт тулгуурлан явуулж байсан. Нөгөө талаас нийгмийн гишүүдийн нийгмийн асуудлыг хариуцсан албан тушаалтан аль ч төрийн үед ажиллаж тэдгээрийн нийгмийн асуудлыг зохих /загвар/ түвшинд шийдвэрлэж байсан нь түүхийн эх сурвалжууд болон урьд нь мөрдөгдөж байсан хууль, эрхийн актуудаас тодорхой харагдаж байдаг.

Монгол Улсын нийгмийн ажлын нэгээхэн хэсэг болсон хорих байгуулага дахь нийгмийн ажлын түүхэн асуудлыг тусгайлан авч үзэхэд энэ талын үйл ажиллагаа 2003 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн гэж үзэх нь учир дутагдалтай байна.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2003 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн А/220 тоот тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, төвлөрсөн хорих ангиудад ажиллах нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт"-ыг батлан[17] гаргаж мөрдөж эхэлснээр энэ

[17] Монгол улс дахь нийгмийн ажлын хөгжил. УБ., 2008 он., 21 дэх тал.

талын үйл ажиллагаа мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ явуулах загварт шилжсэн гэж үзэх үндэстэй юм.

Судалгааны явцад Монгол уламжлалт ёс заншил, эрх зүйн түүхэн уламжлалаас хорих байгууллага дахь нийгмийн ажлын үйл ажиллагаа эртний уламжлалтай гэдэг нь тодорхой харагдаж байдаг. Мөн хүмүүсийн тусгайлсан нийтлэг болох ялтан, хоригдогч нарын нийгмийн харилцааг зохицуулан эрүүл, аюулгүй байдлыг нь ханган ял эдлүүлэх ажиллагааг явуулж ирсэн ШШГБ-ын түүхэнд нийгмийн ажлын үйлчилгээг нь хөгжлийн явцад өөрийн гэсэн онцлог, чадавхитай уялдуулан явуулж түүнд тулгуурлан хөгжиж байсан нь зайлшгүй юм. Эндээс Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийгмийн ажлын түүхэн мөн чанарыг нээн гаргаж ирэхийн тулд зарим нэг түүхэн эх сурвалжуудыг авч үзье.

1925 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар "Шинэ гянданг байгуулахын наана хуучин гяндангийн дотоод байдлыг арга эрэн засан сайжруулах дүрэм"[18]-ийн заалтанд ялтны эрүүл, ахуйн хангалт болон сурган хүмүүжүүлэх, суллагдсан ялтныг нийгэмшүүлэх талаар тусгасан байдаг. Жишээлбэл: Ялтны суух тасалгаа бүрд 15 лааны гэрэл нижгээдийг нийтийн нэгэн адил хэрэглүүлэх, ялтны суух байшин тасалгааны дотор хүйтэн нойтон чийг, элдэв муу үнэр, хорт бөөс байгаа зэрэг нь ямагт орших ялтны бие тэсвэрлэн суухад бэрх тул ялтны биеийг өдөр бүр нэг цаг гяндангийн хашаанд салхинд явуулан тэдний дэр дэвсгэрийг сар бүр 3 удаа салхинд гаргаж тусгай өлгүүрт өлгөж басхүү байшин тасалгааны хаалгыг нээж ариун салхи оруулж ариутгаваас зохино. Мөн дүрмийн арван нэгдүгээр зүйлд: Ялтан нарт лекц хэмээн сайн суртал журмыг одоо цагийн улс төрийн шинэ хуучин байдал зэргийг ялган салгаж тодорхойлон хэлж ухуулахуйц олон сургуулийн багш нар оюутныг болон сургуулийн шавь нар мэтийн эрдэмтнийг урин ирүүлж ухуулан гэгээрүүлбээс тустай бөгөөд одоо гяндангийн газар байшин савгүй тул энэ лекцийг өдрийн дулаан сайныг үзэж сар бүр хоёр удаа гяндангийн хашаан дотор ухуулан уншиж, сэнхрүүлэн хэрэглэвээс зохино.

Дүрмийн 12 дугаар зүйлийн 3-т "Ял дуусгаж гяндангаас гарах хүнд зохих ажил, үйлдвэр олж хийлгэх, аж төрөх амьдрах замыг олгоно" гэх

[18] БНМАУ-ын засан хүмүүжүүлэх ходөлмөрийн байгуулагын талаар гарсан хууль, эрхийн баримт бичгийн эмхэтгэл. А.Думбурай, А.Лхагваа, Л.Чүлтэмсүрэн. 1991 он., 8-12 дах тал.

мэтээр тусгайлан зааж өгсөн нь тухайн үеийн ялтнуудыг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд онцгой анхаарч байсны тод жишээ юм. Дээрхи эх сурвалжуудаас хархад суллагдаж буй ялтнуудыг нийгмийн амьдралд дасан зохицуулах үүднээс бичиг үсэгт сурган боловсруулан, ажил хийн бие даан амьдрах чадварыг суулган өгч байсныг харж болох юм.

Мөн 1929 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн засгийн газрын 19 дүгээр хурлын 1 дүгээр зүйл ба улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлын 2 дугаар зүйлээр баталсан " Аливаа хэрэгтэн ялтангаар ажил үйлдвэр хийлгэх тухай дүрэм"[19]-ээр гадагш гарч ажил үйлдвэр хийлгэх ялтны хувийн онцлогт тулгуурласан судалгаанд үндэслэн ялтны чадварыг харгалзан хөдөлмөрт хандах хандлагыг идэвхижүүлэн ажил хийлгэн тусгай хөлс олгож банкны салбар бүхий газруудад хоригдогсдын нэрийн дор тэмдэглүүлэн хадгалуулахаар заасан нь ялтан хоригдож байх хугацаандаа болон суллагдан гарах явцад өөрт шаардлагатай нийгмийн үйлчилгээг авах бололцоог нээж, төрийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлж байсан нь хорих байгуулага дахь нийгэмшүүлэх үйл ажиллагааны томоохон түүхэн илрэл болсон.

Эндээс харахад нийгэмшүүлэх үйл ажилагаа нь цаашид хорих байгуулагад мөрдөгдөж байсан үе үеийн хуулиудад тусгалаа олж энэ үйл ажиллагааг улс орны тухайн үеийн түүхэн хөгжилтэй нийцүүлэн ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагаа улам бүр боловсронгуй болон тасралтгүй хөгжсөөр байгаа нь харагдаж байна. Харин нийгмийн ажил гэсэн нэр томьёог 2003 оноос эхлэн хорих байгуулагад хэрэглэж эхэлсэн бөгөөд урьд нь сурган хүмүүжүүлэгч, ахуй дэглэмийн байцаагч /1999 он/ гэсэн нэрийн хүрээнд ялтан, хоригдогч нарт үзүүлэх нийгмийн ажлыг явуулж ирсэн байна. Монгол улсын хорих байгууллагын нийгмийн ажил нь нийгмийн ажлын онцлог загварт суурилсан нийгмийн ажлыг явуулан өнөөгийн шатанд хүрсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Нөгөөтэйгүүр одоогийн байдлаар энэ үйл ажиллагааг "Мэргэжлийн нийгмийн ажил" гэсэн нэр томьёоны хүрээнд хоригдогч нарыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд нийгмийн ажлын зааврыг боловсруулан 2012 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилэн найруулсан төсөлд энэ асуудлыг нарийвчлан тусган хэлэлцүүлж эхлээд байна. Энэ нь ялтан,

[19] Дурьдсан бүтээл. 15-19 дэх тал.

хоригдогч нартай ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг ажилуулах шаардлагын хүрээнд олон асуудлуудыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалт хүмүүжлийн хэлтсээс удирдан гүйцэтгэж байна.

Монголын нийгмийн хөгжилийн үе шатуудад хорих байгуулага дахь нийгмийн ажлын үйлчилгээ нь улс орны хөгжилтэй уялдан зохих хэмжээгээр явагдаж хөгжлийнхөө дараагийн шатанд хүрч байгаа нь мэдрэгдэж байна.

2012 оны 5 дугаар сарын байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагад 74 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 19 нь мэргэжлийн нийгмийн ажилтан, 55 нь бусад мэргэжилтэй нийгмийн ажилтан[20] ажиллаж нийгэмшүүлэх үйл ажиллагааг амжилттай явуулж байна.

Ингээд Хорих байгууллага дахь нийгмийн ажлын хөгжлийн шинчлэл, цаашдын чиг хандлагыг өргөн болон явцуу утгаар нь тодорхойлвол:

Нэг талаас нийгмийн ажлын хөгжлийн чиг хандлагыг авч үзэхийн тулд дэлхийн зарим орны хорих байгуулага дахь нийгмийн ажлын хөгжилтэй харьцуулан авч үзье.

Жишээлбэл: Герман улсад хорих байгуулагад ажиллаж буй харуул хамгаалалтын болоод бусад албан хаагч нар нь нийгмийн ажлын талаархи сургалтанд ямар нэг байдлаар хамрагдсан байдаг[21]. Тэнд хорих байгуулагад ажиллах албан хаагчдыг 6 сарын хугацаагаар сургалтанд хамруулан бэлтгэж үйл ажиллагааны явцад давтан сургалтыг нийгмийн хөгжилтэй уялдуулан зохион байгуулж байдаг нь хорих байгуулагад ажиллаж буй албан хаагч нарын ажлын ур чадварт нөлөөллөж нийгмийн хөгжилийн сөрөг хандлагаас хамаарч гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх дархалааг нөхцөлдүүлэн нийгмийн ажлын болоод хорих байгууллагын үйл ажиллагааг хэвийн явууллах чадварыг төлөвшүүлэх асуудалд анхаарч байдаг.

Харин Монгол улсын хорих байгууллагын нийгмийн ажил нь Монгол улсын нийгмийн хөгжил, хоригдогч нарын онцлогоос хамаарч ялтан, хоригдогч нарт явуулах нийгмийн ажил нь өөрийн онцлог, үйл ажиллагааны харилцан адилгүй орчинд хөгжиж байгаа боловч хорих байгууллагын нийгмийн ажилтны зүгээс хүмүүнлэгийн ажлын хүрээнд олон асуудлуудыг шийдвэрлэх нь зүйн хэрэг боловч цаашид энэ асуудлыг нарийвчлан авч үзэх

[20] ШШГЕГ-ын ялтны сургалт хүмүүжлийн хэлтсийн судалгаанаас. 2012 он., 2сар

[21] ШШГЕГын ялтны сургалт хүмүүжлийн хэлтсийн тайлан. "Герман улсын зарим хорих анги үйл ажиллагаатай танилцсан ажлын нэгдсэн тайлан". УБ., 2009 он.

шаардлагатай байна.

Монголын хорих байгууллагад хоригдож байгаа хоригдогч нартай ажиллаж буй нийгмийн ажилтан болон бусад албан хаагч нар нийгмийн болоод ялтан хоригдогч нарын хууль ёсны шаардлага, сэтгэхүйд нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвар, чадамж нь төлөвшлийн шатандаа явагдаж байна гэж үзэх үндэстэй юм. Үүнийг нийгмийн хөгжилтэй шууд холбон авч үзэх шаардлагатай.

Социалист нийгмийн тогтолцоотой байх үед тухайн нийгмийн онцлог нь ялтан, хоригдогч нарыг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд эерэг нөлөөлөл үзүүлж байсан нь зайлшгүй бөгөөд шилжилтийн үед ялтан, хоригдогч нарын нийгмийн асуудалд тэднийг тураж, өлсгөж, өвчин тусган үхүүлэхгүй байх бүхий л боломжинд тулгуурлан нийгмийн ажил үйлчилгээг явуулж ирсээр өнөөгийн шатанд хүрч ирсэн.

Үүнд нийгмийн хөгжил, хоригдогч нарын сэтгэхүй, ар гэрийн байдал, хүмүүжил, төлөвшил зэрэг нь ялгаатай нөхцөл байдлыг нөхцөлдүүлж байсныг харж болох юм.

Цаашид Монголын хорих байгуулагын нийгмийн ажлыг нийгмийн хөгжил, нийгмийн гишүүдийн сэтгэхүйн өөрчлөлттэй холбогдуулан авч үзхэд олон онцлог асуудал урган гарч ирсээр байдаг. Үүнд:

- хоригдогч нарыг хорихоос суллагдаад нийгмийн шинэ нөхцөл байдалд дасан зохицож амьдрах чадварыг Монгол улсын нийгмийн амьдралын онцлогт тохируулан нийгмийн ажлыг чиглүүлэн тохирсон арга /технологи/-ыг цаг алдалгүй тухай бүр оновчтой хэрэглэж байх нь нэн чухал шаарлагатай.

- зарим судлаачид хорих байгуулагын нийгмийн ажилтанг бусад мэргэжлийн нийгмийн ажилтануудтай адилтган авч үзэн хорих байгууллагын нийгмийн ажилтанг тусгайлан бэлтгэх шаардлагагүй гэсэн үзэл бодол байдаг нь нийгмийн ажлын шаардлагыг өнөөгийн хорих байгуулагын практик үйл ажиллагаатай уялдуулан авч үзэхэд энэ нь нарийн төвөгтэй үйл ажиллагаа бөгөөд учир дутагдалтай байгаа нь харагддаг тул хорих байгуулагын / нийгмийн ажилтан/ болон ялтан хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах үүднээс хорих байгуулагад ажиллах нийгмийн ажилтанг тусгайлан бэлтгэх шаардлагатай байна.

- ялтан хоригдогч нарын нийгмийн асуудлыг явцуу байдлаар шийдвэрлэх

нь Монголын хорих байгуулагад хоригдож байгаа ялтан, хоригдогч нар нь хэт их бэлэнчлэх сэтгэхүйд автан өөрсдийн нөөц боломжийг дайчлахгүй байх явдал Монгол хүний амьдрах чадварыг сулруулан цаашлаад эх орны аюулгүй байдалд шууд харшлах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй тул энэ асуудлыг төрийн бодлогод хамаатуулан авч үзэх хэрэгтэй.

- хорих байгууллагын нийгмийн ажил үйлчилгээг хорих ангийн талаар практик мэдлэг сайтай, маш чадварлаг /бие хамгаалах, хорих ангийн онцлог харуул хамгаалалтыг мэддэг, эх оронч сэтгэлтэй, нийгмийн ажилтны баримтлах зарчим, ёс зүйг хорих байгууллагын нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлэх чадвартай/ албан тушаалтан гүйцэтгэх нь хорих байгуулага дахь мэргэжлийн нийгмийн ажил үйлчилгээний хөгжлийн дархлааг тогтооход чухал ач холбогдолтой.

- нөгөөтэйгүүр хорих ангид албан үүрэг гүйцэтгэж байдаг албан тушаалтангууд нь цаг наргүй төрийн тусгай үүрэг гүйцэтгэн сэтгэл зүйн болоод биеийн аюултай нөхцөл байдалд ажиллаж амьдардаг тул энэ асуудлыг хариуцсан мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллах нь зайлшгүй шаардлагатай. Энэ нь дан ганц хоригдогч нарын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх нь учир дутагдалтай бөгөөд эдгээр нийгмийн ажилтнуудын ажлын уялдаа холбооноос хамаарч үл ойлголцолын асуудлаас урьдчилан сэргийлж төрийн үйлчилгээг нэг мөр шуурхай явагдах гол үндэс нь болж болох юм.

Цаашид Хорих байгууллагын нийгмийн ажлын үйлчилгээг улам бүр боловсронгуй болгон өргөжүүлэн тэлснээр бусад нийгмийн ажил үйлчилгээтэй холбогдож нийгмийн хамгаалалын цогц үйл ажиллагааг нөхцөлдүүлэн Монголын хорих байгууллагын нийгмийн ажлын онцлогт суурилсан нийгэмшүүлэх үйл ажиллагааны нэг томоохон чиг хандлага, үйл ажиллагаа болохыг үгүйсгэх аргагүй юм.

Энэ нь ялтан хоригдогч нарын нийгмийг үзэх үзэл бодлыг зөв төлөвшүүлэх үүднээс улс орны хөгжилтэй уялдуулан тэднийг нийгмийн гишүүдийн нэгэн адил амьдрах чадварыг нь идэвхжүүлэн, нөлөөлөх арга хэмжээг шат дараалан авах нь Монгол улсын хөгжил, нийгмийн хамгаалалд томоохон ахиц дэвшил гарна гэдэгт итгэлтэй байна.

Анхаарал тавьсанд баяраллаа.

ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ



Р.ОЮУНБАДАМ
/Монгол Улсын гавъяат хууьлч,
Шихихутуг ХЗДС-ийн багш

Улсын хэмжээгээр төрөл дэглэмийн хорих ангиудад жилд дунджаар 6800-7000 хоригдол ял эдэлж байна. Түүний 7% нь эмэгтэйчүүд 75 % нь залуучууд 0.6% нь насанд хүрээгүй хүмүүс байна. Үүнээс 2120 хүн буюу 34 % нь хорих газраас суллагдаж, 2998 хүн шинээр хорих ял эдэлдэг. Нийслэл болон орон нутгийн урьдчилан цагдан хорих төвүүдэд дунджаар 1200-аад сэжигтэн яллагдагчид хоригдож байгаагийн ... % нь хэрэг нь хэрэгсэхгүй болдог. Түүнээс илүү хувь нь шинээр урьдчилан хоригддог гэсэн бодит статистик байна. **Муу ёрын тойрог** гэмээр нийгмийн энэ үзэгдлийн цаана хүний эрх, хүний зовлон зүдгүүр, ааш, араншин хүсэл, хясал бүхэн хорих, цагдан хорих байгууллагын ажилтны нүдэн дээр болж байдаг төдийгүй тэр болгоныг хэрхэн зохицуулах, яаж харьцах зэрэг хүндхэн хариуцлагатай тулгарна. Хоригдсон, цагдан хоригдсон нийт хүнийг хүн амын тоонд авч үзэхэд олон улсын хэмжээнд нилээд өндөр үзүүлэлттэй байна. *Аливаа этгээдийг үйлдсэн гэмт хэрэгт нь шийтгэх ба гэмт хэргийн сэжигтнээр татахад тухайн хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхүүдээ алдах эрсдэлтэй байдаг. Хувь хүн эрүүгийн хариуцлагад татагдаж шүүхийн өмнө зогсохдоо тухайн этгээд бүхэл бүтэн төрийн аппарат цагдаагийн байгууллага, байцаалтын өрөө, цагдан хорих байр, шүүхийн танхим, хорих ангитай нүүр тулдаг.* Сэжигтнээр татагдсан мөчөөс эхлэн, баривчлагдах, саатуулагдах, мордөн байцаагдах, шүүх ажиллагаа болон давж заалдах зэрэг байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд хүний эрх зорчигдох өндөр эрсдэлтэй байдаг. Шүүхээс өмнөх шатанд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийн эрхийг хэрхэн хамгаалах вэ

гэдэг асуудал өнөөдөр хуульчдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Аливаа хэлбэрээр хоригдсон болон саатуулагдсан хүмүүсийн дотроос хамгийн нарийн төвөгтэй, хамгийн маргаантай нь урьдчилан цагдан хоригдогчийн асуудал гэвэл маргах хүн гарахгүй байх. Урьдчилан цагдан хоригдогчид гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй учраас тэдгээр хүмүүстэй хуульд заасан хязгаарлалаас гадна аль ч шатанд хэтрүүлэн харьцах боломжгүй. Илүү иргэнлэг харьцаатай байхыг шаардана. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндэслэн журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасан. Хэдийгээр хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлаж байгаа ч гэсэн баривчлах ажиллагааны хэм хэмжээг хэтрүүлбэл **дур мэдэн** баривчлахтай адилтган үздэг. ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан "**дур мэдэн**" хэмээх нэр томъёог зөвхөн хууль бус хорьж саатуулахыг хэлээд зогсохгүй **хүч хэтрүүлсэн, шударга бус болон хойшлуулшгүй эсхүл таамаглах аргагүй гэсэн нөхцлүүдийг агуулсан** илүү өргөн агуулгатай гэж тайлбарласан байна. ИУТЭОУПактаар Хоригдсон буюу саатуулагдсан хүмүүст хүч хэтрүүлэн хэрэглэхийг хориглосон байдал бүх нөхцөлд хориглох боломжгүй юм. Учир нь хууль сахиулагч албан тушаалтнууд **гарцаагүй тохиолдолд үүргээ биелүүлэхэд шаардлагатай хэмжээгээр хүч хэрэглэж болно.** Тухайлбал хоригдлууд оргон зайлахыг завдсан болон бусад хууль ёсны хэв журам зөрчигдөж өөрт нь болон бусад хүмүүсийн амь насанд аюул заналхийлсэн ноцтой хүнд хохирлоос хамгаалах тохиолдолд хүч хэрэглэж болохыг дурьджээ. Сэжигтэн яллагдагчийг баривчилж хорьж саатуулахдаа тэдний хэргийг мөрдөн байцааж байгаа албан тушаалтнууд зөвхөн хуулийн дагуу олгодог бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллах ёстой. Олон Улсын Хүний эрхийн хэм хэмжээ нь хүнийг хууль бусаар дур мэдэн баривчлаж эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх болон албадан саатуулагдсан үед гарч болох бусад хэлбэрийн зөрчил гарахаас давхар хамгаалсан байдаг.[22] Аливаа улс хуульдаа ямар албан тушаалтан хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй болохыг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Албан тушаалтан хийсэн үйлдэлдээ ялангуяа баривчлах, хорих ял оногдуулах зэрэгтээ хариуцлага хүлээх нөхцлүүдийг

[22] "Шударгаар шүүгдэх эрх" Эмнести Интернэшнл, 2012 он, 24 дэх тал

тусгах хэрэгтэй.[23] Эдгээрийг шүүхийн өмнөх шатанд заавал хийгдэх ёстой ажлууд гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үндсэн зарчмуудад зааж өгсөн байна. Нийгмийн сэтгэл зүйд цагдан хоригдож байгаа хүн бол эрх чөлөөгүй хүмүүс гэсэн ойлголт байдаг. Тэгвэл тэд бусдын нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх учиртай. 1992 онд Монгол улсын Үндсэн хууль Монгол улсын иргэн бүр халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөтэй байх, Амьд явах эрхтэй гэж заасан нь хоригдож байгаа болон цагдан хоригдож байгаа хүнд нэн хамаатай. Эдгээрийн дотроос **халдашгүй дархан байх** эрхийг дараах байдлаар тайлбарлаж байна.

- Хоригдогчид хоригдож байх хугацаандаа эрүү шүүлт хилсээр хэрэгт тулгуулахгүй байх
- Хэн нэгний дарамт шаардлагад өртөхгүй байх
- Тэдэнд сэтгэл санааны дарамт учруулахгүй байх
- Эрүүл мэндээ хамгаалуулах
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг ойлголт зэргээр тайлбарлагдана.
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн хувьд сэжигтэн, яллагдагчид олгогдсон эрх эдлэх, үүрэг хүлээх
- Мэдээлэл авах
- Гадаад ертөнцтэй харилцах
- Өөрийн зараамал эрхээ хангуулах гэх мэт. Хоригдох нөхцөл журамтай холбогдуулан олон эрхүүдийг дурьдаж болно.

Жишээ нь нөхцөл сайтай байранд амьдрах, биологийн хэрэгцээ болон алдсан энергийг нөхөх хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, ундны усаар хангуулах, эмнэлгийн үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон зүйл багтана.

Даяарчлалын эрэн үед Монгол Улс зөвхөн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний эрхийг хамгаалах асуудлын талаар авч үзэх нь явцуу асуудал учраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийг мөрдөх. бусад орны сайн туршлагуудыг өөрийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлэх боломжуудыг бүрдүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна. *Олон улсын баримт бичигт хорих цагдан хорих газар бол заавал хянах ёстой газар*

[23] "Шударгаар шүүлгэх эрх" Эмнести Интернэшнл, 2012 он, 24 дэх тал

гэж үздэг. Яагаад хянах ёстой вэ? гэвэл: Шүүхийн өмнөх шатанд гэмт хэрэгт сэжигтэн яллагдагчаар татагдахад хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхээ алдах эрсдэлтэй байдаг. Иймд сэжигтэн ялдагчдийн эрхийн зайлшгүй хамгаалах шаардлагатай болдог. Шүүхийн өмнөх шатанд байгаа гэдэг утгаараа сэжигтэн яллагдагчийн эрхийг хамгаалах, тэдэнтэй харьцах талаар илүү болгоомжтой харьцах учиртай.

Хүүльдзаасанэрхийгхамгаалахынзэрэгиээзаяамалэрхийгньхөндөхгүй нэр төрийг нь сэвтүүлэхгүй байхад анхаарах нь ардчилсан төрийн албан хаагчдын ёс зүйн болон мэргэжлийн өндөр түвшинд ажиллах үр чадвар юм. Хуулийн дагуу хоригдож буй хүмүүсийн эрх, эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдана. Тухайлбал гадагш зорчих, эвлэлдэн нэгдэх эрхээ хязгаарлуулна. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдож байгаа ч түр саатуулагдаж байгаа хүмүүс, хоригдлууд нь хяналтын дор байдаг учраас эмзэг байдаг. Хоригдож байгаа этгээдийн эрхийн зарим хязгаарлалт нь түүний хувь заяанд нөлөөлсөн байдаг. Хуулинд тодорхойлсноор хорих цагдан хорих төв нь хаалттай бус юм. Тиймээс хоригдогч нийгмээс тусгаарлагдаж нийгмийн нөлөөллийн гадна үлддэг. Хорих ял эдлэгсэд нь хоригдож байгаа газраа ямарч цаг үед ширүүн догшин харьцаа амсах, эрүү шүүлтэнд өртөж болзошгүй байдаг. Хорих ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр юм. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай Монгол улсын хууль болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд сэжигтэн яллагдагчийг хүлээн авах тухай хангалттай заалтууд тусгалаа олсон хэдийч заавал биелүүлэх шаардлагуудыг хангасан байвал зохино. Эдгээрийг харьцуулан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мэдээлэл авах эрх. Хоригдох этгээдийг хүлээн авахдаа шалган нэвтрүүлэх байрны харуул, ээлжийн дарга нар цагдан хорьж байгаа албан тушаалтныг байлцуулан үзлэг хийж, хориотой эд зүйлсийг хураан авч, тэмдэглэл хөтлөн холбогдох этгээдээр гарын үсэг зуруулна. Хоригдох этгээдийг хүлээн авсан тухай лавлагааг жижүүрийн туслах хөтлөх бөгөөд хүлээлгэн өгсөн албан тушаалтнаар лавлагаанд гарын үсэг зуруулна. Лавлагаанд уг этгээдээс баривчлах, хорих болсон шалтгаан, цагдан хорих гэж байгаа газрын талаар түүний ар гэрийхэн, төрөл төрөгсөд болон өмгөөлөгчид нь албан ёсоор мэдэгдсэн эсэх талаар лавлаж тэмдэглэл

үйлдэнэ. Хоригдох этгээдэд хорих байрны дотоод журам, цагийн хуваарь, сахилгын шийтгэл ногдуулах журам, эрх, үүргийг нь тоо бүртгэлийн ажилтан танилцуулж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Хоригдох этгээдэд дээрх мэдээллийг бичгээр гаргаж өгнө. Жижүүрийн туслах уг мэдээллийг бичиг үсэг мэдэхгүй хүнд тайлбарлан өгөх үүрэг хүлээнэ[24] гэж манай хууль журамд заасан бол Олон улсын баримт бичигт: Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед нь мэдээлж аливаа сонгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой. Эрүүгийн хэргээр яллагдаж байгаа бүх хүн өөрийнхөө өмгөөлөгчтэй найдвартай уулзах цаг байрны нөхцлөөр бүрэн хангах ёстой[25] гэжээ.

Гадаад ертөнцтэй харилцах бусадтай уулзах эрх. Албан тушаалтны албан ёсны зөвшөөрлийг үндэслэн 7хоногт 2 удаа 10-17 цагийн хооронд уулзах цагийн хуваарийг хорих ангийн дарга батална. Хоригдсон этгээдийг 1 удаагийн уулзалтаар уулзах түр хугацааны уулзалтыг 20 минутаас хэтрүүлэхгүй байхыг харуул хаамгаалалтын ажилтанд хяналт тавьж хорих байранд хориглосон зүйл дамжуулахыг хориглоно. Хоригдсон этгээдийг бусадтай уулзахад нь иргэний бичиг баримтыг тоо бүртгэл дээр нь шалгаж найз нөхөд төрөл садангийн хүн мөн эсэхийг тулгаж шалгана[26] гэж Монгол улсын хууль журам үздэг бол НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12-р сарын 09-ний өдөр 43\173–р тогтоолоор батлсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-ын 19 дүгээр зарчим, НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаар анхны их хурал дээр 1955 онд батлсан "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм" 37 дугаар зарчмуудад гадаад ертөнцтэй аль болох илүү холбоотой байхыг зөвшөөрч хөхүлэн дэмжих нь зүйтэй. Уулзалтын нөхцөл нь аюулгүй байдлын шаардлага ба хүний нэр төрийг хүндэтгэсэн байх ёстой. Гэр бүлтэйгээ тусдаа уулзах өрөө тасалгааг урамшуулан дэмжих ёстой. Хоригдогчид зөвхөн гэр бүл, найз

[24] Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам 2011 он ШШГЕГ. Харуул хамгаалалтын ажилтанд зориулсан гарын авлага, 88 дахь тал

[25] НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12-р сарын 9 ний өдөр 43\173 –р тогтоолоор батлсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-ын 13-р зарчим;

[26] Баривчлах цагдан хорих байрны дотоод журам 2011 он ШШГЕГ харуул хамгаалалтын ажилтанд зориулсан гарын авлага 94 дахь тал

нөхдөөс гадна хуульч болон шүүхийн байгууллагын ажилтнуудтай уулзах эрхээр хангагдах ёстой гэж үзжээ. Мөн АНУ-ын өмнөд мужийн Луизиана, Миссисипи, Алабама мужийн цагдан хорих төвүүд болон засан сайжруулах газрууд сонин сэтгүүлтэй байдаг. Тэнд дүрэм, журам хоригдогчийн хүмүүжил, өөрийн үйл ажиллагааны талаар нийтэлдэг Идэвхитэн бичигч хоригдлуудтай юм билээ. Албама мужийн баруун Мобайлын төв гяндангийн хэрэгтэн, сэжигтний мөрдөх дүрмийн хэсгээс дурьдвал

• Хоригдлууд өөрсдийн уулзахыг хүссэн 3-аас илүүгүй хүний нэрсийг бичүүлэх боломжоор хангагдсан байх

• Эргэлт уулзалтаар ирэгсэд гяндангийн захиргаанд урьдчилан уулзалтын цагаа мэдүүлэн тохиролцсон байх ёстой.

• Уулзалтаар ирэгсэд уулзалт эхлэхээс 10 минутын өмнө ирсэн байвал зохино[5] гэжээ.

Мэдээж хэрэг бусад орны дүрэм журмыг дуурайх, хуулбарлахыг чухалд үзээгүй. Гэвч анхааран үзэх зүйл олон байна. Уулзалт хийлгэх ажилтан болон уулзалтад оролцогч нарт аль нэгэнд нь ямар нэг хүндрэлгүй зохицуулсан, уншихад ойлгомжтой, хэрэгжүүлэхэд хялбар, үг хэллэг нь энгийн тэгсэн байтлаа дүрэм журмыг зөрчих боломжгүй байна. Хоригдож буй этгээдүүд хэзээ нэгэн цагт эрх чөлөөтэй болохыг мартах аргагүй зүйл бөгөөд эргэлт уулзалт бол хамгийн сайн харилцаа байдаг тул хоригдогчийн бусадтай уулзах, захидал харилцаатай байх хууль журмын дагуу утсаар ярих боломжтой байх зэрэг нь тэднийг нийгмийн амьдралд буцааж ороход нь хамгийн сайн үр дүнтэй арга юм. Гэвч хэмжээнээсээ хэтэрвэл амьдрал дээр сөрөг үр дагавар олныг дагуулдаг. Жишээ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар жирийн дэглэмд ял эдэлж буй хоригдол бусадтай түр хугацаагаар уулзахад хязгаарлал тогтоогоогүйгээс ялангуяа эмэгтэй хоригдлууд хувийн хэрэгтээ бараг 20-30 түүнээс ч илүү хүн бичүүлсэн байх тохиолдол байдаг. Ар талдаа бололцоотой, хэргийн хувьд ихэвчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн зарим хоригдол шүүхээс оногдуулсан хорих ялын 20 гаруй хувийг гэр бүл найз нөхөдтэй уулзаж, эргэлтээр ирсэн зүйлийг идэж ууж, элдвийг ярилцан өнгөрөөж байгааг судалгаагаар тогтоосон зүйл. Энэ нь сайн талтай ч нөгөө талдаа хорих байгууллагын ажилтны ажлын чанартай цагийг барсан, хохирогчийн гомдол дагуулсан, ял завших сул талтай.

Хоол хүнсний хангамж үйлчилгээ: Хоригдсон этгээдэд өгөх цай хоол өдөрт 2 удаа халуун хоол 3 удаа цай 1 удаа гурилан бүтээгдэхүүн хоногийн хоолны илчлэг нь 3400 ккл-аас багагүй байна нэг удаа олгох цай 1.5 л хоол 0.5 литр гэжээ.[27] НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харьцах асуудал 1955 онд батлсан хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм 20 дугаар дүрэм: Шоронгийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдогч бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалах хангалттай тэжээллэг, сайн чанарыг сайтар бэлтгэсэн хоол ундаар хангах ёстой. Хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундааны устай байх ёстой. Хоригдлын хоолны амт чанар, хэмжээ, нэр төрлөөрөө хоригдогчийн эрүүл мэндийг хангахуйц байх ёстой гэжээ.

Ариун цэвэр, цагаан хэрэглэл: Халуун усанд 14 хоногт нэг удаа орно. Усанд ороход шаардагдах ариун цэврийн хэрэгсэл саван бусад хэрэгслийг өөрсдөө хариуцна. Хувцас цагаан хэрэглэлийг 14 хоногт 1 удаа нэгдсэн угаалгахад авна[28] гэжээ.

Цагдан хорих төвүүдэд жилд дунджаар .... эмэгтэйчүүд хоригддог. Тэд сэжигтний, яллагдагчийн, давж заалдах хугацаанаас хамаараад янз бүрийн хугацаанд хамгийн багадаа 14 тэгээд цаашдаа хэдэн сар жилээр ч хоригдох тохиолдол бий.

Гэвч эмэгтэй хүнийг цагдан хорих нөхцөл журам тухайлбал хоол хүнс, хувцас, ариун цэвэр эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэх мэт олон асуудал нь зайлшгүй онцлог зохицуулалттай байх ёстой. Харамсалтай нь манай хууль, дотоод журамд эмэгтэй хүний талаар, жирэмсэн эмэгтэйн талаар ганц хоёр зүйл дурьдсанаас өөр зүйл ороогүй байна. Харин жирэмсэн биш бусад эмэгтэй хоригдогчийн онцлогт нь тохирсон зохицуулалт үгүйлэгдэж байна.

НҮБ 1955 онд жишиг дүрэм: Эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хэрэгсэл тавьж олгох нь зүйтэй. Хоригдогчийн хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй. Хувцас нь цэвэр бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас

[27] Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 95 дахь тал

[28] Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 93 дахь тал

тавьж олгож байвал зохино. Эмэгтэйчүүд хувийн ариун цэвэр сахих үүднээс хэвийн болон сарын тэмдэг үзэгдэх үед шаардлагатай хэрэгслээр тогтмол хангагдах ёстой гэж үзсэн.

Эмнэлгийн үйлчилгээ: Хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх халдваргүйжүүлэх, ажлыг эрүүл мэндийг хамгаалах холбогдох хууль тогтоомжуудад заасны дагуу явуулна. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй.

• Хоригдсон этгээд хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан тохиолдолд хорих захиргаа нь түүний ойрын төрөл садан болон хорих шийдвэр гаргасан албан тушаалтан прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

• Хоригдсон этгээд нас барсан тохиолдолд цогцост шүүх эмнэлгийн задлан хийсний дараа ар гэр, төрөл садны хүмүүст шилжүүлнэ. Цогцосыг ирж авах тухайн хорих байрны зардлаар оршуулна[29] гэсэн байна.

Олон улсын конвенцоор цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийн амьдралаар амьдрах боломж олгодоггүй учраас хоригдогчдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжиж байх нь чухал. Эрүүл мэндийн үйлчилгээ нь эрх чөлөөт амьдралдаа авдаг үйлчилгээнээс ялгагдах ёсгүй. Хорих цагдан хорих газрууд эмэгтэйчүүд онцгой хэрэгцээнд муу зохицсон байдаг. Цагдан хорих байрны эмнэлгийн ажилтнууд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах, эмэгтэйчүүдийн эмнэлгийн үйлчилгээг баталгаатай авдаг байх ёстой[30] гэжээ. Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих тухай түүнд нийцүүлэн гаргасан дотоод журам хоригдогчийн хорих нөхцөл журам өргөн агуулгаар хуульчилжээ. Мэдээж хэрэг хүн амьдрах нөхцөл боломжийг хангах нь цөөн хэдэн зүйлээр хязгаарлах асуудал биш юм. Гэвч хүний заяамал эрхийг хангахаас эхлээд амьдралд тохиолдох бүхий л зүйлийг хуульчлахыг чухалд үзэж байгаа нь нэг талаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, нөгөө талаар хэдийгээр хоригдож байгаа бол... хүний амьдрал өргөн учир тэр болгоныг хууль журмаар заагаад байх нь ач

[29] Сэжиггэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх хууль, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 69 дэх тал

[30] Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг , аргачилсан удирдамж 2006 он, 126-130 дахь тал

холбогдолгүй гэж үзээд хорих, цагдан хорих газарт

Эрүү шүүлт ба хүнлэг бусаар харьцах тухай асуудал: Эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг ямар ч нөхцөл байдал зөвтгөж чадахгүй. Эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гуравдагч этгээдээс мэдээ сэлт мэдүүлэг авах тухайн хүн буюу гуравдагч этгээдийн үйлдсэн сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэх буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу 3 дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шалналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Мөн манай улс 2000 оны эцсээр " Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийн хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орсон. Ардчилсан нийгэмд нийгмийн суурь үнэт зүйлийг хуулиар сахин хамгаалдаг. Тэдгээрийн хамгийн чухал нь хүмүүний төрөлхийн заяамал нэр төрийг тэдний хувийн болон нийгмийн байдлаас үл хамааран хүндэтгэн үзэх явдал юм. Хүмүүнийг хэр зэрэг эрхэмлэн үзэж байгаа нь аливаа нийгэмд эрүүгийн хуулийг зөрчсөн эсвэл зөрчсөн гэж буруутгагдаж байгаа хүмүүст хэрхэн хандаж байгаагаар илэрнэ. Эдгээр хүмүүс нь өөрсдөө бусдын заяамал нэр төр эрхийг хүндэтгээгүй хүмүүс мөн. Гэвч хорих газрын ажилтнууд нь тэдний хийсэн хэргийг эс харгалзан нийгмийн нэрийн өмнөөс хүндэтгэн үзэх онцлог үүрэг хүлээдэг. Хорих үйлчилгээ нь эрүүгийн шүүхийн тогтолцооноос иргэний заяамал эрхэд хамгийн ихээр нөлөөлдөг бүрдэл хэсэг юм. Тиймээс хорих газрын харгалзагч бороохой гозогнуулан хоригдлуудын дундуур явах зэрэг бүхий л төрлийн дээрэнгүй харьцах харьцааг хориглодог.

Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих тухай Монгол улсын хууль түүнд нийцүүлэн гаргасан цагдан хорих байрны дотоод журам нь хоригдогчийн эрх зүйн байдал, ахуй нөхцөл, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг өргөн агуулгаар хуульчилжээ.

Мэдээж хэрэг хүн амьдрах нөхцөл боломжийг хангах нь цөөн хэдэн зүйлээр хязгаарлах асуудал биш юм. Гэвч хүний заяамал эрхийг хангахаас эхлээд амьдралд тохиолдох бүхий л зүйлийг хуульчлахыг чухалд үзэж байгаа нь нэг талаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөгөө талаар хэдийгээр

хоригдож байгаа боловч хүний амьдрал баян учир тэр болгоныг хууль журмаар заагаад байх нь ач холбогдол багатай билээ. Хамгийн гол нь Монгол улсад хорих ял эдлүүлэх болон сэжигтэн яллагдагчдын баривчлах цагдан хорих хууль, журмаас гадна хорих, цагдан хорих газарт хүн хорих үйл ажиллагаатай холбоотой зарим нөхцлүүдийг тухайлбал орон байр, гэрэл, дулаан, хоол хүнс, эмнэлгийн үйлчилгээ, эргэлт уулзалт гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхэд ***оорийн онилогтоо тохирсон үндэсний стандарт үгүйлэгдэж байна. Үүнийг Олон улсын баримт бичигт хүний эрхийн стандарт гэж тэмдэглэсэн байдаг. Үндэсний стандарттай болсон нөхцолд бүх зүйлийг хуулиар зохицуулах шаардлага гарахгүй давуу талтай.*** Иймд манай өнөөгийн мөрдөж байгаа хууль тогтоомжоо эргэн харж цаашид боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай монгол улсын хуулийн бүлэг зүйлийн 70 шахам хувь нь цагдан хорих шийдвэрийг биелүүлэх байгууллага, ажилтны эрх үүргийг хуульчилжээ. Хүнлэг ардчилсан нийгмийг цогцлоон байгуулж буй өнөө үед хүнээ нэн тэргүүнд тавих зарчим үйлчлэх ёстой. Иймд хоригдож байгаа хүний эрхийг хорих цагдан хорих газар хэрхэн хангахыг дараа нь түүнийг хэрэгжүүлэх байгууллага, ажилтнууд ямар журмаар ажиллах тухай хуульчилж өгөх нь тохиромжтой. Практик дээр хууль хэрэгжүүлэх механизмыг тогтоож өгөхийн оронд журмаар хуулийн нилээд хэсгийг хуулаад цаас эзлүүлж хүн уншихад хэт өргөн болгодог байдал ажиглагдаж байна. Хорин нэгдүгээр зуун бол цахим нийгэм учраас хүмүүс цаас унших дургүй цаг алдана гэж үзэх болсон. Үг хэллэг нь орооцолдсон урт байдгаас ойлгомжгүй уншихаас төвөгшөөдөг сул талтай. Зөвхөн дотоодын хууль журмандаа захирагдах байдлаар мэргэжлийн төвшингөө тогтоох бус даяарчилсан өнөө үед олон улсын хорих байгууллага дээр юу болж байна гэх мэтчилэн хүний эрхийн мэдрэмжтэй байх нь мэргэжлийн ур чадварыг тодорхойлох нэг үзүүлэлт болно.

ЭРХ ЗҮЙТ ТӨР БА ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ



О.БАТСАЙХАН
ХСИС-ийн ШШГС-ийн багш, ахмад

Эрх зүйт төр гэж ямар ойлголтыг хэлэх вэ? - "Эрх зүйт төр" /Rechtstaat/ хэмээх нэр томъёо нь XIX зууны эхний хагаст Германы хууль, эрх зүйн зохиол бүтээлд анхлан хэрэглэгдэж эхэлсэн. Эрх зүйт төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах, түүнийг аливаа хууль бус, дур зоргоор авирлах, хүчирхийллээс тууштай хамгаалах үүднээс эрх зүйн ноёрхлыг дээдэлдэг, түүнд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг орчин үеийн ардчилсан төрийн сонгодог хэлбэр бөгөөд төрт ёсны хөгжлийн гол загвар болж байгаа билээ.[31]

Төр нь сонгодог утгаараа ард түмний санаа бодол хүсэл зоригийг илэрхийлсэн олон түмэнд үйлчилдэг үйлчилгээний байгууллага бөгөөд иргэнд үйлчлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчид гол үүргийг гүйцэтгэдэг. Энэ утгаараа төр ба иргэний харилцааны нэг чухал асуудал нь төрийн үйлчилгээг эрхэлж буй төрийн албан хаагчдын ёс зүйн байдал болно. Нийтийн ашиг сонирхолыг төлөөлж ажилладаг, төрийн ажлыг залгуулдаг хэн боловч тогтсон дэг жаяг, дүрэм журам, хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч иржээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн ашиг сонирхолын асуудлаар Аристотель "Төрийн засаглалыг ёс зүй, улс төрийн хувьд шалгарсан мэргэжлийн хүмүүс хэрэгжүүлнэ" гэж бичиж байсан байна. Харин манай монголчууд үе үеийн тэргүүний сэхээтнүүд, шашны нэрт зүтгэлтнүүд эзэн Чингис хааны үеэс эхлэн төрийн албаны дэг жаяг, ёс журмыг дээдлэн баримтлаж ирснээ тухайн үеийн хууль цааз болон судар бичигт тэмдэглэж үлдээжээ. Чингис

[31] Google!.mn. Эрх чөлөөний төлөөх эхний алхам эрх зүйт төр. С.Мөнхсайхан.УБ хот. 2010 он

хаан төрийн түшээ нараа жил бүрийн эхэн ба эцэст хааны ордонд авчирч сургааль сонсгодог байжээ. Энэ тухай "Аливаа үйлчингээс, аялгуут билэгт хүн хэрэгтэй, түм түмэн хүнээс төр ёс мэдэх хүн дээр буй" хэмээн бичсэн байна.

1913-1918 онд Богд Жавзандамба зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг-т /7,8-р дэвтэрт/. Төрийн түшмэдийн албан ямар байх, учиртай хийгээд, хэрхэн сонгон авах, эрдэм сахилга ямар түвшинд байх ёстойг заасан байдаг. Ийнхүү Монголчууд эрт үеэс төрд зүтгэх төрийн түшээдийг төлөвшүүлэх бодлогыг явуулж ирсээр нийгмийн шаардлага хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөн хөгжүүлсээр өнөө цагтай золгосон түүхтэй.

1990 оноос эрх зүйт төр, ардчилсан нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төрийн албанд ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх шаардлага гарсан байна.

Монгол улсын шинэ үндсэн хууль, төрийн албаны тухай хууль батлагдсанаар ардчилсан эрх зүйт төрийн тогтолцоо, төр иргэний харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлж, төрийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, 1996 онд төрөөс "Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого" гэсэн баримт бичгийг баталснаар иргэнд төрийн үйлчилгээг хүргэдэг, төрийн албаны шинэчлэлтийн үйл явц эхэлсэн байна.

"Этик" буюу ёс зүй нь тухайн орчинд хүмүүст ёс суртахууны шаардлагыг илэрхийлж буй ойлголт бөгөөд сайн муу, шударга, шударга бус, зөв буруугийн тухай үзэл баримтлалд үндэслэгдсэн зан төлөвийн журам юм.

Хүмүүс өдөр тутмынхаа ажил амьдралд эрх зүйн төдийгүй ёс суртахууны хэм хэмжээг мөрдлөгө болгодог. Юуг хийж болох хийгээд юуг хийж болохгүй, ямар зүйл нь сайн ямар зүйл нь муу, юманд хэрхэн хандах тухай хүн бүр анхаасаа эхлэн олж авч, тэр нь гэр бүл, орчин ахуй, ажил амьдралд илрэлээ олж, нийгмийн амьдралд заавал мөрдөх шинжтэй зан байдлын журам болон бэхждэг байна.

Энэхүү журмыг ёсчлон мөрдөх нь амьдралд өөрийгөө зөв авч явахын үндэс болдог.

Ардчилал, эрх чөлөө, эрх зүйт ёсны талаар ярилцаад багагүй

хугацааг өнгөрсөн ч хөндөж хэлэлцэх ёстой асуудлууд өөрийн дарааллаа хүлээсээр байгаагийн нэг нь хуульчийн ёс зүйн асуудал билээ.

Өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилт нь хангалтгүй байгаагаас сүүлийн үед тус байгууллагын ажилтны ёс зүйн доголдол их гарч үүнээс болж манай байгууллагын үнэт зүйлсийг бүхэлд нь үгүйсгэх, ШШГБ-ын тогтолцоо болон хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үл итгэх байдал газар авсаар байгаа нь сэтгэл эмзэглүүлэм зүйл болоод байна. Энэ нь нэг талаас албан хаагчдын үзэл бодлоо илэрхийлэх нь зүй ёсны боловч, нөгөө талаас асуудлыг хууль ёс, журмын дагуу шийдвэрлэх бус харин шаардлага, хүчирхийллийн замаар хэрэгжүүлэхийг оролдож байгаа нь алба хаагчдын удирдлагын эрх мэдэлд итгэх итгэл алдарснаар илэрхийлэгдэж байгаа юм. Тиймээс миний илтгэл өнөө үеийн ардчилсан эрхзүйт төрт ёсны үүднээс шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн асуудлыг байх ёстой хийгээд байгаа байдлын арга зүйн хүрээнд хөндөж өөрийн санал дүгнэлтээ илэрхийлж байна.

Аливаа мэргэжил ёс зүйн өвөрмөц шаардлагыг өөртөө бий болгодог ба, өөрийн ёс зүйтэй байна. Мэргэжлийн онцлогоос шалтгаалж ёс зүйн шаардлага нь урган гардаг. Хуульч хүн төрийг төлөөлж иргэдтэй харьцдаг, хуулийг хэрэгжүүлж, зөрчсөн тохиолдолд шийтгэл хүлээлгэх, хуулийн биелэлтийг хянах зэрэг мэргэжлийн онцлог байдлууд нь хуульчийн ёс зүйн өвөрмөц шинжийг илэрхийлж байдгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн шаардлагууд болдог.[32]

Тухайлбал: Мэргэжлийн ёс зүй буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйд ёс суртахууны дараахь шаардлагууд тавигддаг. Төр, ард түмний төлөө үйлсэд шударгаар зүтгэх, хүний эрх, эрх чөлөөг хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хүмүүс, иргэдэд үнэн сэтгэлээсээ үйлчлэн туслах, аливаа байгууллага, албан тушаалтан эрхээ зөв эдэлж, үүргээ бүрэн биелүүлэхэд эрх зүйн бүхий л арга хэрэгслээр үйлчлэх, мэргэшлийн бүхий л туслалцааг үзүүлэх, нийгэм иргэдэд сөрөг аливаа хууль бус үйлдлийг үл тэвчих, хууль ёсыг зөрчих явдлаас сэргийлж, гарах шалтгаан нөхцлийг нь арилгах, авилга авах, албан тушаал, мэргэжлээ

[32] Х.Тэмүүжин "Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл", "Хуульчийн ёс зүн гарын авлага" 2004 он УБ 9 дэх тал

урвуулан ашиглах, сэжигтэн яллагдагч, ялтантай хувийн харьцаа тогтоох, өөрт ашигтай зүйлийг биелүүлхийг эдгээр хүмүүсээс шаардах, ямар нэгэн байдлаар ялгамжтай хандах, танил тал харах, тал тохой татах, төр иргэн байгууллагын нууцыг задруулах, бодит байдлыг хэтрүүлэх, иргэдэд үл тоомсорлосон сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл хийх, хүнд суртал гарган чирэгдүүлэх санал хүсэлт, өргөдөл гомдлыг нь шалтгаангүйгээр хугацаа алдуулах, шийдвэрлэхээс зайлсхийх, хуулиар далайлган айлган сүрдүүлэх, бүдүүлэг харилцах заналхийлэх зэрэг зүй зохисгүй байдал гаргахыг цээрлэх ёстой.

Хэдийгээр тус байгууллагын ажилтнууд нэг талаас өөрсдийн үйл ажиллагааны үндсэн үүргийг ухаарч ёс зүйн үнэт зүйлсийг итгэл үнэмшил болгон баримтлах нь тэдний соёлын асуудал боловч, нөгөө талаас энэ эрх мэдлээ ашиглан өөрсөддөө давуу байдал бий болгож, үүнийгээ зүй бусаар ашиглахаас хамгаалж хянах нь бусад иргэд, албан хаагчдаас тавигдаж буй шаардлага байдаг. Энэ дотоод болоод гадаад ёс зүйн хэм хэмжээнээс шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн шаардлага болон урган гардаг. Өнөө үед шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн шаардлагыг мэргэжлийн төрлөөс үл хамааран авч үзвэл а/ үйлчлүүлэгчдээс тавигдах ёс зүйн хэм хэмжээ /үйлчлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах, итгэл даахтай холбогдсон асуудал/, б/ мэргэжлийн зүгээс тавигдах ёс зүйн хэм хэмжээ /шийдвэр гүйцэтгэх байгууллагаас албан хаагч, ажилтнуудад тавигдах ёс зүйн шаардлага/ гэж ангилан үзэж болохоор байна.

а/Үйлчлүүлэгчдээставигдахёсзүйнхэмхэмжээгэдэгньшүүхийншийдвэр гүйцэтгэх байгууллагаар дамжуулан эрх зүйн асуудлаа шийдвэрлүүлж буй иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас албан хаагчдад тавьж буй ёс зүйн шаардлагууд багтдаг. Тухайлбал: аливаа асуудлыг албан тушаалтан нь хуулийн дагуу зөв шударгаар явуулах ёстой. Үүнийг тодорхой болгохын тулд нэг жишээ татъя. Шинээр ажилд орох хүсэлт гаргасан иргэн, ажилтныг шилжүүлэх, томилох, сургахад ялгамжтай ханддаг, энэ байдлаа зүгээр л хууль, журмаа хэрэглэсэн, байгууллагын бодлого гэж өөрсдийгөө зөвтгөх шударга бус байдлыг таслан зогсоохын төлөө эрх мэдлээ ашиглах боломж байсан ч үүнийг хүсээгүй бөгөөд түүнд хувийн байдал нь нөлөөлсөн. Тиймээс өнөөдөр Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ёс зүйд зайлшгүй байх

ёстой хэм хэмжээ бол шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх мэдэлд орж болох удирдах ажилтны хувийн сэдлийг хаах боломжтой хэм хэмжээнүүд юм. Тухайлбал: Манай "Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 4.2.3-д шударга, энэрэнгүй байх, 5.5.1-д албан тушаалаа хувийн сонирхлоор ашиглах, 5.5.4-д аливаа хэлбэрээр танил тал харах, бусдад давуу байдал олгох зэрэг хязгаарлалтууд нь үүний нэг тод илрэл юм.[33]

-Мэдлэггүй, чадваргүй байдлаасаа чөлөөлөгдөх.[34] Асуудал тавьж байгаа талаас гаргаж байгаа шаардлага бол тухайн албан тушаалтан нь асуудлыг шийдвэрлэх, туршлага мэдлэгтэй, ур чадвартай байх, албан тушаалтан нь хуулийн хэм хэмжээ, түүний цаана агуулагдах үзэл баримтлал үнэт зүйлсийг нээн илрүүлэх онолын мэдлэгтэй байж, түүнийгээ тодорхой асуудал шийдвэрлэхэд хэрэглэх чадвартай байх нь албан тушаалтны шийдвэр үндэслэлтэй байж, асуудал тавьж буй талуудад хүлээн зөвшөөрөгдөх урьдчилсан нөхцөл болдог байна. Тиймээс амьдралын туршлага, хууль зүйн болон, харилцааны мэдлэгээ байнга хөгжүүлэх нь тухайн албан тушаалтны соёл төдийгүй нэг чухал үүрэг байдаг. Энэ талаар шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэмд тусгасан байна. Тухайлбал: 5.11-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь хариуцсан үүрэгт ажилдаа хариуцлагатай, мэргэшсэн, ажилдаа дур сонирхолтой, үнэнч шударга, сахилга дэг журмыг сахидаг, хувийн зохион байгуулалт сайтай, зан харьцааны хувьд доголдолгүй байна хэмээн заасан байна.[35]

б/ ШШГБ-ын ажилтны мэргэжлийн зүгээс тавигдах ёс зүйн хэм хэмжээ гэдэгт ажил үүргээ явуулахад баримтлах ёс зүйн хэм хэмжээний шаардлагууд ордог. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ажлын үндсэн талбар нь ял эдлүүлэх ажиллагаа байдаг. Энд хуулийг хэрэгжүүлж буй төрийн төлөөлөгчийн ашиг сонирхлыг, ял эдэлж буй ялтны нийтлэг ашиг сонирхлыг тус тус хамгаалан ажилтан хөндлөнгийн байр сууринаас эрх зүйд тулгуурлан асуудлыг шийдвэрлэдэг. Энэхүү энгийн юм шиг боловч нарийн төвөгтэй үйл ажиллагаануудаас хууль хэрэгжих байдал биелэлээ олж, шударга байдал бий болж байдаг. Тиймээс шийдвэр гүйцэтгэх

[33] "Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм" 2008 он УБ хот

[34] М.Батсуурь "Хууль дээдлэх ёс" 2006 он 81дэх тал

[35] Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл 2011 он УБ хот

байгууллагын ажилтны ёс зүйг түүний ажил үүргийн үйл ажиллагаанаас гадуур үнэлэх нь утгагүй юм. Энэ талаархи үзэл санаа нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийн 5.5.3-д албан тушаалараа түрүү барин бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, сүрдүүлэх, 5.5.5-д бусдад бүдүүлэг зан авир гаргах, 5.12.2-д ялтан, хоригдогч этгээдтэй найз нөхдийн болон бусад хэлбэрээр ойр дотно холбоо тогтоох, тэдэнд ялгавартай хандах, давуу байдал олгох, 5.12.7-д ялтан, хоригдогч этгээдийн нэр төрийг гутаан доромжлох, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бие махбодид нь хүч хэрэглэх гэж тусгасан байна. Мөн мэргэжлийн нэр хүнд ШШГБ-аас тавигдах ёс зүйн хэм хэмжээ гэдэгт тухайн ажилтан ажиллаж буй байгууллагаас өөрийн байгууллагын нэр хүнд, түүнд хандах иргэдийн итгэлийг хамгаалах зорилгоор тавигдаж буй ёс зүйн шаардлагуудыг багтаан ойлгоно. Энэ нь ёс зүйн дүрмийн 5.1-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь нийтээр хүлээн зөвшөөрөн даган мөрдөж буй ёс зүйн хэм хэмжээг бусдад үлгэрлэн чанд сахин ажиллана, 5.4-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ажилтны нэр хүндийг өндөрт өргөн ажиллах үүрэг хүлээнэ гэж бататгасан байна. Эдгээр ёс зүйн шаардлагуудыг зөрчвөл Шүүхийн шийдвэр гүйццэтгэх тухай Монгол улсын хуулийн 136-р зүйлд зааснаар сануулах, сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах, цол бууруулах буюу хураан авах, ажлаас халах сахилгын шийтгэлийг оногдуулахаар заасан байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь толинд харагдаж байгаа мэт ялтан, хоригдогсдын болон иргэдийн нүдэнд ил тод байдаг тул өөрийгөө хянаж, биеэ зөв авч явах шаардлагатай байдаг. Зөвхөн хуулийг хэрэгжүүлэгч төдийгүй төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнд багтдаг тусгай мэргэжлийн хүмүүс тул албан тушаалтны хувьд ёс зүйн шаардлагыг нэгэн адил биелүүлэх учиртай.

ШШГБ-ын ажилтан нь ёс зүйн талаар ямар нэгэн доголдолтой байх нь ажил үүргээ биелүүлэхэд сөргөөр нөлөөлдгийг амьдрал нэгэнт харуулж байна. Иймд ажил мэргэжилдээ сайн ажилтан байхын зэрэгцээ, ёс суртахууны хувьд төлөвшсөн ажил амьдралд байр сууриа олсон байх явдал нь чухал юм.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйд ажлын онцлогтой нь уялдуулан ёс зүйн анхаарвал зохих зарим асуудлыг авч үзэх нь зүйтэй юм.

Тогтоол гүйцэтгэх газрын ажилтан нь юуны өмнө Шүүхийн шийдвэр гүйццэтгэх тухай Монгол улсын хуулийн заалт, тэдгээртэй холбогдуулан гаргасан заавар журмыг нэгбүрчлэн нарийвчлан судалж хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Тогтоол гүйцэтгэх газрын ажилтан нь нэг талаас эрх зүйн мэдлэг хуульч ажиллагаа, сонор сэрэмж, харилцааны эв дүй, хүнлэг энэрэнгүй чанар, нөгөө талаас ялтны тухайн дэглэмийн шаардлагыг хангаж, нийгэмших явдалд нь дэмжлэг туслалцаа үзүүлдэг ч, ялтан бүр алдсанаа ухаарч, гэм буруугаа ойлгосон байдаггүй бөгөөд, зан харьцааны доголдолтой, хүнийг элдвээр гоочилж, өөрийн дарамтанд оруулах, хорих ангийн дүрэм журамд захирагдахгүй, дураараа байх хүсэл эрмэлзэлтэй сөрөг хандлагатай нэгэн хэсэг байдаг зэрэг тус байгууллагын ажлын хүнд нөхцлийг даван туулах мэргэжлийн, сэтгэл зүйн өндөр мэдлэг чадвартай байж, хуулийн хүрээнд ажиллаж хүнд алдсан алдаагаа засах боломж байдгийг ухааруулж, зөв алхам бүрийг нь дэмжин, сайшаан урамшуулж ажиллахын зэрэгцээ, ялтан түүний садан төрөлтэй хувийн харьцаа тогтоохоос сэргийлж, харилцааны зөв хэм хэмжээг сахин ёс зүйн зөрчлөөс сэргийлж байх шаардлагатай.

Нөхцөл байдал хэдий чинээ хүнд бэрх байна төдий чинээ хатуу чанга чанар, шийдэмгий зоримог шийдэл хэрэгтэй. "Сайн ёс зүй нь сайн хуулиас илүү ач холбогдолтой" гэх үг бий.[36]

Төрийн тусгай энэ албыг хэн нэг нь гүйцэтгэх нь тодорхой бөгөөд амжилттай гүйцэтгэснийг Шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүх гэрчилдэг. Хорих байгууллагын ажилтан нь хорих ангийн дэглэмийн онцлогоос шалтгаалан ажлын нөхцөл нь хүндэрч сэтгэл зүйн дарамт ихтэй байдаг тул өөрийнхөө мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хүнтэй ажиллах, харьцах хандлагыг цаг үеийн шаардлагын хэмжээнд бий болгож, уужуу тайван, ухаалаг чанарыг өөртөө төлөвшүүлэх хэрэгтэй.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь өөрийгөө болон алба,

[36] Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Багабанди "Нэр алдраас илүү хүн чанарын тухай бод" news.zindaa.mn 2010 он. УБ хот

ажлын нэр төрийг эрхэмлэн албандаа хүндэтгэлтэй хандаж, олон нийт, хорих байгууллагад ажиллагсдад таатай бус ханддаг зарим хандлагыг сэтгэлийн хат, ажлын амжилтаар даван туулж, эерэг хандлагыг бий болгох чадвартай байх хэрэгтэй. Бодит байдалд урьд өмнө ч, одоо ч үнэндээ ял эдэлж байгаа эндсэн, эвдэрсэн хэнийг ч гэсэн хорих байгууллагын ажилтнаас өөр хэн ч өдөр тутам анхаарч, халамжилж, туслаж, дэмжиж байдаггүй бөгөөд төрөл төрөгсөд нь хуулийн хугацаанд уулзаж, зөвлөж, хэлж, ярилцан сэтгэлийн дэм өгдөг.

Амьдрал ахуйн бололцоо муугаас ял эдлэх хугацаанд нь төрөл төрөгсөд нь эргэж, уулзаж чадахгүй хий дэмий сэтгэл зовхоос цаашгүй хүмүүст сэтгэл санааны дэмжлэг өгч ажилладгаараа Хорих байгууллагын ажилтнууд албандаа бахархалтай хандах хэрэгтэй ч, зарим нэгэн ажилтан танил тал харах, ялтантай хувийн харьцаа тогтоож байгаа нь өөрийн хэнэггүй байдал, ажил албандаа хүндэтгэлтэй бус хандаж байгаагийн илрэл юм гэж дүгнэж байна.[37]

2012 оны 08 дугаар сард Зүүнхараа, Дарьт дахь хорих ангиудаас тохиолдлын журмаар Хорих байгууллагын ажилтнуудын ёс зүйн талаар сонгон авч ярилцсан 100 хүний дунд хийсэн судалгаагаар дараахь дүр зураг харагдаж байна.

Хорих байгууллагын албан хаагчдын ёс зүйн үнэлэмж					
Зүүнхараа дахь Хорих анги	Сэтгэл бүрэн ханамжтай	Заримдаа ханамжтай	Ханамжгүй	Хариулаагүй	Бүгд
	29	33	16	22	100
Дарьт дахь Хорих анги	26	28	20	26	100

[37] Ш.Дуламсүрэн "Хуульчийн мэргэжлийн ёс зүй" 2007 он. УБ хот 151 дэх тал

Хорих байгууллагын албан хаагчидаас иргэдэд үйлчилж байгаа байдлыг хэрхэн төсөөлж байна вэ?

Хорих байгууллагын үйл ажиллагаа				
	Бүрэн нийцэж байна	Бараг нийцэхгүй байна.	Хариулахгүй буюу, мэдэхгүй	Бүгд
Ойлгоход бэрхшээлтэй	41	34	25	100
Үйлчлүүлэхэд чирэгдэл ихтэй	36	48	16	100
Асуудал эцэслэн шийдвэрлэгддэггүй	12	25	63	100

Таны бодлоор доорхи хүмүүст хорих байгууллага хэрхэн хандах вэ?

	Илүү үйлчилдэг	Адилхан	Доогуур	Бүгд
Хөрөнгө мөнгөтэй хүмүүст	55	45	0	100
Албан тушаалтай хүмүүст	63	37	0	100
Хамаатан садан, танил талдаа	26	65	9	100

Доорхи дүгнэлтүүдээс санал нийцэж байгааг тэмдэглэнэ үү? /хувь/

	Бүрэн нийцэж байна	Бараг нийцэхгүй байна.	Хариулахгүй буюу, мэдэхгүй	Бүгд
Эрх бүхий албан тушаалтны шийдвэрт удирдагын нөлөө их байдаг.	36	34	30	100
Эрх бүхий албан тушаалтны шийдвэрт хувийн сонирхол их байдаг.	76	13	11	100

Асуудлыг цаг хугацаандаа шийддэггүй, удаашруулдаг.	46	21	23	100
Хорих байгууллагын ажилтнууд тусархуу, элдэг зантай.	36	40	24	100

Эдгээр судалгааны үр дүнгүүд нь албан хаагчдын дунд явуулсан судалгаагаар нотлогдож байгаа юм. Тухайлбал: 2008 оноос хойш мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрмийн дагуу ШШГБ-ын ажилтнуудад ялтантай хувийн харьцаа тогтоосон 1, согтууруулах ундаа хэрэглэсэн 23, холбогдох хууль зөрчсөн 4, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн 4 гарсан байгаа нь дээрхи хандлага нь оргүй зүйл биш гэдгийг илтгэж байна. Түүгээр ч барахгүй албан хаагчид өөрсдөө ч энэ байдлаа хүлээн зөвшөөрдөг. 90 орчим албан хаагчдаас хорих байгууллагын ажилтанд өнөө үед дутагдаж байгаа чанарын талаар асуулга явуулахад а/ мэргэшсэн чанар дутагдалтай 23,0%, б/ мэргэжлийн ёс зүй дутагдалтай 31,0 в/ харилцааны ур чадвар дутагдалтай 60,0.%, сонирхлын зөрчилд автамтгай 14,0%, гэсэн хариулт өгсөн байна.

Дээрхи байдлуудаас дүгнэж үзвэл ШШГБ-н ажилтны ёс зүйн хүрээнд аливаа асуудлыг шийдвэрлэхэд ур чадвар, мэргэшсэн чадвар дутагдалтай, сонирхлын зөрчлөөс чөлөөлөгдөөгүй, биеэ авч явах болон харилцааны соёл дутмаг гэсэн нийтлэг зөрчил харагдаж байна.

Хэдийгээр ёс зүйн талаар хууль журамд тусгасан боловч бодит байдал дээр ёс зүйн хэрэгжилт нь хангалтгүй байгаа шалтгаан нь юу вэ? гэсэн асуулт гарч байна. Энэ нь ёс зүйн хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэр болон, иргэний зүгээс тавих хяналтыг зөв бүрдүүлээгүйтэй холбоотой юм.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйд тавих хяналтыг иргэний байгууллагад шилжүүлж болох эсэхийг хөндөх цаг нь болсон байна. Ингэж ажилтны ёс зүйн хяналтыг сайжруулснаар бид шударга үйл ажиллагаа явуулах, эрх бүхий албан тушаалтнаас шударга бус авир гаргахаас сэргийлж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.